ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ
2015-2022

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022

ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг*
*Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

# АГУУЛГА


**Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ ........ 2**

**Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ........ 3**

**"Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан"-ийн Хөрөнгө оруулагч "Оюу толгой" компани ........ 4-5**

**"Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-ийн бүтэц, зохион байгуулалт ........ 6-8**

Сангийн Удирдах зөвлөл ........ 6

Харилцааны хороо ........ 7-8

**Говийн Оюу хөгжлийг дэмжих санд хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл ........ 9-11**

Санхүүжилт олгох үндсэн чиглэл ........ 9

Санхүүжилт олгох үйл явц ........ 10

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн зорилтот хамрах нутаг дэвсгэр ........ 11

**Сангийн 2022 оны Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт ........ 12-20**

**"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн амжилт бүтээлийн он дараалал ........ 21**

**Ирээдүй хойч үеийн төлөө сан ........ 22-23**

Говийн оюу-Бизнес боломж" бизнесийн бичил зээл ........ 22-24

Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж ........ 25

"Говийн Оюу-Оюутны тэтгэлэг" хөтөлбөр ........ 25-31

**Хандив тусламж ........ 32-33**

**Сангийн 2022 оны онцлох үйл явдал ........ 34-36**

**Санхүүжилтийн гүйцэтгэл-2022 он, санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт ........ 37-89**

Санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд ........ 37-39

Удирдах зөвлөлөөс Сангийн 2022 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт ........ 40-44

Сангаас батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт ........ 45-89

*2022 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт ........ 45-71*

*Он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд ........ 72-89*

**Санхүүжилтийн квот, 2022 оны квотын санхүүжилтээр хэрэгжих төсөл хөтөлбөр ........ 90-157**

Санхүүжилтийн квот, зорилго ........ 90

Манлай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 91-106

Баян-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 107-112

Даланзадгад суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 113-120

Баяндалай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 121-130

Мандал-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр 131-134

Сэврэй суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 135-138

Булган суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 139-144

Цогт-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 145-148

Номгон суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 149-154

Хүрмэн суманд хуваарилагдсан санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр ........ 155-166

**Сангийн ил тод байдал ........ 167**

**Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ ........ 168-175**

**Харилцагч байгууллагууд ........ 176-179**

**Санхүүгийн тайлан ........ 180-183**


*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг*
*Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

*“Оюу толгой” компанийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн дарга*

***Эндрью Уилсон***

*Та бүхэндээ “Оюу толгой” компанийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг уламжлал ёсоор хүргэж байгаадаа баяртай байна.*

*“Оюу толгой” ХХК нь Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г 2015 онд байгуулснаас хойш “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт маань 2022 онд өссөн дүнгээр 101.3 тэрбум төгрөгт хүрч, уг санхүүжилтээр нийт 353 төсөл, хөтөлбөр санхүүжүүлжээ.*

*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь өнгөрсөн онд орон нутгийн иргэд, нутгийн захиргааны байгууллагын санаачилгад тулгуурлан “Бэлчээр усжуулалтын II аян-2022”, “Ханбогд сумын төвийн цэвэр бохир шугамын угсралтын ажил”, “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах төсөл” зэрэг томоохон 12 төсөл, Өмнөговь аймгийн 12 сумдад олгосон санхүүжилтийн квотоор тухайн сумын иргэд байгууллагын санаачилсан 39 төсөл хөтөлбөрт санхүүжилт олголоо.*

***“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг”** хөтөлбөрт 2022 онд 81 оюутан хамрагдсан бол өссөн дүнгээр Өмнөговь аймагт нэн хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж буй 405 оюутанд 1 тэрбум төгрөгийн сургалтын бүрэн тэтгэлгийг уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд олгосон байна. **“Говийн Оюу-Бизнес боломж”** бичил зээлийн хөтөлбөрийн хүрээнд 59 бизнес эрхлэгчдэд 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ХААН банкаар дамжуулан олгож цөөнгүй бизнес эрхлэгчид бизнесээ өргөтгөх, шинээр бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүллээ.*

*Соёлын өвийг хамгаалах, түүх соёлын уламжлалыг хадгалахад чиглэсэн овоо тахилга, тэмээний уралдаан, наадам зэрэг үйл ажиллагаанд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” -аас нийтдээ 917.9 сая гаруй төгрөгийн хандив 2022 онд олгосноос 800,0 сая төгрөг нь говь нутгийн малчин түмнээ өвлийг өнтэй давахад зориулан өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зориулагдлаа.*

*Товчлон дүгнэвээс 2022 он “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хувьд дэлхий даяар сүүлийн хоёр жил дамнан хүндрэл бэрхшээл дагуулсан цар тахлын үед удааширсан олон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж алдагдсан цаг хугацааг нөхөж ажилласан, сангаас санхүүжүүлж бүрэн тохижуулан ашиглалтад оруулсан “Өмнөговийн байгаль түүхийн музей”-н барилга Монгол Улсын шилдэг барилгаар шалгарсан, Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж гэрээний талууд цаашдын зорилтоо тодорхойлсон зэрэг үр бүтээлтэй жил байлаа.*

*Сангийн хөрөнгө оруулагч “Оюу толгой компани”-н хувьд 2023 оны нэрдүгээр улиралд багтаан гүний уурхайн олборлолтоо эхлүүлэх боломж бүрдүүлсэн их бүтээн байгуулалтын жил байлаа.*

*Өмнийн цэнхэр говьдоо дэлхийн хэмжээний бүтээн байгуулалт хийж, уг бүтээн байгуулалт, уурхайн үйл ажиллагаагаар бий болсон баялгийг нийгмийн сайн сайхны төлөө зориулагдсан төсөл хөтөлбөрийн байдлаар санхүүжүүлэн хүргэж ажиллаж буй бидний ажлыг дэмжиж хамтран ажилласан бүх байгууллага, хүмүүст гүн талархал илэрхийлж ажлын амжилт хүсье!*

# ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

2015 оны 04 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Оюу толгой” компани нь **“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”** Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу Толгой” компани нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан Хамтын ажиллагааны гэрээний дагуу орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн ажиллаж байна.

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”



### АЛСЫН ХАРАА

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- *Авилгаас ангид байх*
- *Хувийн ашиг сонирхлоос ангид байх*
- *Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах*
- *Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах*
- *Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх*
- *Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх*

### ЭРХЭМ ЗОРИЛГО

*Өмнөговьчуудын сайн сайхан амьдралыг дэмжсэн хамтын хөгжлийн санаачилгыг санхүүжүүлэгч сан байна*

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ТАЛААР

“Оюу толгой” ХХК бол “Рио Тинто” компани (66 хувь) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34 хувь)-ийн хувь нийлүүлсэн Монгол Улсын хамгийн том зэс, алтны компани юм. Уурхайн цогцолбор Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 километр, Монгол-Хятадын хилээс хойш 80 орчим километрт оршдог.

Олон арван жилийн хайгуулын үр дүнд Оюу толгойн ордыг 2001 онд нээн илрүүлж, улмаар 2013 онд анхны зэсийн баяжмалаа экспортод гаргасан билээ. Уурхайн ашиглалтын хувьд ил уурхайгаас хүдэр олборлож, хоногт 100,000 тонн хүдэр баяжуулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, дагалдах байгууламж, дэд бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн Оюу толгойг дэлхийн хамгийн том зэсийн уурхайн нэг болгох гүний уурхайн бүтээн байгуулалт амжилттай урагшилж буй. Тус компани үйлдвэрлэсэн зэс, алтны агуулгатай баяжмалаа олон улсын зах зээлд борлуулдаг.

2022 оны эцсийн байдлаар Оюу толгойн нийт ажиллах хүчний 97 хувь нь монголчууд бөгөөд тэдний 21 орчим хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлжээ. “Оюу толгой” компани ажиллах хүчнийхээ эрүүл мэнд хийгээд хөдөлмөрийн аюулгүй байдалд эн тэргүүний ач холбогдол өгдөг бөгөөд Рио Тинто группийн хэмжээнд хамгийн аюулгүй уурхайн нэгд тооцогддог.

“Оюу толгой”-н Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч талуудын төлөөллөөс бүрдэх бөгөөд компанийн стратегийн чиглэлийн дагуу шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ. Харин уул уурхайн бизнесийн бүхий л чиглэлээр мэргэшсэн Гүйцэтгэх удирдлагын баг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, стратегийн бодлогыг хэрэгжүүлдэг.

“Оюу толгой” компани нь 2015 оны 4 дүгээр сарын 22-нд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулагч “Рио Тинто” компанийн олон улсад мөрддөг стандарт журмын дагуу уурхайн үйл ажиллагаа явагдаж буй Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан. Энэ нь аймаг төдийгүй Монгол Улсын хэмжээнд уул уурхайн компани нутгийн захиргааны байгууллагатай иж бүрэн хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж буй анхны жишээ юм.

## АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ



## ҮНЭТ ЗҮЙЛС

- Аюулгүй ажиллагаа
- Хамтын зүтгэл
- Хүндэтгэл
- Ёс зүй
- Төгөлдөршил



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах












# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дүрмийн 8-д зааснаар сангийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.

**Удирдах зөвлөлийн гишүүнчлэл**

8.2 “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь дараах 7 гишүүнээс бүрдэнэ:

a) Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж “Оюу толгой” ХХК-д бичгээр мэдэгдэн томилсон Удирдах зөвлөлийн гурван гишүүн (тус бүрийг нь Удирдах зөвлөлийн орон нутгийн гишүүн гэх)

b) “Оюу толгой” ХХК-аас нэр дэвшүүлж Өмнөговь аймаг болон Ханбогд суманд бичгээр мэдэгдэн томилсон Удирдах зөвлөлийн дөрвөн гишүүн (тус бүрийг нь Удирдах зөвлөлийн “Оюутолгой”-ийн гишүүн гэх)

***“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дүрмээс***

*Гэрээний талууд Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн Дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах, хөндлөнгийн хяналт тавих эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх сонгогдон ажиллаж байгаа.*

## САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД-2022 ОН



Удирдах зөвлөлийн дарга/ “Оюу Толгой”-н Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал

**Эндрью Уилсон**



Удирдах зөвлөлийн гишүүн/ Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга

**Б.Бадраа**



Удирдах зөвлөлийн гишүүн/ Өмнөговь аймгийн Засаг дарга

**Р.Сэддорж**



Удирдах зөвлөлийн гишүүн / Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч

**Ж.Занабазар**



Удирдах зөвлөлийн гишүүн / “Оюу Толгой”-н Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал

**Д.Амарбаясгалан**



Удирдах зөвлөлийн гишүүн / “Оюу Толгой”-н Хангамжийн хэлтсийн Ерөнхий менежер

**Мелисса Шаненганге**



Удирдах зөвлөлийн гишүүн / “Оюу Толгой”-н Орон нутгийн харилцааны Ерөнхий менежер

**Г.Сугар**

# ХАРИЛЦААНЫ ХОРОО

Харилцааны хороо нь Өмнөговь аймаг, "Оюутолгой" ХХК болон хамтран ажиллах орон нутаг дахь түншлэгч сумдын хоорондын аливаа хамтын ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Энэ нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төлөөлөгчид болон "Оюу толгой" ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан ахлах менежерүүд Оюу толгой төслийн үйл ажиллагаанаас Өмнөговь аймаг болон түншлэгч сумдад тулгарч буй өнгөрсөн, одоо болон ирээдүйн нөлөөллийг хэлэлцэж, дүгнэх зорилгоор хоорондоо тогтмол уулзана. Уулзалт нь дараах үндсэн хоёр зорилготой байна.

a) Орон нутгийн оролцоо шаардсан аливаа үүрэг, амлалтын талаар олон талыг хамарсан, ил тод хэлэлцүүлэг өрнүүлэх

b) Хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналын талаарх баримтуудыг хянан хэлэлцэж, түүний хэрэгжих боломж, дарааллын талаар Хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтийн шалгуур, ялангуяа засаг захиргааны бодлого, төлөвлөлт, "Оюу толгой" төслийн урт хугацааны хөгжлийн чиглэл болон талуудын урт хугацааны тогтвортой хөгжлийн талаарх нэгдсэн алсын төсөөллийг харгалзан үзэж, Хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх.

***(Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 2-оос)***

# ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД-2022 ОН

## ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ДАРГА НАР



**Ч.Баяржаргал**
*Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч*



**О.Цэрэннадмид**
*"Оюу толгой" компанийн Орон нутгийн харилцааны менежер*

## ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД



**Ц.Амартөгс**
*Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын дарга*



**О.Эрдэнэ-Өрнөх**
*Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга*



**Ц.Бадамцэрэн**
*Нийгмийн бодлогын хэлтсийн дарга*



**О.Мандахбаяр**
*Баян-Овоо сумын Засаг дарга*



**П.Баасанцогт**
*Манлай сумын Засаг дарга*



**Х.Нэхийт**
*Ханбогд сумын Засаг дарга*



**В.Мөнхбат**
*Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч*



**Б.Энхмөнх**
*Даланзадгад сумын иргэний төлөөлөл*



**Д.Амартүвшин**
*"Оюу толгой" компанийн Хангамж, худалдан авалтын газрын менежер*



**Б.Ууганбаяр**
*"Оюу толгой" компанийн байгаль орчны менежерийн үүрэг гүйцэтгэгч*



**Э.Ганхуяг**
*"Оюу толгой" компанийн Сургалт хариуцсан ахлах ажилтан*

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД: ТӨСӨЛ САНААЧЛАГЧ, “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”, ХАРИЛЦААНЫ ХОРОО, САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ 7 СЭДЭВЧИЛСЭН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЖ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.

## САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛҮҮД

### АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛ АВАХ ЧИГЛЭЛҮҮД

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛ АВАХ ЧИГЛЭЛҮҮД

- Нийгмийн дэд бүтэц & хөрөнгө оруулалтын төсөл
- Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол, ажил мэргэжил баримжаа олгох сургалт &ажил эрхлэлт)
- Усны менежмент
- Уламжлалт мал аж ахуй & бэлчээрийн менежмент
- Үндэсний түүх, соёл & аялал жуулчлал
- Байгаль орчны менежмент (нөхөн сэргээлт, био-тархалт, экологийн тэнцвэр)

### ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ- БИЗНЕСИЙН БИЧИЛ-ЗЭЭЛ

/Хаан банкаар дамжуулан жилийн 7,2% буюу сарын 0,6%-ийн хүүтэй 80-100 сая төгрөгийн бизнесийн хөнгөлөлттэй, бичил зээл олгож байна/

### ОРОН НУТГИЙН БИЗНЕС ХӨГЖИЛ & БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

## ХДС-ИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

### НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ

#### НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ

**Төслийн санал хүлээн авах**

- Өмнөговь аймгийн үндсэн чиглэлтэй уялдсан байна

**Нөхцөл байдлын шинжилгээ хийх**

- Санал ХДС-ийн бичиг баримтуудад нийцсэн байна

**Санхүүжилтийн шийдвэр гаргах**

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

**Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт**

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

#### ХДС-ИЙН 3 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛТЭЙ УЯЛДАН ХЭРЭГЖИХ ХӨТӨЛБӨР

- ХДС 3 жилийн үндсэн чиглэлээ боловсруулж батлуулна
- Жил бүр үндсэн чиглэлийн дагуу төсөл зарлаж санал хүлээн авна

**Санхүүжилтийн шийдвэр гаргах**

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

**Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт**

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

#### САНХҮҮЖИЛТИЙН КВОТ

- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас ХДС-д уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байгаа сумдын нэрсийг ирүүлсэн
- Санхүүжилтийн квотоор хийсэн ажлыг жил бүр дүгнэнэ
- Түншлэгч болон уул уурхайгүй сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулна

**Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт**

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ЗОРИЛТОТ ХАМРАХ НУТАГ ДЭВСГЭР




**Зорилтот газар**

1 Журмаар зохицуулсны дагуу санхүүжилтийн квотод хамрагдсан сумд

2 **Бусад сум** - Бүх сумдыг хамарсан төсөл, хандивт хамруулан санхүүжүүлэх

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2015-2022 ОНД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДАД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**МАНДАЛ-ОВОО**
**18 төсөл, 6 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **1 бичил зээл, 1 хандив,**
**1.6 тэрбум ₮/637.3 мянга $**

**БУЛГАН**
**19 төсөл, 15 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **2 хандив, 467.7 сая ₮/173.2 мянга $**

**СЭВРЭЙ**
**23 төсөл, 20 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **2 хандив, 467.7 сая ₮/173.9 мянга $**




**ГУРВАНТЭС**
**20 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор),
**51.2 сая ₮/18.6 мянга $**

**НОЁН**
**3 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор),
**5.9 сая ₮/2.3 мянга $**

**БАЯНДАЛАЙ**
**17 төсөл, 25 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **619.9 сая ₮/226.9 мянга $**




**ЦОГТ-ОВОО**
**20 төсөл, 13 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **1 хандив, 3.5 тэрбум ₮/1.2 сая $**

**ЦОГТЦЭЦИЙ**
**2022 оны санхүүжилтийн квотод хамрагдсан, 19 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **1 хандив, 165.2 сая ₮/57.9 мянга $**

**МАНЛАЙ**
**43 төсөл, 16 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **2 бичил зээл, 11 хандив, 3.7 тэрбум ₮/ 1.5 сая $**

**ХАНБОГД**
**61 төсөл, 18 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **9 бичил зээл, 19 хандив, 18.4 тэрбум ₮/ 7.3 сая $**

**БАЯН-ОВОО**
**24 төсөл, 11 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **1 бичил зээл, 8 хандив, 2.9 тэрбум ₮/ 1.2 сая $**

**НОМГОН**
**15 төсөл, 13 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **433.7 сая ₮/ 160.9 мянга $**

**ДАЛАНЗАДГАД**
**63 төсөл, 206 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **44 бичил зээл, 8 хандив, 42.6 тэрбум ₮/ 16.2 сая $**

**ХАНХОНГОР**
**11 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **1 хандив, 26.3 сая ₮/10.3 мянга $**

**ХҮРМЭН**
**12 төсөл, 9 оюутны тэтгэлэг** (давхардсан тоогоор), **275.7 сая ₮/ 98 мянга $**

- Өмнөговь аймгийн бүх сумыг хамарсан төсөл 28 төсөл, 39 хандив, 18.7 тэрбум ₮/ 6.9 сая $
- Өмнөговь аймгийн сумдыг хэсэгчлэн хамарсан 10 төсөл, 1.9 тэрбум ₮/ 808 мян $

## "ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"
# ӨМНӨГОВЬ АЙМАГТ 100 ГАРУЙ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРУУЛСАН



## САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

### САНГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ ДАВХАРДСАН ТООГООР 780,000 ХҮНД ХҮРСНЭЭС ЗОРИЛТОД БҮЛГИЙН ИРГЭД ДАРААХ БАЙДЛААР ХАМРАГДСАН БАЙНА.

**25,0** мянган малчин

**6** мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн




**25,0** мянган ахмад настан

**77,0** мянган залуучууд

**645** эмзэг бүлгийн иргэн

**146,0** мянган эмэгтэйчүүд

### Зорилтот үр шим хүртэгч




| | Хүүхэд | Эмэгтэйчүүд | Залуучууд | Малчин | Ахмад настан | Эмзэг Бүлгийн Иргэд | Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 | 3502 | 9357 | 92 | 1080 | | 205 | |
| 2021 | 11196 | 47522 | 40000 | 2829 | | | |
| 2020 | 26230 | 21560 | 4786 | | 1288 | 260 | |
| 2019 | 32574 | 53475 | 959 | 10763 | 12074 | 90 | 4313 |
| 2018 | 10592 | 13,181 | 1920 | 3040 | 77 | 90 | 1995 |
| 2017 | 7504 | 173 | 11514 | 531 | 12375 | | 300 |
| 2016 | 6486 | 1000 | 18450 | 6971 | 38 | | |
| 2015 | 593 | | | | | | |

ҮР ШИМ ХҮРТЭГЧИД ЯРЬЖ БАЙНА

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙН ДЭМЖИХ САН”-ДАА БАЯРЛАЛАА, ТАЛАРХЛАА

БИД ЭРҮҮЛ ШҮДТЭЙ БОЛЛОО







АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ САЙЖИРСАНД БАЯРТАЙ БАЙНА



АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАНГАГДЛАА



АЮУЛГҮЙ, АМАР АМГАЛАН АМЬДРАХ ОРЧИН БҮРДЛЭЭ





СТАНДАРТАД НИЙЦСЭН МАТЕРИАЛЛАГ БААЗТАЙ БОЛЛОО

ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАГДЛАА. СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙНА

*БОДИТОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ*
*ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН*

# "ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"-ИЙН 2015-2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## 101.27 ТЭРБУМ ₮
## 38.97 САЯ $



Харилцагч байгууллага
**+450**

Шинэ ажлын байр
**568**

27 төслийн хамтарсан санхүүжилт
**52 тэрбум ₮**

Үр шим хүртэгч
**+780,000**

Тэтгэлэгт оюутан
**405**

Бизнесийн хөнгөлөлттэй зээл
**59**

Санхүүжилтийн квот
**5.7 тэрбум ₮**

Төсөл хөтөлбөр
**353**

# НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД "ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"-ААС ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР




**9 ТЭРБУМ ₮**
**3.5 САЯ $**

### ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 3

- Чадавхжуулах сургалт
- Тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөр
- Иргэдэд мэдлэг, мэдээлэл өгөх сургалт

**2.5 ТЭРБУМ ₮**
**1.1 САЯ $**

### ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 4

- Сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж
- Сургалт, сургалтын хэрэглэгдэхүүн

**0.8 ТЭРБУМ ₮**
**313 МЯН. $**

### БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ - ЗОРИЛТ 6

- Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж
- Сумдад худаг гаргах ажил

**5.6 ТЭРБУМ ₮**
**2 САЯ $**

### ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 8

- Бизнес хөгжлийг дэмжих төсөл
- Хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлт

**60.7 ТЭРБУМ ₮**
**23.6 САЯ $**

### ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ - ЗОРИЛТ 9

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, музей, спорт заалны барилга

**2.3 ТЭРБУМ ₮**
**938.4 МЯН $**

### ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ - ЗОРИЛТ 11

- Сургалт, нөлөөллийн ажил
- Иргэдийн ая тухтай амьдрах орчинг сайжруулах тохижилт, үйлчилгээний ажил

**1.2 ТЭРБУМ ₮**
**505 МЯН $**

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БАГАСГАХ - ЗОРИЛТ 15

- Сумдад мод тарих
- Хог хаягдал менежмент

**34.2 САЯ ₮**
**17 МЯН $**

### ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ - ЗОРИЛТ 16

- Хүний наймааны хохирогч, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлсэн

**101.27 ТЭРБУМ ₮**
**38.97 САЯ $**

### ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БИЙ БОЛГОХ - ЗОРИЛТ 17

- 101.27 тэрбум ₮ буюу 38.97 сая $-ийн хөрөнгө оруулалт хийж 500 гаруй түнштэй болсон

# САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ- 2015-2022 (өссөн дүнгээр)

Оюу Толгой

"ОЮУТОЛГОЙ" ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2015-2022/

**101.27 ТЭРБУМ ₮/38.97 САЯ $**




**90.57 ТЭРБУМ ₮/**
**34.94 САЯ $**

**Төсөл хөтөлбөрийн санхүүжилт**




**5.2 ТЭРБУМ ₮/**
**1.97 САЯ $**

**Ирээдүй хойч үеийн төлөө сан**

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж




**2.3 ТЭРБУМ ₮/**
**0.86 САЯ $**

**Орон нутгийн хандив**




**3.2 ТЭРБУМ ₮/**
**1.2 САЯ $**

**Сангийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээлэл, бусад**

## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-аас 2015-2022 онуудад "Оюу толгой" компаниас жил бүр 5 сая ам.доллар хүлээн авч төсөл хөтөлбөрийн санхүүжилт, ирээдүй хойч үеийн төлөө сан (хөнгөлөлттэй зээл, оюутны тэтгэлэг, ирээдүй хойч үед зориулсан хадгаламж), орон нутгийн хандив, үйл ажиллагаа гэсэн 4 үндсэн чиглэлээр зарцуулан Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж ирсэн.

"Оюу толгой" компаниас 7 жилийн хугацаанд нийт 101.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хүлээн авснаас 89.45%-ийг буюу 90 гаруй тэрбум төгрөгийг томоохон хэмжээний 118, санхүүжилтийн квотын 235 буюу нийт 353 төсөл хөтөлбөр санхүүжүүлэхэд зориулсан. Тэдгээр нь бүгд нийгмийн шинж чанартай, олон нийтэд үр ашгаа өгөх төслүүд байсан бөгөөд Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум, "Оюу толгой" компани хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн 7 хавсралт болох нийгмийн дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээ, байгаль орчны менежмент, усны менежмент, уламжлалт мал аж ахуй бэлчээрийн менежмент, үндэсний түүх соёл, аялал жуулчлал, орон нутгийн бизнес хөгжил гэсэн чиглэлийн дагуу хэрэгжиж байна.

### “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2015-2022 ОНД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ НИЙГМИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ 353 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЖ 100 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРУУЛЛАА

- 6 цэцэрлэгийн барилга
- 2 сургуулийн барилга
- 3 сумын эрүүл мэндийн төвийн барилга, малын эрүүл мэндийн төвийн барилга
- 108 шинэ худаг, 44 худаг засвар
- 3 сумын уурын зуух, тогоо шинэчлэл, усаар үнс зайлуулах систем суурилуулалт
- Сургалт, судалгааны төсөл-35
- Мод үржүүлэг, усалгааны систем суурилуулалт-12
- Тохижилт, үйлчилгээ-43 төсөл
- 1 өвс тэжээлийн агуулах
- Бүрэн тохижуулсан 1 музейн барилга, музейн тохижилт-5 төсөл
- 2 удаагийн мал угаалга- Өмнөговь аймгийн 15,010 малчин өрх (давхардсан тоогоор)
- Ногооны хүлэмж-550 ширхэг
- 1 махны үйлдвэр, 1 цэвэр усны үйлдвэр, 1 арьс шир үйлдвэр
- Тоног төхөөрөмж нийлүүлэлт, тохижилт-162 төсөл
- Түүх соёлын дурсгалт зүйл хадгалалт, хамгаалалтын ажил-9
- 3.2 км цахилгааны шугам, шугамын өргөтгөл 1, дэд станц 2
- 6.5км ус зайлуулах шугам, 11.08 бохир усны шугам, 9.5 км цэвэр усны шугам
- 1 спорт заал

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН НИЙГМИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ , АМЖИЛТ БҮТЭЭЛИЙН ОН ДАРААЛАЛ

## 2015 — 4 ТЭРБУМ ₮


Өмнөговь аймаг, Ханбогд сум,“Оюу толгой” компани хооронд Хамтын ажиллагааны гэрээ байгуулав


Анхны хөрөнгө оруулалт- Даланзадгад сумын 25, 26-р цэцэрлэгийн барилга санхүүжүүлэв

## 2016 — 14 ТЭРБУМ ₮


Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилгыг санхүүжүүлэв


Даланзадгад сумын 2-р сургуулийн заалны барилга санхүүжүүлэв

## 2017 — 26 ТЭРБУМ ₮


Ханбогд сумын сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв


Ханбогд, Манлай сумын уурын зуухны барилга санхүүжүүлэв

## 2018 — 38 ТЭРБУМ ₮


Ханбогд сумын бүрэн тохижсон 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга санхүүжүүлэв


Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв


Өмнөговь аймгийн сумдад санхүүжилтийн квот олгож эхлэв

## 2019 — 51 ТЭРБУМ ₮


Өмнөговь аймгийн 15 сумын 5951 малчин өрхийн 2,5 сая толгой бог мал угааж сум бүрт суурин ванн барьсан


Манлай сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг санхүүжүүлэв

## 2020 — 66 ТЭРБУМ ₮


Ханбогд сумын өвс тэжээлийн агуулахыг барилга санхүүжүүлж ашиглалтад оруулав


Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын шав тавьж ажил эхлүүлэв

## 2021 — 82 ТЭРБУМ ₮


Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв


Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Монголын Барилгачдын холбооноос “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-г шилдэг хөрөнгө оруулагчаар өргөмжлөв

## 2022 — 101 ТЭРБУМ ₮


“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлсэн Өмнөговь аймгийн Говийн байгаль түүхийн музейн барилга Монгол улсын шилдэг барилгаар шалгарлаа


Ханбогд сумын төвийн 9.5 км цэвэр, 9 км бохир усны шугам угсралтын ажил санхүүжүүлж ашиглалтад оруулав

# “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжид заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 6%-ийг Өмнөговийн ирээдүй хойч үеийнхэнд зориулан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан” хэлбэрээр хуваарилдаг. Энэхүү хойч үедээ зориулсан санд хуваарилсан санхүүжилтийг:

- “Говийн оюу- Бизнес боломж” бизнесийн бичил зээлийн хөтөлбөр,
- Тусгай нөхцөлт Хадгаламж,
- “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” гэсэн үндсэн гурван хэлбэрээр хуваарилан зохих журмын дагуу зарцуулж байна.

## “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2016 оноос хойш “Говийн оюу-Бизнес боломж” нэртэй орон нутгийн жижиг бизнесийг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2022 онд Өмнөговь аймгийн **59** бизнес эрхлэгч иргэдэд **1.6 тэрбум төгрөгийн** зээл олгосон.

### Бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн мэдээлэл

| Сум | Зээлийн тоо | Олгосон зээл /өссөн дүнгээр/ |
|---|---|---|
| Даланзадгад | 46 | 1,370,974,300 |
| Баян-Овоо | 1 | 35,000,000 |
| Ханбогд | 9 | 171,000,000 |
| Манлай | 2 | 45,020,000 |
| Мандал-Овоо | 1 | 28,000,000 |
| **Нийт** | **59** | **1,649,994,300** |

“Говийн оюу-Бизнес боломж” бичил зээлийн хүрээнд 2016-2022 онд нийт 151 ажлын байр шинээр бий болгосноос **79** түр ажлын байр, **72** байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгохдоо 2018 оноос 2021 онуудад жилийн хүүг **12%** байхаар тогтоосон байсан буюу сард 1%-ийн хүүтэй 50 хүртэлх сая төгрөгийн зээл олгож байсан.

Харин 2022 онд Сангийн Удирдах зөвлөл хуралдаж хүүг бууруулах санаачилга гаргаснаар Хаан банктай тохиролцон жилийн хүүг **7.2%**, буюу сарын хүүг **0.6%** байхаар тогтоож хүүг бууруулж бизнесийн төрлөөс хамаарч 100 хүртэлх сая төгрөгийн зээл авах боломжтой болгосон.

## Хөнгөлөлттэй зээлийн хуучин нөхцөл

| Зээлийн төрөл | Зээлийн дээд хэмжээ | Хүү /жилийн/ | Хугацаа |
|---|---|---|---|
| Бизнесийн зээл | 50.0 сая хүртэл төгрөг | 12% | 60 хүртэл сар буюу хамтран ажиллах гэрээний дуусах хугацаанаас хэтрэхгүй байна |

## Хөнгөлөлттэй зээлийн шинэчлэгдсэн нөхцөл

| Зээлийн төрөл | Зээлийн дээд хэмжээ | Хүү /жилийн/ | Хугацаа |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх | 80.0 сая хүртэл төгрөг | 7.2% | 36 хүртэл сар буюу хамтран ажиллах гэрээний дуусах хугацаанаас хэтрэхгүй байна |
| Хөрөнгө оруулалтын зээл | 100.0 сая хүртэл төгрөг | 7.2% | 60 хүртэл сар буюу хамтран ажиллах гэрээний дуусах хугацаанаас хэтрэхгүй байна |

## 2016-2022 онд олгосон зээлийн зориулалтыг харуулсан тоон мэдээлэл

Олгосон бичил зээлийн зориулалт



# “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” ХӨНГӨЛӨЛТТЭЙ БИЧИЛ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН БИЗНЕСИЙН ЗЭЭЛ АВСАН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ДУРДВАЛ:

2022 онд “Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан Даланзадгад сумын бизнес эрхлэгчдээс: “Өмнөговь хөшиг”





Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зээл олгосон




2022 онд Даланзадгад сумын хагас автомат даацын бетонон блокийн үйлдвэрт хөрөнгө оруулалтын зээл олгож үйлдвэрийн хүчин чадал нэмэгдүүлсэн.




## “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”-ИЙН ТУСГАЙ НӨХЦӨЛТ ХАДГАЛАМЖ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийн **2%**-ийг **10** жилийн хугацаатай хадгаламжид байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нээж одоогийн байдлаар **2.3 тэрбум** төгрөг хуримтлуулаад байна.

Ирээдүй хойч үеийн төлөө сангийн журмын дагуу уг хадгаламжийн эх үүсвэрийг Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийнхэнд зориулсан эрсдэл багатай, урт хугацааны хөрөнгө оруулалт шаардагдах төсөл хөтөлбөрт дэмжихэд зарцуулах эсвэл үргэлжлүүлэн хадгалах эсэхийг 2026 онд шийдвэрлэнэ.

## “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу – Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2022 онд 7 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.



“Говийн оюу-оюутны тэтгэлэг” хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн дотоодын их дээд сургуульд Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлээр амжилттай суралцаж буй Өмнөговь аймгийн оюутнуудыг дэмжих зорилгоор сургалтын бүрэн тэтгэлэг болон нэг удаа аймагтаа ирэх зардлыг мөн өгдөг.

“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55, 2019 онд 45, 2020 онд 47, 2021 онд 90, 2022 онд 81 оюутан тус тус хамруулсан бөгөөд 2016-2022 онд давхардсан тоогоор Өмнөговь аймгийн 405 оюутанд 1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. Тэтгэлэгт хамрагдан төгссөн оюутнуудын 70 гаруй хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ орон нутагтаа ажиллаж 10 орчим хувь нь дараагийн шатны сургалтад хамрагдаж байна.

2022-2023 оны хичээлийн жилийн тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд:

- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас тус аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсний дагуу аймгийн ЗДТГ-ын боловсрол, хүний нөөцийн мэргэжилтнүүд, Ханбогд сумын төлөөлөл, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төлөөлөл болон хөтөлбөрийн удирдах байгууллагаар сонгогдсон “Говийн оюуны хөтөч” төрийн бус байгууллага, Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороо 2022-2023 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2022 онд  магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр амжилттай суралцаж байгаа тэтгэлгийн гэрээгээ сунгасан болон шинээр тэтгэлэгт хамрагдсан нийт 81 оюутанд тэтгэлэг олгосон.

### Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутнуудыг сумдаар ангилсан байдал




### Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутнуудыг сумдаар ангилсан байдал




| | Баяндалай | Баян-Овоо | Булган | Гурвантэс | Даланзадгад | Мандал-Овоо | Манлай | Ноён | Номгон | Сэврэй | Ханбогд | Ханхонгор | Хурмэн | Цогт-Овоо | Цогтцэций |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2016 | | 2 | | 1 | 18 | | 1 | 1 | 1 | 1 | 3 | 1 | | 1 | |
| 2017 | 5 | 2 | 1 | | 33 | 1 | 4 | 1 | 1 | 1 | 2 | 3 | | 2 | 1 |
| 2018 | 3 | 3 | 2 | 2 | 31 | 1 | 3 | | 1 | | 3 | 3 | 1 | 1 | 1 |
| 2019 | 3 | 2 | 3 | 1 | 23 | 1 | 3 | | 1 | 1 | 2 | 1 | 1 | 2 | 1 |
| 2020 | 3 | 1 | 3 | 4 | 16 | 1 | 2 | | 3 | 5 | 1 | | 2 | 1 | 5 |
| 2021 | 4 | | 3 | 7 | 47 | 2 | | | 4 | 6 | 4 | 2 | 2 | 2 | 7 |
| 2022 | 7 | 1 | 3 | 5 | 38 | | 3 | 1 | 2 | 6 | 3 | 1 | 3 | 4 | 4 |

## "ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ" ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ




## "ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ" ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН ТӨГССӨН ОЮУТНУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



## “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ”
## ХӨТӨЛБӨРТ 2022 ОНД ХАМРАГДСАН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЮУТНУУД


**Р.БАЯРМАА**
*МУИС-Археологи*


**Э.ҮРЖИНБАДАМ**
*ШУТИС- Архитектур*


**Б.НАНДИНСҮРЭН**
*МУБИС-Аялал жуулчлал*


**Д.ЖИМСМАА**
*Их засаг-Бага ангийн багш*


**Б.ЛХАМЖАРГАЛ**
*МУИС-Биологийн багш*


**М.МЯГМАРСҮРЭН**
*МУБИС-Математикийн багш*


**Э.ДАЛАЙЖАРГАЛ**
*МУИС-Нийгмийн ухааны багш*


**О.ЛХАГВАДЭРЭМ**
*МУБИС-Биеийн тамирын багш*


**Ү.БОЛОРЗУЛ**
*МУБИС-Нийгмийн ухааны багш*


**Б.НАСАНТОГТОХ**
*ХААИС-Байгаль орчны нөхөн сэргээлт*


**А.ЦОГДЭЛГЭР**
*ХААИС-Байгаль орчны нөхөн сэргээлт*


**Г.СҮХБАТ**
*МУИС-Геологи*


**Ц.ХУЛАН**
*СУИС-Жүжигчин*


**Ц.АНАР**
*Боловсрол, соёл эрх зүйн ДС-Жүжигчин, найруулагч*


**Э.ЦЭРЭНЧУНТ**
*ХААИС-Барилгын инженер*


**Э.БАДАМХАМД**
*АШУҮИС- Дүрс оношилгооны техникт*


**Ё.ХОРОЛСҮРЭН**
*ХААИС-Хүнсний технологич*


**Г.ӨНӨДАЛАЙ**
*ШУТИС-Цахилгааны инженер*


**Б.БАТХИШИГ**
*ХААИС-Мал зүйч*


**Б.ТАЙВАНЖАРГАЛ**
*ХААИС-Малын эмч*

## “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ 2022 ОНД ХАМРАГДСАН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЮУТНУУД



**А.ТЭГШЗАЯА**

*ХААИС-Малын эмч*



**Ч.АНАР**

*МУИС-Мэдээллийн систем*



**О.ЭРДЭНЭЧИМЭГ**

*ШУТИС- Мэдээллийн систем- График дизайн*



**Г.АНУУЖИН**

*МУБИС-Нийгмийн ажилтан*



**И.ЛХАМ-ОСОРЖИН**

*МУИС-Нийгмийн ажилтан*



**Г.НАСАНЖАРГАЛ**

*МУБИС-Нийгмийн ажилтан*



**Ц.НЯМДАРЬ**

*МУИС-Нийгмийн ажилтан*



**О.САРАНЦАЦРАЛТ**

*МУБИС-Нийгмийн ажилтан*



**Б.ЖАМЦ**

*ШУТИС-Программ хангамж*



**Б.ИШСҮРЭН**

*Мандах их сургууль-Программ хангамж*



**С.МЯГМАРБАЯР**

*ХУИС-Программ хангамж*



**Б.ӨСӨХБАЯР**

*Их засаг ОУИС-Программ хангамж*



**Ц.ХАЛИУНЗАЯА**

*МУИС-Программ хангамж*



**О.ЦЭНГҮҮН**

*МУИС-Программ хангамж*



**Н.ЭНХБАЯСГАЛАН**

*Идэр ИС-Программ хангамж*



**Ж.МӨНХСАЙХАН**

*ШУТИС-Системийн аюулгүй байдал*



**Н.ОТГОНЦЭЦЭГ**

*УБХИС-Системийн аюулгүй байдал*



**О.МАРАЛ-ЭРДЭНЭ**

*ХҮИС-Сэтгэл судлал*



**Х.НАМУУН**

*ХҮИС-Сэтгэл судлал*



**Г.НАМУУНСАЙХАН**

*МУИС-Сэтгэл судлал*



**Б.ЭРСҮҮХ**

*Оточ маарамба-Уламжлалтын эмч*



**Х.ОЮУ-ЭРДЭНЭ**

*Этүгэн ИС-Хүний их эмч*



**П.ДӨЛГӨӨН**

*АШУҮИС-Хүүхийн эмч*



**Д.АЛТАНЖАРГАЛ**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**Т.БАТ-ЭНХ**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**Г.БАЯНБУЛГАН**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**С.БАЯРМӨНХ**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**Б.ЗОЛЗАЯА**

*АШУҮИС-Шүдний эмч*



**Ж.МЯГМАРСҮРЭН**

*АШУҮИС-Шүдний эмч*



**Б.НАСАНЦЭЦЭГ**

*АШУҮИС-Шүдний эмч*



**Э.ОРГИЛМАА**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**Х.УРАНЦЭЦЭГ**

*Ач анагаах ухааны ИС-Шүдний эмч*



**Б.ХУЛАН**

*АШУҮИС-Шүдний эмч*



**С.ЦЭНГЭЛМАА**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**Б.ЦЭЦЭГДЭЛГЭР**

*Этүгэн ИС-Шүдний эмч*



**И.ОТГОНЖАРГАЛ**

*ХААИС-Эрүүл ахуйч, Хүнсний чанар, эрүүл ахуйн үнэлгээ*



# ХАНДИВ ТУСЛАМЖ

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Хандив тусламжийн журмын дагуу Өмнөговь аймаг, тус аймгийн сумдад шаардлагатай тулгамдсан асуудал, журамд заасан хандивын төрлийн дагуу 2016-2022 онд 3 тэрбум төгрөгийн Хандив тусламж олгосон байна.

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2022 ОНД ОЛГОСОН ХАНДИВ



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2016-2022 ОНД ОЛГОСОН НИЙТ ХАНДИВ

### 2016-2022 онд олгосон хандив




| Он | Тоо | Дүн |
|---|---|---|
| 2016 | 5 | 33,000,000 |
| 2017 | 12 | 368,125,762 |
| 2018 | 20 | 175,412,560 |
| 2019 | 25 | 370,588,700 |
| 2020 | 11 | 322,595,920 |
| 2021 | 4 | 866,500,000 |
| 2022 | 16 | 917,950,000 |
| **Нийт** | **93** | **3,054,172,942** |

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2016-2022 ОНД ОЛГОСОН НИЙТ ХАНДИВЫН ЗОРИУЛАЛТ

### 2016-2022 онд олгосон хандивыг төгрөгөөр харуулав



# САНГИЙН 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

## 2022 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

*Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум, "Оюу толгой" компани хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний талуудын уулзалт болсон.*

*Хамтын ажиллагааны гэрээнд "Грант торнтон" олон улсын аудитын компаниас хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтийг хэлэлцэж цаашдын хамтын ажиллагаагаа хэлэлцлээ.*





*Харилцааны хороо хуралдаж "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ийн үйл ажиллагаа болон хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээлэлтэй танилцаж Санд хүлээн авсан төсөл хөтөлбөрүүдийг хянан эрэмбэлж Удирдах зөвлөлд зөвлөмж өглөө.*

*"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланга боловсруулан Англи, Монгол хэл дээр 2500 хувь хэвлэн нийтэд тарааж танилцуулан www. goviinoyu.mn цахим хуудсанд байршууллаа.*









*Манлай, Баян-Овоо, Ханбогд сумдын тэмээний баярт зориулан хандив олгож өв соёлоо түгээн дэлгэрүүлэх үйлст дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.*

## 2022 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ



*"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөл хуралдаж Санд ирсэн төсөл хөтөлбөрийн саналуудтай танилцаж 9 төсөл шинээр санхүүжүүлэхээр баталж, Өмнөговь аймгийн 12 суманд санхүүжилтийн квот олгохоор хуваарилсан бөгөөд Сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргалаа.*




RioTinto
GrantThornton
Оюу Толгой

*"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд Грант Торнтон аудитын компани аудит хийсэн бөгөөд Сангийн нийт үйл ажиллагаанд Рио Тинто болон Оюу толгой компанийн дотоод аудит хяналт хийсэн.*

*Рио Тинтогийн дотоод аудит "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-н үйл ажиллагаанд аудит хийхээс гадна санхүүжүүлж хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн судалгаа хийсэн.*

*Рио Тинто болон "Оюу толгой" компанийн төлөөлөл, удирдлагууд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-аас санхүүжүүлж хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан.*

*Үндэсний хэмжээний телевиз болон сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл 17 сэтгүүлч Сангийн үйл ажиллагаатай танилцсан.*

# САНГИЙН 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Өмнөговь аймгийн 12 сумын Засаг дарга нартай санхүүжилтийн квотын гэрээ байгуулж өмнөх онуудад санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдтэй танилцсан.*






*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр Даланзадгад суманд баригдсан 4 давхар, олон улсын стандартад нийцсэн Өмнөговь аймгийн музейн барилгын нээлтийн ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагдсан.*

## 2022 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

*Харилцааны хороо болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн хурал болж 3 төсөл хөтөлбөр санхүүжүүлэхээр батлав.*





*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Ханбогд сумын төвийн цэвэр бохир шугамын угсралтын ажлын шав тавих, төслийн үйл ажиллагаа эхлүүлэх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулсан. Төслийн гүйцэтгэгчээр орон нутгийн “Шутээн-Эрдэнэ” компани шалгаран төслийн барилга угсралтын ажлыг амжилттай гүйцэтгэсэн.*



*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 10.9 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Өмнөговь аймгийн музейн барилга Монгол Улсын 2022 оны шилдэг барилгаар шалгарсан.*




*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас “Говийн оюу-оюутны тэтгэлэг” хөтөлбөр зарлаж Өмнөговь аймгаас дотоодын магадлагдан итгэмжлэгдсэн их дээд сургуульд амжилттай суралцаж, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах шаардлага хангасан оюутнуудаас материал хүлээн авсан.*

# САНГИЙН 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ




Өмнөговь аймгийн уул уурхайн чуулган, Соёлын ажилтны чуулга уулзалт, Нүүдэлчин Монгол, Цагаан таягтны өдөрлөг гэх мэт үйл ажиллагаануудад “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас хандив олгов.




“Оюу толгой” компанийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Өмнөговь аймагт 2015-2022 онд оруулсан хөрөнгө оруулалт 100 тэрбум төгрөгт хүрлээ.

## 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ



Харилцааны хороо болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн хурал болж 3 төсөл хөтөлбөр санхүүжүүлэхээр батлав.



“Говийн оюу-оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн 2022-2023 оны хичээлийн жилийн тэтгэлэгт Өмнөговь аймгийн 81 оюутан хамруулж сургалтын бүрэн тэтгэлэг олголоо.



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн ажилтнууд Олон улсын санхүүгийн корпораци (IFC), болон Дэйл Карнеги сургалтын төвүүдийн чадавхжуулах сургалтуудад хамрагдлаа.



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хүсэлт, Өмнөговь аймгийн сумдын малчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас өвлийг өнтэй давах, өвс тэжээл худалдан авахад зориулан 800 сая төгрөгийн хандив олголоо.




“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2021 оны тайланг нийт 2800 хувь, 8200 брошюр, 3630 бусад танилцуулга, материал хэвлүүлж “Оюу толгой” компанийн нээлтэй өдрүүд, “Нэгдсэн үндэстний байгууллага”-ын нээлттэй өдөр, олон нийтийн уулзалт, хурал чуулганы үеэр олон нийтэд түгээж, цаг үеийн мэдээ, мэдээллийг Сангийн цахим хуудас, Facebook хуудсанд цаг тухай бүрд мэдээлсэн. 2022 онд Сангийн Facebook хуудсаар 476.4 мянган хүнд хүрч 75 пост нийтэлсэн.

# САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ-2022 ОН

Оюу Толгой

“ОЮУТОЛГОЙ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2022/

**18.97 ТЭРБУМ ₮/5.99 САЯ $**




**16.4 ТЭРБУМ ₮/**
**5.18 САЯ $**

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт




**1.04 ТЭРБУМ ₮/**
**0.33 САЯ $**

Ирээдүй хойч үеийн төлөө сан

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж




**0.97 ТЭРБУМ ₮/**
**0.31 САЯ $**

Орон нутгийн хандив




**0.56 ТЭРБУМ ₮/**
**0.17 САЯ $**

Сангийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээлэл, бусад

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь 2022 онд 12 томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн сангаас түншлэгч болон уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа Зорилтот сумд болох Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Номгон, Хүрмэн, Цогтцэций сумдад олгосон санхүүжилтийн квотоор мөн онд нийт 39 төсөл, хөтөлбөр хэрэгжээд байна.

**2022 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Зорилтот сумдын санхүүжилтийн квотын болон аймаг, сумдын хамарсан томоохон нийт 51 төсөл санхүүжүүлж Хамтын ажиллагааны гэрээний дараах сэдэвчилсэн хавсралтын хүрээнд төслүүд хэрэгжүүлсэн.**

2022 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр-
Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт тус бүрээр - (₮)



## “Говийн Оюу хөгжлийн дэмжих сан”-аас 2015-2022 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилбал:




| № | Сэдэвчилсэн Хавсралт | Төслийн тоо | Санхүүжилт (₮) | Санхүүжилт ($) |
|---|---|---|---|---|
| 1 | Нийгмийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт | 58 | 60,722,812,783 | 23,642,521.51 |
| 2 | Байгаль орчны менежмент | 16 | 1,231,283,360 | 515,828.07 |
| 3 | Нийгмийн суурь үйлчилгээ | 191 | 17,088,270,337 | 6,329,750.39 |
| 4 | Орон нутгийн бизнес хөгжил | 17 | 3,397,053,405 | 1,310,874.12 |
| 5 | Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент | 19 | 2,008,818,739 | 827,923.46 |
| 6 | Усны менежмент | 17 | 3,138,532,421 | 1,092,110.02 |
| 7 | Үндэсний түүх соёл | 35 | 1,549,226,099 | 669,138.77 |
| | **Нийт** | **353** | **89,135,997,144** | **34,388,146** |

## УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУВААРИЛСАН ХУВААРИЛАЛТ

| № | ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР | САНХҮҮЖИЛТ (₮) | САНХҮҮЖИЛТ ($) |
|---|---|---|---|
| **УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТАЛСАН ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР** | | | |
| **Нийгмийн дэд бүтэц** | | | |
| **Инфляци, үнийн өсөлтөөс шалтгаалсан нэмэлт санхүүжилт олгосон төсөл** | | | |
| 1 | Өмнөговь аймгийн музейн барилгын нэмэлт ажил | 1,122,956,377 | 354,868.45 |
| 2 | Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт санхүүжилт | 682,680,000 | 215,735.53 |
| **Шинээр батлагдсан төсөл** | | | |
| 1 | Ханбогд сумын төвийн гадна цэвэр, бохирын шугамын угсралт | 4,456,004,019 | 1,408,153.77 |
| 2 | “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөр- бохирын шугамын ажил | 973,708,238 | 307,704.15 |
| 3 | Даланзадгад сумын дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах ажил | 1,500,000,000 | 474,019.02 |
| | Дэд дүн (А) | **8,735,348,634** | **2,760,481** |

| | | | |
|---|---|---|---|
| **Тогтвортой хөгжлийн хөтөлбөр** | | | |
| 1 | Бэлчээр усжуулах II аян-2022 | 1,777,875,215 | 561,831.11 |
| 2 | Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажил | 84,570,000 | 26,725.19 |
| 3 | Галын машин | 500,000,000 | 158,006.34 |
| 4 | Цээжний хөндийн хагалгааны багаж | 40,000,000 | 12,640.51 |
| 5 | “Цахим багш”- компьютер | 874,000,000 | 276,195.08 |
| 6 | Өмнөговь аймгийн хүн амын боловсролыг дэмжих хамтарсан хөтөлбөр | 996,559,200 | 314,925.34 |
| 7 | Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр | 1,265,472,000 | 399,905.20 |
| 8 | Эрт оношилно-эрт эмчилнэ | 626,220,000 | 197,893.46 |
| 9 | Дэлхийн иргэд Ханбогдоос | 245,000,000 | 77,423.11 |
| | Дэд дүн (Б) | **6,409,696,415** | **2,025,545** |
| | ТОМООХОН ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ДҮН (В) | 15,145,045,049 | 4,786,026 |

| Санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төслүүд | | | |
|---|---|---|---|
| ХАНБОГД СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Г)** | **204,183,700** | **70,000** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 12,876,491 | 4,518.8 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| БАЯН-ОВОО СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Д)** | **145,845,500** | **50,000** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 17,255,725 | 6,055.7 |
| 1 | Аялгуу | 10,200,000 | 3,579.55 |
| 2 | Өрх бүр үйлдвэрлэгч | 90,000,000 | 28,441.14 |
| 3 | Ирээдүйн зохион бүтээгч инженерүүд | 19,939,200 | 6,301.04 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 7,412,500 | 2,601.3 |
| МАНЛАЙ СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Е)** | **145,845,500** | **50,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 374,540 | 131.4 |
| 1 | Ойн зурвасын усалгаа | 16,000,000 | 5,056.20 |
| 2 | Эмчилгээний кабинет тохижуулах | 20,000,000 | 6,320.25 |
| 3 | Тохилог ажлын байр, чанартай үйлчилгээ | 20,000,000 | 6,320.25 |
| 4 | Эко хогийн сав нийлүүлэх | 7,000,000 | 2,212.09 |
| 5 | Ундны усны шүүлтүүр | 10,000,000 | 3,160.13 |
| 6 | Дотуур байр-тав тухтай орчин | 23,228,000 | 7,340.34 |
| 7 | Цаг уур өртөөний ариун цэврийн өрөөний тохижилт | 6,000,000 | 1,896.08 |
| 8 | Хужир шүү тарих | 16,217,300 | 5,124.87 |
| 9 | Ногоон төгөл | 20,000,000 | 6,320.25 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| ДАЛАНЗАДГАД СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ё)** | **145,845,500** | **50,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 29,651,730 | 10,405.9 |
| 1 | Оюу шүд | 99,759,000.00 | 31,525.11 |
| 2 | ДЗ 26-р цэцэрлэгт дэвсгэр нийлүүлэх | 19,980,000.00 | 6,313.93 |
| 3 | Тухтай дотуур байр | 20,000,000.00 | 6,320.25 |
| 4 | Элсний волейболын талбай байгуулах | 19,950,000.00 | 6,304.45 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| БАЯНДАЛАЙ СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ж)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 35,138,781 | 12,331.5 |
| 1 | Сумын төвийн камержуулалт | 19,985,500.00 | 6,315.67 |
| 2 | Чөлөөт бөхийн дэвжээ | 15,000,000.00 | 4,740.19 |
| 3 | Хос хаягтай Баяндалай | 9,900,000.00 | 3,128.53 |
| 4 | Мянган төгөл | 20,000,000.00 | 6,320.25 |
| 5 | Музейн үзмэр дэглэх | 25,000,000.00 | 7,900.32 |
| 6 | Өвлийг өнтэй давъя | 22,000,000.00 | 6,952.28 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| СЭВРЭЙ СУМ | | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (З)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 1,423,500 | 499.6 |
| 1 | Зөв бүхэн зөвхөн манай гэр бүлээс | 3,400,000.00 | 1,074.44 |
| 2 | Лед дэлгэц | 79,233,000.00 | 25,038.63 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 4,336,000 | 1,521.7 |

| | | | |
|---|---|---|---|
| | **МАНДАЛ-ОВОО СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (И)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 24,140,420 | 8,471.7 |
| 1 | Гамшиг дайчилгааны бэлэн байдал | 37,600,000.00 | 11,882.08 |
| 2 | Эко сум | 45,500,000.00 | 14,378.58 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 4,400,000 | 1,544.1 |
| | **ЦОГТ-ОВОО СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Й)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 513,300 | 180.1 |
| 1 | Хүнсний ногооны тариалангийн талбайн тохижилт | 11,945,000.00 | 3,774.77 |
| 2 | Ухаалаг шийдэл | 69,800,000.00 | 22,057.68 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 4,380,000 | 1,537.1 |
| | **НОМГОН СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (К)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 3,109,100 | 1,091.1 |
| 1 | Номгон сумын ЭМТ-д автомашин нийлүүлэх | 23,400,000.00 | 7,394.70 |
| 2 | Цахилгаан хангамжийн дэд станц | 41,787,136.00 | 13,205.26 |
| 3 | Хайрхан хорооллыг гэрэлтүүлгээр хангах | 14,705,000.00 | 4,646.97 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| | **БУЛГАН СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Л)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 4,474,115 | 1,570.1 |
| 1 | Ёслол хүндэтгэлийн өргөө - Булган | 45,000,000.00 | 14,220.57 |
| 2 | Түүхээ мөнхөлье | 30,000,000.00 | 9,480.38 |
| 3 | Өрхийн эмийн сан | 12,700,000.00 | 4,013.36 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 4,000,000 | 1,403.7 |

| | | | |
|---|---|---|---|
| | **ХҮРМЭН СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (М)** | **87,507,300** | **30,000.00** |
| | 2021 онд төсөлд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт | 89,644,001 | 31,459.3 |
| 1 | Хамгаалагдсан хүүхэд хөгждөг | 22,563,600.00 | 7,130.38 |
| 2 | Эмийн сангийн тохижилт | 11,840,000.00 | 3,741.59 |
| 3 | Говь гурван сайхан | 18,115,000.00 | 5,724.57 |
| 4 | Модны талбай хашаажуулалт | 10,000,000.00 | 3,160.13 |
| 5 | Соёлын төвийн тоног төхөөрөмж | 94,099,900.00 | 29,736.76 |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| | **ЦОГТЦЭЦИЙ СУМ** | | |
| | **2022 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Н)** | **87,507,300** | **30,000.00** |
| | Эрсдэлийн сангийн зарцуулалт | 0 | 0 |
| | **САНХҮҮЖИЛТИЙН КВОТЫН ДҮН (О)** | **1,341,778,600** | **424,019.05** |
| | **БУСАД** | | |
| 1 | Ирээдүй хойч үеийн төлөө сан | 1,049,138,845.83 | 331,541.18 |
| 2 | Хандив тусламж | 974,856,474.31 | 308,067.01 |
| 3 | ХДС-ийн үйл ажиллагаа | 562,677,700.00 | 177,813.29 |
| | **Дэд дүн (Ө)** | **2,586,673,020.14** | **817,421.48** |
| | **Нийт дүн(П)** | **19,073,496,669** | **6,027,467** |

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2022 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

## 1. “ХАНБОГД СУМЫН ГЭР ХОРООЛЛЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ БАРИХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ШҮТЭЭН-ЭРДЭНЭ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **4,456,004,019 төгрөг** |






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сум нь суурин болон хөдөлгөөнт хүн амын төвлөрөл ихтэй томоохон сум бөгөөд 2021 оны статистикийн судалгаагаар тус суманд албан ёсны бүртгэлтэй 8154 хүн ам, 1718 өрх тоологдсон. Энэхүү томоохон суурин болон хөгжиж байгаа сумын хувьд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд тав тухтай амьдарч, ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд нэн тэргүүнд сумын төвийн инженерийн шугам сүлжээг өргөтгөж гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох нь чухал дэмжлэг болох юм.
- 2017 онд Ханбогд сумын төвд “Оюу толгой” компанийн санхүүжилтээр “Цэвэр усан хангамжийн цогцолбор”-ыг байгуулсан. Тус цогцолбор гүний хоёр худаг, усан сан, ус цэвэршүүлэх байгууламж, ил өртөө, усны чанарын хяналтын лаборатори зэрэг байгууламжуудаас бүрдсэн, автомат технологитой, иж бүрэн цогцолбор юм. Мөн 2016 онд Азийн хөгжлийн банкны G0204-MON төслийн санхүүжилтээр Ханбогд сумын төвд цэвэрлэх байгууламж, цэвэр, бохир, дулааны гол шугамууд ашиглалтад орсон. Дээрх томоохон хөрөнгө оруулалтуудын үр дүнд Ханбогд сумын хэрэглэгчид цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд анх холбогдож эхэлсэн бөгөөд үүнээс хойш сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэвэр, бохир, дулааны салбар шугамуудыг өргөтгөж 2021 оны байдлаар сумын төвийн одоо суурьшсан нийт хэрэглэгчдийн

зөвхөн 30 орчим хувь нь дээрх шугамуудад холбогдсон байна.

Иймд дээрх стандартад нийцсэн зураг, төсвийн дагуу баригдсан, хүчин чадал сайтай цэвэр, бохир усны гол шугамд гэр хорооллын айл өрх холбох салбар шугамуудыг өргөтгөх нь нэн чухал байсан.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын төвийн айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож тэдгээр суурьшлын бүсийн ард иргэдийг эрүүл, аюулгүй тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны № 02, № 10 тогтоолуудаар “Ханбогд сумын төвийн гадна цэвэр, бохир усны шугамын угсралт” төслийг 4,456,004,019 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Шүтээн-Эрдэнэ” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- 2022 онд “Шүтээн-Эрдэнэ” ХХК нь орон нутгийн зах зээлээс 491.2 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн, шатахуун худалдан авч, 30 түр ажлын байр бий болгосон.
- Улсын комисс 2022 оны 12 дугаар сарын 08-нд ажиллаж ашиглалтад шилжүүлэхээр шийдвэрлэв.

## ҮР ДҮН:

- Ханбогд сумын төвийн Гоёот, Хөөвөр, Бага булаг хорооллын 30 аж ахуйн нэгж байгууллага, 325 айл өрх, 30 гудамж цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбогдоно.
- Иргэдийн ундны усны чанар сайжирсан.
- Иргэдийн аюулгүй тухтай, эрүүл, аюулгүй орчинд амьдарч, ажиллах нөхцөл сайжирсан.
- Хөрсний бохирдлыг бууруулсан.
- Айл өрх, албан байгууллагын санхүүгийн чадавхад эерэг нөлөөлнө.
- Шугам сүлжээний үйл ажиллагааг хариуцагч байгууллагын борлуулалтын орлого нэмэгдэнэ.

**ШУГАМЫН АЖЛЫГ 2022 ОНЫ 12 САРЫН 08-НД УЛСЫН КОМИССТ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ.**








## 2. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
БАТЛАГДСАН ТӨСӨВ: **1,800,000,000 төгрөг**

ГҮЙЦЭТГЭГЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

1. “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022, Багц-1”: **“Хишиг юниверс” ХХК, 355,000,000 төгрөг**
2. “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022, Багц-2”: **“Хишиг юниверс” ХХК, 356,000,000 төгрөг**
3. “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022, Багц-3”: **“Сойл инженеринг” ХХК, 358,875,215 төгрөг**
4. “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022, Багц-4”: **“Эхний эхэн” ХХК, 354,000,000 төгрөг**
5. “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022, Багц-5”: **“Эхний эхэн” ХХК, 354,000,000 төгрөг**






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Хөдөө аж ахуйн газраас аймгийн хэмжээнд нийт 6,665 малчин өрхийн 2.8 сая гаруй толгой мал 5,184 бэлчээрийн худгаас ундалж байгаа нь нийт малын тоог хонин сүргийн тоо толгойд шилжүүлснээр нэг худгаас 800-3,700 толгой мал ундалж, нэг худгаас ус уух малын тоо стандартаас 2-3 дахин хэтэрсэн тухай тооцоо, судалгаа гаргасан. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр:
  - 2019 онд “Чандмань эрдэнэ” төсөл /784.8 сая ₮/-ийн хүрээнд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын 15 багийн газар нутагт 37 худаг шинээр гаргаж, 40 худаг сэргээн засварласан,
  - 2021 онд сангийн санхүүжилтээр “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2021” төсөл /516.1 сая ₮/-ийн хүрээнд аймгийн 9 сумын усжуулагдаагүй, усан хангамж дутагдалтай, алслагдсан бэлчээрт газрын доорх усны геофизикийн хайгуул хийж инженерийн хийцтэй худаг 18 худаг шинээр гаргасан.

  Мөн аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худаг ус гаргах, сэргээн засварлах ажлууд

хийгдсээр байгаа ч одоогийн байдлаар аймгийн хэмжээний нийт бэлчээрийн зориулалттай газрын 58 % нь усжуулагдсан байна. Иймд цаашид усны дутагдалтай газар нутгуудад бэлчээр усжуулах, уст цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Усжуулагдаагүй, усан хангамж дутагдалтай, алслагдсан бэлчээрт инженерийн хийцтэй худаг гаргаж бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022” төслийг 1,800,000,000 (нэг тэрбум найман зуун сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ дээрх ажлыг 5 багц болгон тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ болон санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь төслийн гүйцэтгэгчид болох “Хишиг юниверс” ХХК, “Сойл инженеринг” ХХК, “Эхний эхэн” ХХК-тай санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийг эхлүүлэв.

## ҮР ДҮН:

- Бэлчээрийн нөөц сайтай газруудад газрын доорх усны шинэ нөөц олж тогтоох,
- Газрын доорх усны хайгуулаар уст цэгийн зөвлөмж өгсөн цэгт, инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж усжуулагдаагүй бэлчээрийг усжуулж сум орон нутаг, тухайн бүсийн малчдад хүлээлгэн өгөх
- Өмнөговь аймгийн 15 сумын усан хангамж дутагдалтай 60 цэгт инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж 90.0 мянган га бэлчээрийг усжуулж, 180 орчим малчин өрхийн 90.0 мянган толгой малыг найдвартай усны эх үүсвэртэй болгоход дэмжлэг болно.
- Төслийн хүрээнд инженерийн хийцтэй 60 худаг шинээр гаргахаас 2022 оны байдлаар 28 худаг гаргаж төслийн гүйцэтгэл 47%-д хүрсэн. Үлдсэн худгууд гаргах ажил 2023 онд үргэлжлэн хэрэгжинэ.







## 3. “НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧ” ХӨТӨЛБӨР-БОХИРЫН ШУГАМЫН АЖИЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“АЛТАЙН ҮНДЭС КОНСТРАКШН” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **973,708,238 төгрөг** |



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тус бүсэд барилга, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр, малын гаралтай түүхий эд боловсруулах болон бусад чиглэлийн 30 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулах боломжтойгоор төлөвлөсөн байдаг. 2021 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр тус бүсийг эрчим хүчний эх үүсвэрт холбоход зориулан 1.0 тэрбум төгрөг баталсан бөгөөд дээрх санхүүжилтээр “Аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа”, “Үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах”, “35/10 кВ-ын дэд станц, 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж барих”, “35 кВ-ын ЦДАШ шинээр татах-(1км)” зэрэг төслүүдийг хэрэгжүүлсэн.
  Өмнөговь аймгийн ЗДТГ-с дээрх үйлдвэрийн бүсийг дэд бүтцэд шат дараатай холбохоор төлөвлөж 2022 онд тус бүсийг бохир ус зайлуулах төвлөрсөн шугамд холбох төслийн саналыг санд ирүүлсэн.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын үйлдвэрийн бүсийн дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэхэд дэмжлэг болох.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэр, технологийн паркийг дэд бүтцэд холбох төслийг 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэр, технологийн паркийг дэд бүтцэд холбох ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Алтайн үндэс констракшн” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилгын ажлыг эхлүүлэв.
- Төслийн ажил 2023 оны барилгын ажлын улиралд эхлэх бөгөөд төслийн хүрээнд Даланзадгад сумын үйлдвэрийн бүсээс аймгийн хуучин цэвэрлэх байгууламж руу холбох 2.08 км бохир усны гол шугамын ажил хийх юм.

## ҮР ДҮН:

- Өмнөговь аймгийн үйлдвэрлэлийн салбар хөгжихөд дэмжлэг болно.
- Тус бүсэд нэн чухал хэрэгцээ, шаардлагатай үйлдвэрийн бохир ус зайлуулах асуудал шийдвэрлэгдэнэ.
- Орон нутгийн иргэдэд тогтвортой, байнгын ажлын байр бий болох суурь тавигдана.

# 4. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦАД УСААР ҮНС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ БОЛОН ҮНСЭН САН БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| БАТЛАГДСАН ТӨСӨВ: | **1,500,000,000 төгрөг** |




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын Дулааны цахилгаан станц нь 444 аж ахуйн нэгж байгууллага, 69 төсөвт байгууллага, 2705 айл өрх буюу нийт 3218 хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр ханган ажилладаг. Мөн тус станц нь 2000 онд ашиглалтад орсон бөгөөд жилд дунджаар 70,000 тн нүүрс түлж 18,000 тн үнс ялгаруулдаг. Тус станц нь үнс, шаарга зайлуулах тоног төхөөрөмжгүйгээс үнс, нурам зайлуулагч 3 хүнээр үнсээ хуурайгаар нь түрдэг тэргээр зөөлгөн машинд ачин станцаас урагш 3.5 км газарт тээвэрлэн хаядаг. Зуухны хий соролт норм хэмжээнээс 3-4 дахин ихсэж горим алдагдсанаас АҮК 50%-иас доош буурч дутуу шаталтууд байх ёстой хэмжээнээс 2-3 дахин өссөн. Үүнээс шалтгаалан нүүрсний зарцуулалт нэмэгдсэн. Мөн станцын зуухнуудын нүүрсний шаталтаас үүссэн үнсний 93% нь үнс баригчид баригдан бункер уруу хаягддаг технологитой боловч зуухны эд ангиуд хуучирч муудсанаас зөвхөн 40% нь үнс баригчид баригдан, 20% нь утааны хийтэй хамт тээвэрлэгдэн яндангаар агаар мандалд хаягддаг.
  Иймд тус станцаас гарч байгаа үнснээс шалтгаалсан агаарын бохирдлыг бууруулах нь нэн тэргүүний тулгамдсан асуудал болсон байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулж хотын агаар орчны бохирдлыг бууруулж оршин суугчдад таатай нөхцөл бүрдүүлэх, станцын ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах” төслийг 1,500,000,000 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Энэхүү 1,500,000,000 төгрөгийн санхүүжилтийг сангийн Удирдах зөвлөлөөс дулааны станцын янданг өөрчлөн сайжруулах зорилгоор баталсан байсан боловч ашиглагч, захиалагч байгууллагуудын шинээр гаргасан саналын дагуу зориулалтыг өөрчлөн усаар үнс зайлуулах систем байгуулахаар өөрчлөн баталсан.
- Захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ-аас “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлана.

## ҮР ДҮН:

- Даланзадгад сумын агаар орчны бохирдол буурч оршин суугчдын эрүүл амьдрах таатай нөхцөл бүрдэнэ.
- Станцын ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг хөнгөвчилж ажлын байрны эрүүл ахуй, орчны нөхцөл сайжирна.
- Тоноглолуудын үнс тоосонцроос шалтгаалж гэмтэж доголдол үүсдэг байдал багасна.

# 5. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **МУИС-ИЙН УЛААНБААТАР СУРГУУЛЬ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **85,070,000 төгрөг** |




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймаг нийт 15 сумтай, үүнээс зөвхөн Ханбогд сумын нутаг дэвсгэрт “Оюу толгой“ компанийн дэмжлэгтэйгээр тус сумын түүх-соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн сантай болсон. Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байрлах улсын хамгаалалтад авсан 28, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар аймгийн хамгаалалтад авсан-37, сумын хамгаалалтад авсан нийт 351 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар байгааг баталгаажуулсан. Дээрх газруудыг нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэх шаардлагатай байсан.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймгийн бүх сумын нутаг дахь түүх соёлын дурсгалуудыг нэг бүрчлэн бүртгэж аймаг орон нутаг, сум бүрийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн санг бий болгох.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх” төслийг 85,070,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.

- Захиалагч аймгийн ЗДТГ "Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх" төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч МУИС-ийн Улаанбаатар сургууль, санхүүжүүлэгч "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан" хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.

**ҮР ДҮН:**

- Өмнөговь аймгийн бүх нутгийн түүх соёлын дурсгалт зүйлсийн иж бүрэн бүртгэл мэдээллийн сан цаасан болон цахим хэлбэрээр бий болно.
- Түүх, соёлын дурсгалт зүйлсийн бүртгэл, хяналт төрийн байгууллагуудын бүрэн хяналтад орно
- Түүх, соёлын дурсгалуудыг бүрэн тоо бүртгэлтэй болгож, хадгалах, хамгаалах, судлах бүрэн боломжтой болно.
- Төслийн хүрээнд хийгдвэл зохих ажлууд 2022 онд 6 сумын нутаг дэвсгэрт хийгдсэн ба үлдэх сумдын хувьд 2023 онд үргэлжлэн хэрэгжинэ.

# 6. “ГАЛЫН МАШИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
БАТЛАГДСАН ТӨСӨВ: **500,000,000 төгрөг**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын “Гурван сайхан нисэх буудал” нь 2022-11-15 ны өдрийн байдлаар он гарснаас хойш өөрийн аэродромд 559 агаарын хөлөг хүлээн авсан.
  Нисэх буудалд одоо ашиглаж байгаа галын машин нь нисэхийн галын 4 дүгээр зэрэглэлтэй бөгөөд ашиглалтын хугацаа 2017 онд дууссан. Манай улсын агаарын тээврийн хөгжил муугаас шалтгаалан орон нутгийн нисэхийн үйл ажиллагаа доголдолтой, ихэнхдээ ашиггүй ажилладаг, эдийн засгийн хүндрэл зэргээс шалтгаалан тус байгууллага галын машинаа шинэчилж чадахгүй байна. Одоогийн байдлаар “Гурван сайхан нисэх буудал”-ын аэродромд 5-6 дугаар зэрэглэлийн агаарын хөлгүүд бууж байна. Иймд Даланзадгад сумын нисэх буудал нь стандартын шаардлагад нийцсэн хүчин чадалтай галын машинтай болох шаардлагатай байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Энэхүү төсөл нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах цаашлаад Гал унтраах 021-р ангитай хамтран ажиллаж тухайн орон нутгийн барилга байгууламж, албан байгууллага, эд хөрөнгө, объектын гал түймрийг хамтран унтраах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, хүн ардын амь нас, эрүүл мэндийг хамгаалах чухал ач холбогдолтой юм.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Галын машин” төслийг 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Галын машин” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зохион байгуулна.

## ҮР ДҮН:

- Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон бусад учирч болох гал түймрийн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөл сайжирна.

# 7. “ЦЭЭЖНИЙ ХӨНДИЙН ХАГАЛГААНЫ БАГАЖ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| БАТЛАГДСАН ТӨСӨВ: | **40,000,000 төгрөг** |






## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн БОЭТ-ийн мэс заслын тасаг нь 2013 оноос цээжний хөндийн дурангийн хагалгаа хийж эхэлсэн. БОЭТ-д 5 эмч, 4 сувилагч болон мэдээгүйжүүлэлтийн эмч, сувилагчаас бүрдсэн баг дурангийн хагалгаа хийж байна.
  Улсын хэмжээнд хийгдэж байгаа нийт хагалгааны 60% нь дурангаар хийгддэг болсон бөгөөд дурангийн хагалгаа нь өвдөлт багатай, хөдөлмөрийн чадвар алдалт байхгүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи юм. Орон нутагт хийгддэг дурангийн хагалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлэхэд багаж хэрэгслийн дутагдалтай байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Орон нутагт хийгдэх дурангийн хагалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Цээжний хөндийн хагалгааны багаж” төслийг 40,000,000 (дөчин сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Цээжний хөндийн хагалгааны багаж” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зохион байгуулна.

**ҮР ДҮН:**

- Иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад нэн чухал дэмжлэг болно.
- Яаралтай онош тогтоох шаардлагатай үед дурангаар оношилж шаардлагатай хагалгаа, эмчилгээг шууд хийх боломжтой.
- Дурангийн хагалгаа нь өвдөлт багатай, хагалгааны зүсэлт маш жижиг байдаг тул эдгэрэлт хурдан байдаг.
- Мөн дээрх хагалгаанд орсон өвчтөнд өвдөлт зовуурь бага, эдгэрэлт түргэн, гоо сайханд нь ээлтэй бөгөөд цаашлаад тэдний эдийн засаг, цаг хугацааг хэмнэдэг гэх мэт олон эерэг үр дүнтэй юм.

# 8. "ЦАХИМ БАГШ" ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"** |
| БАТЛАГДСАН ТӨСӨВ: | **874,000,000 төгрөг** |






## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл цахим хэлбэрт шилжсэн нь багш сурагчдын цахим, зайны сургалтыг ашиглах, үр ашигтай суралцах чадавх дээшилсэн. Мөн орчин үеийн боловсролын чиг хандлагатай уялдуулан багш нарыг сүүлийн үеийн сургалтын дэвшилтэд арга зүй, технологи, программуудыг ашиглаж болохуйц шаардлага хангасан зөөврийн компьютероор хангах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгараад байгаа билээ. Одоо ашиглаж буй компьютер нь орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, гацах, халах, асахгүй байх зэрэг эрсдэлүүд тулгарч байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Багш нарт сургалтын дэвшилтэд арга зүй, технологи, цахим сургалтыг ашиглах боломжийг бүрдүүлэх.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор "Цахим багш" төслийг 874,000,000 (найман зуун далан дөрвөн сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ "Цахим багш" төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зохион байгуулна.

## ҮР ДҮН:

- Өмнөговь аймгийн 230 багшийн сургалтын хэрэглэгдэхүүн сайжирч Өмнөговь аймгийн багш нарын цахим, зайн сургалтын чанарыг сайжруулж, хичээлийн хоцрогдлыг нөхөх, боловсролын чанарт эергээр нөлөөлж үр өгөөжөө өгнө.

# 9. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**

ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧИД:

- **ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН**
- **НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН**
- **НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН**

5 ЖИЛИЙН ХАМТАРСАН ТӨСВИЙН НИЙТ ДҮН: **6,900,000 $**

2022 ОНЫ САНХҮҮЖИЛТ:

- **ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 996,559,200 ₮**
- **НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 346,000 $**
- **НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 86,000 $**

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Төслийн хүрээнд дараах гол асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

1. **Боловсролын тэгш хүртээмжтэй байдал:**
   - Сургуулийн түвшинд тэгш хамруулсан боловсролын бодлогын хэрэгжилт тэр дундаа ХБХ-ийн сургуульд хамрагдалт хангалтгүй байна.
   - Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах
   - Хүүхдийн сурах, боловсрох үйл явцад эцэг, эх, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.
2. **Боловсролын цахим шилжилт:**
   - Цахим ур чадварын хүрээг нэвтрүүлэх удирдамж, зөвлөмж байхгүй байна.
   - Сургууль, цэцэрлэгийн цахим сургалтын орчин хэрэгцээний шаардлага хангахгүй байна.
   - Дэвшилтэд технологид шаардагдаж буй цахим ур чадварын сургалт зохион байгуулах сургалтын багц материалууд байхгүй байна.
   - Багш, эцэг, эх, сурагчдын цахим ур чадварын түвшин хангалтгүй байна.
3. **21-р зууны чадвар, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой чадваруудыг эзэмшүүлэх:**
   - Сургууль болон насан туршийн боловсролын төвүүдэд хичээлээс гадуурх үйл ажиллагааны чанар, хүртээмж хангалтгүй байна.
   - Өсвөр насныхны нийгмийн амьдралд оролцох оролцоо хангалтгүй байна,
   - Өсвөр насныхан, залуучуудын хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтыг дэмжих үйлчилгээ хангалтгүй байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ҮР ДҮНГИЙН ХЭМЖҮҮР:

- Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр нь дараах 4 зорилго, дэд зорилтуудын хүрээнд хэрэгжинэ.

| Хүлээгдэж буй үр дүн, зорилго | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| **Зорилго 1.**<br>Орон нутгийн засаг захиргаа нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, боловсролын тогтвортой хөгжлийн бодлогоор хангагдаж салбар дундын болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжсөн байна. | **Зорилт 1.1**<br>• Хөтөлбөр, нотлох баримтад суурилсан төсөв бүхий орон нутгийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний тоо | хязгаарлагдмал | Доор хаяж 4 бодлогын баримт бичигтэй болсон байна. |
| | • Төр хувийн хэвшлийн уялдаа холбоо, хамтын ажиллагаа | Байхгүй | Бий болно |
| | **Зорилт 1.2**<br>• Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогыг нэвтрүүлсэн хувийн хэвшлийн тоо | 0 | 20 |
| **Зорилго 2.**<br>Хүүхэд бүр эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр тэгш хамруулсан, чанартай сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдана. | **Зорилт 2.1**<br>• 3-5 насны хүүхдүүдэд, ялангуяа орлого багатай, малчин өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэгш хүртээмжтэй, чанартай сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж буй цэцэрлэгийн тоо | 10 | 27 |
| | **Зорилт 2.2**<br>• Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих стратегийг хэрэгжүүлж буй сумын тоо | 0 | 15 |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилго 3.**<br>Хүүхэд, өсвөр үеийнхэн цахим ур чадвар бүрэн эзэмших боломжтой орчинд тэгш хүртээмжтэй, чанартай боловсролд хамрагдаж, зөөлөн болон хөдөлмөр эрхлэхэд шаардагдах цогц ур чадвартай иргэд болно | **Зорилт 3.1**<br>• Сурлагын хоцрогдол багасгах, сургалтын чанар сайжруулах үйл ажиллагаа явуулсан сургуулийн<br>• тоо | 0 | 22 |
| | **Зорилт 3.2**<br>• Цахим ур чадвар эзэмшсэн багш, ажилчид, хүүхдүүдийн тоо | 0 | 1000 |
| | • Дэвшилтэд технологид суурилсан сургалтын багц хэрэглэгдэхүүн болон цахим сургалтын орчинтой болсон сургууль цэцэрлэгийн тоо | 0 | 2 |
| | **Зорилт 3.3**<br>• Нийгмийн амьдрал, бодлого, шийдвэр гаргахад оролцсон болон бусдыг манлайлсан өсвөр үеийнхэн, залуучуудын тоо | 0 | 6,000 |
| | • 21-р зууны ур чадвар, эрүүл мэндийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хичээлүүдийн агуулга, заах арга зүй сайжруулах үйл ажиллагаанд хамрагдсан багш нарын хувь | 0 | 60% |
| | **Зорилт 3.4**<br>• Эрүүл мэндийн кабинетийн тоо | 1 | 3 |
| | • Эрүүл мэндийн боловсролыг дэмжих орон нутгийн аймаг, сумдын хамтарсан багийн тоо | 0 | 14 |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилго 4.**<br>Хүүхэд бүр эрүүл, аюулгүй сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчинд сурч, хөгжинө | **Зорилт 4.1**<br>• Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн (УХАЦЭА) стандартын шаардлага хангасан төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны хувь | сургууль-60%,<br>дотуур байр -40%,<br>цэцэрлэг-70% | сургууль-100%,<br>дотуур байр -100%,<br>цэцэрлэг-100% |
| | **Зорилт 4.2**<br>• Дотоод нөөц бололцоондоо тулгуурлан хүүхдүүдийн өдрийн хоолыг бэлдэж хангадаг сургуулийн хувь | 76% | 100% |
| | **Зорилт 4.3**<br>• Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авсан сургууль, цэцэрлэгийн тоо | 0 | 53 (22 сургууль, 31 цэцэрлэг) |
| | **Зорилт 4.4**<br>• Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр анхан шатны үйлчилгээ (сургагдсан мэргэжилтэнтэй, үзүүлсэн үйлчилгээний тайлан тогтмолжсон байх) үзүүлж буй сургуулийн хувь. | 0 | 100% |

***Энэхүү таван жилийн хугацаанд хэрэгжих томоохон хөтөлбөр нь 2023 оноос эхлэн хэрэгжинэ.***

# 10. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**

ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧИД:

- **ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН**
- **НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН**
- **НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН**

5 ЖИЛИЙН ХАМТАРСАН ТӨСВИЙН НИЙТ ДҮН: **3,000,000 $**

2022 ОНЫ САНХҮҮЖИЛТ:

- **ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 1,265,472,000 ₮**
- **НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 366,660 $**
- **НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ: 226,260 $**

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

unicef

UNFPA

- Өмнөговь аймаг 71493 суурин хүн амтай, 21989 өрхтэй. Хүн амын 32.8% нь 15 хүртэлх насны хүүхэд, 64.4% нь 16-59 насны иргэд, 3.9% нь 60 ба түүнээс дээш насны иргэд байгаа бөгөөд хүн амын 35.2% нь аймгийн төвд, 3.6% нь сумын төвд, 61.2% нь хөдөө багт суурьшиж байна.
  Халдварт өвчин 2016 онд 10000 хүн амьд 157.0 байсан бол 2020 онд 126.2, харин 2021 оны 10 сарын байдлаар 282.6 тохиолдол бүртгэгджээ. Энэ нь шинэ корона вируст халдварын цар тахалтай холбоотой байна.
  Өмнөговь аймагт халдварт болон халдварт бус өвчлөл өндөр хэвээр байсаар байна. 2020 оны байдлаар нийт нас баралтын 11.4% нь хорт хавдар байна. Мөн чихрийн шижин, зүрх судасны өвчин буурахгүй байгаа бөгөөд осол гэмтлийн тохиолдол жил бүр нэмэгдэж байна. Зам тээврийн осол гэмтэл, нас баралт улсын дундажтай /1.5/ харьцуулахад өндөр /1.9/ байна.
  Аймгийн хэмжээнд 2020 онд 113 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 218 их эмч, 675 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. Улсын хэмжээнд 10000 хүн амд ноогдох сувилагчийн тоо 40.7, аймгийн дундаж 34.9 бол Өмнөговь аймагт 29.1 байгаа бөгөөд 10000 хүн амд ногдох эмчийн тоо улсын хэмжээнд 4.8, аймгийн дундаж 1.8 бол тус аймагт 2.7 байна.
  Өмнөговь аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1800 гаруй иргэн, үүнээс байнгын асаргаатай 280 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 364 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлд хүргэж байгаа гол шалтгаан нь осол гэмтэл (287), нүд (459), мэдрэл (341), сонсгол (459) бэрхшээл, эмгэгүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь Даланзадгад суманд (1015), Гурвантэс (190), Ханбогд (130), Цогтцэций (117), Булган (103), Манлай (102) сумдад амьдарч байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ҮР ДҮНГИЙН ХЭМЖҮҮР:

- Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр нь дараах 4 зорилго, дэд зорилтуудын хүрээнд хэрэгжинэ.

**Зорилго 1.**

Өмнөговь аймгийн хүн амд, ялангуяа зорилтот бүлэг буюу эх хүүхэд, өсвөр үе, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг уртасгана.

| № | Зорилт | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| **Зорилт 1.1** | Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын засаглал, бие даасан байдал, төр, хувийн хэвшлийн түншлэл, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй авах боломжийг нэмэгдүүлсэн байна | 1. Гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж буй эрүүл мэндийн байгууллагуудын хувь<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0%*<br>*Зорилтот түвшин: 15%*<br>*(2026 он(БОЭТ, СЭМТ, ӨЭМТ)*<br><br>*2. Эрүүл мэндийн ажилтны нягтрал*<br>*Суурь үзүүлэлт 2020 онд эмч 10000 хүн амд 2.7, сувилагч 10000 хүн амд 29.1 байна*<br>*Зорилтот түвшин: (2026 он), Улсын дунджид хүргэнэ. Эмч 10000 хүн амд 4.8, сувилагч 10000 хүн амд 40.7 байна* |
| **Зорилт 1.2** | Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нотолгоонд тулгуурлан, орчин үеийн шинэлэг арга технологийг нэвтрүүлэх замаар хэнийг ч орхигдуулахгүй, тэгш хүртээмжтэй хүргэснээр хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Яаралтай тусламж үзүүлэх хугацаа<br>*Суурь үзүүлэлт 2020 он:Тодорхойлогдоно*<br>*Зорилтот түвшин:Улсын дундажтай адил болон түүнээс богино хугацаанд байлгана (2026 он)*<br>2. Хөтөлбөрийн хүрээнд оношилгоо эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн арга, аргачлалын тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: Тодорхойлогдоно.*<br>*Зорилтот түвшин:5-аар нэмэгдүүлнэ (2026 он)* |

| | | |
|---|---|---|
| **Зорилт 1.3** | Нийтийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, халдварт болон халдварт бус өвчний илрүүлгийн сайжруулж, амьдралын зөв дадал, хэвшил төлөвшиж, сэргийлж болох халдварт болон халдварт бус өвчний илрүүлэг сайжирч, нас баралт буурах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 1. Нийтийн эрүүл мэндийн дэмжих төвийн тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:1 (2026 он)*<br>2. Артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин өвчин, хорт хавдрын эрт илрүүлэг<br>*Суурь үзүүлэлт: Артерийн даралт -65.9%, чихрийн шижин-66.7%, хорт хавдар- 53.0% (5 жилийн дундаж)*<br>*Зорилтот түвшин:Артерийн даралт -87%, чихрийн шижин-87.5%, хорт хавдрын-70.0% (2026 он)* |
| **Зорилт 1.4** | Зорилтот бүлэг, ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжруулж, сэргийлж болох эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээний хувь<br>*Суурь үзүүлэлт 2020 он: 50.7%*<br>*Зорилтот түвшин:60% (2026 он)*<br>2. Нэвтрүүлсэн цэвэршилт, үргүйдлийн тусламж үйлчилгээний тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:2 (2026 он)* |
| **Зорилго 2.**<br>Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуй тогтолцоотой уялдуулан, тэгш хүртээмжтэй хүртэх боломж бүрдүүлсэн байна. | | |
| **Зорилт 2.1** | Хүүхэд өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуй тогтолцоотой уялдуулан, тэгш хүртээмжтэй хүргэхэд дэмжлэг үзүүлнэ. | 1. Сургагдсан эрүүл мэндийн багшийн хувь<br>*Суурь үзүүлэлт: Тодорхойлогдоно.*<br>*Зорилтот түвшин: (2026 он): 100%* |

| **Зорилго 3.**<br>Өмнөговь аймгийн хүн ам, зорилтот бүлгийг халамжаас хөдөлмөрт шилжих орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлсэн байна. | | |
|---|---|---|
| **Зорилт 3.1** | Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг өргөжүүлсэн байна. | 1. Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцын удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ-ийн тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 1*<br>*Зорилтот түвшин:3 (2026 он)*<br>2. Аюулгүй сургууль, Аюулгүй дотуур байр аргачлалыг нэвтрүүлсэн сургууль, дотуур байрны тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 7*<br>*Зорилтот түвшин: 21 (2026 он)* |
| **Зорилт 3.2** | Залуучуудын оролцоо, хариуцлага нэмэгдэж, залуучууд бие биеэсээ суралцаж, туршлагаа солилцон, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлсэн байна. | 1. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төвийн тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 6*<br>*Зорилтот түвшин:15 (өссөн тоогоор) (2026 он)*<br>2. Амьдрах ухааны сургалтад хамрагдсан 15-34 насны залуучуудын хувь<br>*Суурь үзүүлэлт 2021 он: Тодорхойлогдоно*<br>*Зорилтот түвшин:30 хувиар нэмэгдүүлэх (2026 он)* |
| **Зорилт 3.3** | Зорилтот бүлгийн хүн ам, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүд, шилжин суурьшигчдад сурах, ажиллах, орлогоо нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд оролцох, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээг олон нийтэд түшиглэн, тэгш хүртээмжтэй хүртэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд байгуулагдсан дэмжих бүлгийн тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:5 (2026 он)*<br>2. ХБИ-д эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын зөвлөгөө мэдээлэл хүргэх сургагдсан Үе тэнгийн сургагчдын тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:30 (2026 он)*<br>3. ХБИ-ийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжихээр байгуулагдсан бүлгийн тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:3 (2026 он)* |

| **Зорилго 4.**<br>Хөдөлгөөнт хүн амд төрийн үйлчилгээг хүргэх загварыг бий болгосон байна. | | |
|---|---|---|
| **Зорилт 4.1** | Ханбогд сумын Хайрхан багийн “Цагаан хад” суурьшлын бүст уул уурхай, тээврийн аж ахуй нэгжүүд, ТББ-тай хамтран ажиллаж, төрийн нэг цэгийн /бичил төр/ үйлчилгээг бий болгон, хөдөлгөөнт хүн амд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх боломжийг дэмжсэн байна. | 1. Суурьшлын бүсэд хийгдсэн судалгааны тоо<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0*<br>*Зорилтот түвшин:1 (2026 он)*<br>2. Хөдөлгөөнт хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь<br>*Суурь үзүүлэлт 2021 он: 0%*<br>*Зорилтот түвшин: (2026 он) хөдөлгөөнт хүн амын 70-аас доошгүй хувийг хамруулсан байна.*<br>3. Хөдөлгөөнт хүн ам оршин байгаа Ханбогд, Цогтцэций сумандаа төрийн үйлчилгээ /эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ/ авах боломж<br>*Суурь үзүүлэлт 2021 он: Боломжгүй*<br>*Зорилтот түвшин: Ханбогд, Цогтцэций суманд төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх (2026 он)* |

***Энэхүү 5 жилийн хугацаанд хэрэгжих хөтөлбөр 2023 оноос эхлэн хэрэгжинэ.***

# 11. “ЭРТ ОНОШИЛНО-ЭРТ ЭМЧИЛНЭ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ:

1. **“АЙ МЕД ТЕХНОЛОЖИС” ХХК**
2. **“МЕДИМПЕКС ИНТЕРНЭШНЛ” ХХК**
3. **3 ДАХЬ БАГЦ АЖИЛД ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА**

ТӨСЛИЙН БАТЛАГДСАН НИЙТ САНХҮҮЖИЛТ: **626,600,000 төгрөг**







## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Мэс заслын тусламж үйлчилгээний хөгжил, дэвшилд хөрөнгө оруулах нь иргэдийн эрүүл энх аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлыг бууруулах, эдийн засагт чухал нөлөө үзүүлэх хэлбэр гэж үзэж байна.
  Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарын нийт төсвийн 70% нь өвдсөн хүмүүсийг эмчлэхэд зарцуулагдаж, хорт хавдрын 70% нь хожуу шатандаа оношлогдож байгаа учир хорт хавдар, гажгийг эрт оношлох, мэс засал, нүд, чих хамар хоолой, судасны мэс засал, ангионрафийн тусламж үйлчилгээг сайжруулан орон нутгийн иргэд аймагтаа оношлогдож, эмчлэгдэх орчин нөхцөл бүрдүүлэхэд анхааран БОЭТөвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад нэн тэргүүнд шаардлагатай байгаа эмнэлгийн багаж хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмжийг нийлүүлэх шаардлагатай байгаа юм.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Урологийн дурангийн хагалгааны багажийн иж бүрдэл, хүүхдийн ходоодны дуран, шүдний дэлгэмэл рентген аппарат, дижитал маммографийн аппарат, нүдний хагалгааны иж бүрдэл, хүчилтөрөгчийн аппарат гэх мэт шаардлагатай багаж, тоног төхөөрөмж нийлүүлнэ.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Уг хөтөлбөрийн гүйцэтгэгч "Ай мед технoложис" ХХК, "Медимпекс интернэшнл" ХХК нар 2 багц тоног төхөөрөмж нийлүүлсэн. "Ай мед технoложис" ХХК Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бүтэн биеийн хүчилтөрөгчийн аппарат, "Медимпекс интернэшнл" ХХК нь хүүхдийн ходоодны дуран тус тус нийлүүлж ажиллагаанд оруулсан.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

1. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг бүрэн хамруулах
2. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.
3. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг 70%-иас дээш болгох
4. Хими эмчилгээг аймагтаа нийт эмчлүүлэгчдийн 20%-д хүргэх зорилтыг хэрэгжүүлэх
5. Мэс засал, хавдар, нүд, сэргээн засах эмчилгээний тусламжийн нэр төрлийг нэмэгдүүлэх
6. Нүдний цус харвалт, гэмтэл, торлогийн эмгэг, хараагүй болоход хүргэх байдлыг эрт оношилно
7. Эрүү нүүр, шүдний бүх төрлийн гажгийг оношилно.
8. Бөөр шээсний зам, түрүү булчирхай, давсаг, шулуун гэдэс, цээж, хэвлийн хөндийн оношилгоо
9. Нүдний мэс заслын 6 төрлийн эмчилгээний аргыг нэвтрүүлнэ.
10. Цөсний зам, мухар олгой, ивэрхий нөхөх хагалгаанаас гадна бөөр, давсаг, түрүү булчирхай, нарийн бүдүүн шулуун гэдэсний бусад, хэвлийн дурангийн мэс заслыг хийнэ.
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, том хагалгааны дараах үе, булчингийн сэргээн засалт, хөдөлгөөн ба сэргээн засал эмчилгээ шаардлагатай иргэдэд сэргээн засах эмчилгээ, хөдөлгөөн засал эмчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.

## 12. "ДЭЛХИЙН ИРГЭД ХАНБОГДООС" ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **"ТИКЕТ ЦЕНТР" ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **239,982,402 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сум нь уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй өрнөж буй суурины хувьд хүн амын тоо сүүлийн жилүүдэд байнга өсөж ирсэн бөгөөд одоогийн байдлаар тус сумын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо 2600-д хүрсэн. Сум орон нутаг, боловсролын салбарын холбогдох байгууллагууд, Оюу толгой компанийн хамтарсан ажлуудын үр дүнд сургууль, цэцэрлэгийн хүртээмж, сургалтын орчин сайжирсаар байгаа хэдий ч хүн амын өсөлт өндөртэй сумын хувьд хэрэгцээ, шаардлага ихтэй хэвээр байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуульд тавилга, сургалтын хэрэгсэл зэрэг 56 нэр төрлийн 687 ширхэг барааг нийлүүлж, англи хэл, сэтгэл зүйчийн кабинет тохижуулна.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор "Дэлхийн иргэд Ханбогдоос" төслийг 245,000,000 (хоёр зуун дөчин таван сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч Ханбогд сумын ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Ханбогд сумын ЗДТГ, гүйцэтгэгч "Тикет центр" ХХК, санхүүжүүлэгч "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан" санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.

### ҮР ДҮН:

- Ханбогд сумын 1, 2-р сургуульд сургалтын таатай орчин бүрдэж багш, сурагчдын ажиллах, сурч боловсрох нөхцөл сайжирна.
- Энэхүү төслийн хүрээнд хийгдэх ажлууд 2023 онд бүрэн хэрэгжиж дуусна.

# ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

## 1. “ЦОГТ-ОВОО СУМЫН 15 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ЭВТ ЦАХИРАЛ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **3,014,716,561 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 оны жилийн эцсийн байдлаар Цогт-Овоо сум нь албан ёсны бүртгэлтэй 1896 хүн амтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай сум юм. Мөн тус сум нь Өмнөговь аймгийн төвөөс Улаанбаатар хот орох төв засмал замын дагуу байршилтайгаас шалтгаалан орон нутгийн иргэд, уул уурхайн ажилчид, гадаад дотоодын аялагч гэх мэт зорчин өнгөрөх иргэдийн тоо харьцангүй ихтэй байдаг тул ердийн сумын эмнэлгээс илүү ачаалалтай ажилладгаас гадна гэнэтийн осол аваарын үед үзүүлэх анхан шатны яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж маш муу байдаг. Тус сумын эрүүл мэндийн төв нь 16 ажилтан, 9 ортойгоор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрүүл мэндийн төвийн барилга нь 2007 онд ашиглалтад орсон 9 ортой тул өрөө тасалгаа, орны тоо хүрэлцдэггүй, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний стандарт хангагдаагүй, эмнэлгийн дотоод халдвар дамжих эрсдэл өндөр, яаралтай тусламж үйлчилгээний үед хүлээлт, дараалал ихтэй зэрэг олон хүндрэлтэй асуудал тулгарч байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилга барьж иргэдэд чанар, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх болон эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга” төслийг 3,106,754,176 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Эвт цахирал” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- 2021 онд “Эвт цахирал” ХХК нь орон нутгийн зах зээлээс 218 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 56 түр ажлын байр бий болгосон.
- 2022 онд “Эвт цахирал” ХХК нь орон нутгийн зах зээлээс 600 гаруй сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 90 түр ажлын байр бий болгосон.
- Барилга угсралтын ажил 2022 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьд хүрэв.

## ҮР ДҮН:

- Цогт-Овоо сум стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгатай болно.
- Эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмж дээшилнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээний орчин нөхцөл сайжирна.
- Эмч, эмнэлгийн ажилтнууд ая тухтай орчинд ажиллана.
- Эмч, ажилчдын ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлнэ.

### 2022 ОНД БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 80 %-Д ХҮРЭВ



## 2. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
НИЙТ ГЭРЭЭНИЙ ДҮН: **10,882,539,341 төгрөг**
Үүнээс 2022 онд: **1,182,059,344 төгрөг**






### ТӨСЛӨӨР ХИЙГДСЭН АЖЛУУД:

1. Барилга угсралтын ажил: **“Аглут” ХХК, 5,795,000,000 төгрөг**
2. Гадна шугам сүлжээний ажил: **“Дужий хайрхан” ХХК, 215,344,809 төгрөг**
3. “Музейн барилгын дотор засал (интерьер), лифт, үүдний гонх барих” төсөл: **“Аглут” ХХК, 2,089,053,404 төгрөг**
4. “Өмнөговь аймгийн музейн барилга барих төсөл”-ийн нэмэлт ажил: **“Аглут” ХХК, 471,702,337 төгрөг**
5. “Музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмж нийлүүлэх”: **“Тангад-араа” ХХК, 137,454,000 төгрөг**
6. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах”: **“Эрдэнийн гүн говь” ХХК, 493,990,000 төгрөг**
7. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн гадна тохижилт”: **“Андгай” ХХК, 148,935,447 төгрөг**
8. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилгын үзмэрийн баяжилт-1”: **Археологийн хүрээлэн, 493,990,000 төгрөг**
9. “Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилгын үзмэрийн баяжилт-2”: **Палеонтологийн хүрээлэн, 200,000,000 төгрөг**
10. “Өмнөговь аймгийн музейн барилгын дотор засал (интерьер), лифт, үүдний гонх барих” төслийн санхүүжилтийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах”, **“Аглут” ХХК, 1,182,059,344 төгрөг**

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт байрлах үзэсгэлэнт байгальтай, говь нутгийн байгаль цаг агаарт зохицсон уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын арвин уламжлалтай нутаг юм. Байгалийн өвөрмөц тогтоц үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал нь аймгийн эдийн засгийн тулгуур салбарын нэг юм. Монгол улсад ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь говь нутгийг үзэж сонирхохоор ирдэг. Эдгээр жуулчдад нутаг орны соёлын өв, говь нутгийн нэрийн хуудас болсон үлэг гүрвэлийн олдвор зэрэг палеонтологийн ховор нандин үзмэрүүдийг үзүүлэхэд аймгийн музейн одоогийн барилгын хүчин чадал хүрдэггүй. Учир нь музейн барилга нь 1954 онд чулуугаар барьсан аймгийн анхны зочид буудал, 1969 онд аж ахуйн аргаар хоёр давхар болгосон барилга юм. Барилгад суулт өгч, хана цуурсан зэрэг эвдрэл гэмтэл нь музейн үйл ажиллагаанд тавигдах MNS 5634:2006 стандартын шаардлага хангахгүй, үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж байна.
  Энэ нөхцөл байдлын улмаас барилгын болон галын улсын байцаагчийн дөрвөн удаагийн дүгнэлтээр үйл ажиллагааг зогсоох шаардлага тавигдаад байгаа. Иймд уг барилгыг музейн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй болсон.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Энэхүү төслийн гол зорилго нь стандартын шаардлага хангасан, барилга архитекторын өвөрмөц шийдэл бүхий музейн барилгыг барьж бүрэн тохижуулан ашиглалтад оруулах юм. Ингэснээр Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгох, гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор "Өмнөговь аймгийн Музейн барилга" төслийг 5,8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор "Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн барилга байгууламжийн нэмэлт ажил" төслийг 3.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 02 дугаар тогтоолоор "Аймгийн шинэ музейн нэмэлт ажил" төслийг 1,2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, төслийн гүйцэтгэгч байгууллагууд тус бүртэй санхүүжилтийн гуравласан гэрээ байгуулав.
- 2021 оны 11 дүгээр сарын 22-нд барилгын ажлыг дуусган ашиглалтад шилжүүлэв.

## ҮР ДҮН:

- Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгоход музей чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.

- Жилдээ 50,000 түүнээс дээш үзэгчдэд соёлын үйлчилгээ явуулах зорилготой бөгөөд, угсаатан зүй-түүхийн болон тэмээний музей, байгалийн музей гэсэн салбаруудтай ажиллана.

## 2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НД ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДРӨӨР ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГОВИЙН БАЙГАЛЬ, ТҮҮХИЙН МУЗЕЙН БАРИЛГЫН НЭЭЛТ БОЛЛОО.






*Нээлтийн үеэр Соёлын дэд сайд М.Батбаяр "Оюу толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэйрдрэ Лингенфэлдерт "Талархал" гардууллаа.*

## 2022 ОНД БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНААС ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГЫГ МОНГОЛ УЛСЫН ОНЫ "ШИЛДЭГ БАРИЛГА"-ААР ШАЛГАРУУЛЛАА.



Шилдэг барилгын шагналыг Барилгын салбарын 96 жилийн ой, "Барилгачдын өдөр-2022" арга хэмжээний үеэр Захиалагч талыг төлөөлж Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, санхүүжүүлэгч "Оюу толгой" компанийг төлөөлж Харилцааны хорооны дарга О.Цэрэннадмид, гүйцэтгэгч "Аглут" компанийн захирал А.Тулга нар гардан авлаа.

# 3. ДАЛАНЗАДГАД СУМЫН 1200 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ХҮННҮГИЙН ГОВЬ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **10,211,387,025 төгрөг** |




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот нь сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл эрс нэмэгдэж байгаатай уялдан сургууль цэцэрлэгийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.
- Даланзадгад сумын 6 сургуулийн 5 нь 2 ээлжээр хичээллэдэг, шинэ төлөвлөлтийн бүс дэх гэр хорооллуудад оршин сууж байгаа 3,193 өрхийн хүүхдүүд сургууль цэцэрлэгтээ 4-6 км холоос явдаг. Энэ нь нийтийн тээвэр хөгжөөгүй тус суманд хүүхдүүд их холоос сургууль, цэцэрлэгтээ явахад бэрхшээлтэй байдаг. Даланзадгад сумaнд 2,591 сурагчийн суудал дутагдаж байгаа зэрэг нөхцөл байдалд үндэслэн төслийг санаачилсан.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлэх, жил бүр хүрээгээ тэлж буй төвөөс алслагдсан гэр хорооллын хүүхдүүдийн сурах нөхцөлийг сайжруулах, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барих” төслийг Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор 4,626,167,267 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 5,585,219,758 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хүннүгийн говь” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

**ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмж нэмэгдэнэ.
- 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Алслагдсан гэр хорооллын сурагчид гэртээ ойрхон сургуульд явах нөхцөл бүрдэнэ.
- 100 орчим шинэ ажлын байр бий болно.

## БАРИЛГА УГСРАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ 45%-ТАЙ БАЙНА.





Ковид өвчин цар тахлын үеийн хорио цээрийн дэглэм хил гаалийн үйл ажиллагаа, барилгын материалын үнийн өсөлт хомсдолоос шалтгаалан барилга угсралтын ажил удааширсан, 2023 онд ашиглалтад орно.

# 4. “ДАЛАНЗАДГАД СУМЫН 200 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ХАНБОГД АРВИЖИХ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **2,880,582,731 төгрөг, үүнээс 2022 онд 682.7 сая төгрөг баталсан.** |






## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж чадахгүй байгаа, зарим хүүхдүүдийн хамрагдаж буй цэцэрлэг гэрээс нь 4-6 км хол байрлалтай байдаг нь хүүхэд, гэр бүлд бэрхшээлтэй байдаг. Даланзадгад сумын Гурван сайхан, Нисэх, Баруун сайхан хорооллын хойд тал, Төгөл зэрэг алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн насны 300 хүүхэд бүртгэлтэй. Улсын стандартаар цэцэрлэгийн нэг ангид 25 хүүхэд хамрагдах ёстой байтал Даланзадгад сумын бүх цэцэрлэгийн дундаж анги дүүргэлт 40 хүүхэдтэй мөн 2020 оны байдлаар дээрх хорооллуудын 136 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа зэрэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөл тааруу байгааг өөрчилж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломжоор хангах шаардлагатай байсан.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулахад дэмжлэг болох.
- Даланзадгад сумын Гурван сайхан хороололд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” төслийг Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор 450,000,000 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 1,765,485,316 төгрөг, 2022 оны 02 дугаар тогтоолоор 682,680,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн

ЗДТГ, гүйцэтгэгч "Ханбогд арвижих" ХХК, санхүүжүүлэгч "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан" санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

**ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Хүүхдүүд гэртээ ойрхон цэцэрлэгт хамрагдана.
- Сургуулийн өмнөх боловсролын хоцрогдол багасна.
- 35 ажлын байр шинээр бий болно.
- Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд бүрийн тоогоор эцэг эхчүүд, асран хамгаалагч нар ажил эрхлэх боломжтой болж өрхийн орлогоо нэмэгдүүлнэ.

## 2022 ОНД БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 90%-Д ХҮРЭВ.







Барилга угсралтын үлдсэн ажил 2023 онд бүрэн хэрэгжиж ашиглалтад орно.

# 5. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **“ММ АРХИТЕКТУР” ХХК**
ГОХДС-С ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **250,000,000 төгрөг**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2015 онд батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь 2030 он хүртэл баримтлахаар боловсруулагдсан боловч тус ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн шатанд сумын хөгжлийн чиг хандлага, хурдцаас шалтгаалан барилга байгууламжийн төлөвлөлт инженерийн шугам сүлжээний төлөвлөлт хийх, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхэд жил ирэх тутам хүндрэл учирч байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын төвийн 4700 га талбайд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, бүс нутаг, хот байгуулалтын болон хөрш зэргэлдээ орших аймаг, сумын хөгжлийн бодлоготой уялдуулан хүн ам татахуйц хэмжээний хот болгон хөгжүүлэх стратеги, төлөвлөлт бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулахад оршино.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” төслийг 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “ММ Архитектур” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийг эхлүүлэв.
- Төслийн ажил 2022 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьд хүрэв.

## ҮР ДҮН:

- Өмнөговь аймаг нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, бүс нутаг, хот байгуулалтын стратеги, төлөвлөлт бүхий 2030 оныг хүртэл баримтлах хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болно.

## ТӨСЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 2022 ОНЫ ЭЦСИЙН БАЙДЛААР 50%-Д ХУВЬД ХҮРЭВ.



# 6. "ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАТА ТӨВ БАЙГУУЛАХ ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА БОЛОВСРУУЛАХ" ТӨСӨЛ (2023 ОНД ҮРГЭЛЖЛЭН ХЭРЭГЖИНЭ)

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"**
БАТЛАГДСАН ТӨСӨВ: **152,000,000 төгрөг**

ГҮЙЦЭТГЭГЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

1. ДАТА ТӨВИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, **"ХЯЗГААРГҮЙ ШУЛУУН" ХХК, 39,900,000 ТӨГРӨГ**
2. ДАТА ТӨВИЙН ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ, **"ЭС АЙ СИ ЭЙ" ХХК, 78,869,670 ТӨГРӨГ**
3. ДАТА ТӨВИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА БИЗНЕС МОДЕЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА ХИЙХ, **"МИРИМ КОНСАЛТАНТ" ХХК, 30,642,500 ТӨГРӨГ**




ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймаг нь  уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарыг түшиглэн хөгжиж буй аймаг тул цаашид орон нутгийн бизнес эрхлэгчдэд уул уурхайтай холбоотой болон холбоогүйгээр үүсэх боломж, эрсдэлийг тооцоолон орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжлийн шинэ түвшинд хүргэн хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулах, үе шаттай хэрэгжүүлэх бодит шаардлага тулгарч байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймагт уул уурхайн бус бизнесийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Дата төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, зах зээлийн судалгаа, бизнес орчны шинжилгээ, бизнес модель боловсруулах бөгөөд дараах ажлууд хийгдэнэ.

  Үүнд:
  - Дата төвийн барилгын зураг төсөв боловсруулна /15*18 м2 харьцаатай 3 давхар барилга/
  - Дата төвийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулна
  - Дата төвийн зах зээлийн судалгаа, бизнес модель, эрх зүйн орчны судалгаа хийнэ.

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн дата төв байгуулах тэзү, зураг төсөл, зах зээлийн судалгаа боловсруулах” төслийг 152,000,000 (нэг зуун тавин хоёр сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь гүйцэтгэгч “Хязгааргүй шулуун” ХХК, “Эс Ай Си Эй” ХХК, “Мирим консалтант” ХХК-уудтай санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийг эхлүүлэв.

## ҮР ДҮН:

- Дата төвийн техникийн шийдэл, ажлын даалгавар, зураг төсөл бүхий баримт бичигтэй болно.
- Өмнөговь аймагт шинээр хөгжих боломжтой гараааны бизнес, мэдээллийн технологийн чиглэлийн компани, төслийг хэрхэн дэмжих стратеги тодорхой болно.
- Орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжилд баримтлах технологид суурилсан, зардал хэмнэсэн, хүртээмжийг ихэсгэх, бүтээмж өсгөхүйц арга техник зэрэг цогц бодлогыг мэргэжлийн түвшинд хөгжүүлэхэд дэмжлэг болох бодлогын баримт бичигтэй болно.

# 7. “НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧ-2021” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
БАТЛАГДСАН ТӨСӨВ: **1,000,000,000 төгрөг**

ГҮЙЦЭТГЭГЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

1. ҮЙЛДВЭРИЙН БҮСИЙН ДЭД БҮТЦИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, **“ГРАНД ЛАЙН ПРОЖЕКТ” ХХК, 128,079,000 ТӨГРӨГ**
2. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮСИЙН 35/10 КВ-ЫН 1*2500 КВА ЧАДАЛТАЙ ДЭД СТАНЦ, 10 КВ-ЫН ХААЛТТАЙ ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ ШИНЭЭР БАРИХ”, **“ХУЯГ ЭРЧИМ” ХХК, 566,635,952 ТӨГРӨГ**
3. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ, КЛАСТЕР, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АЖИЛ”, **“РАДИКС” ХХК, 69,900,000 ТӨГРӨГ**
4. “35 КВ-ЫН ЦДАШ ШИНЭЭР ТАТАХ-(1КМ)”, **“ИХЭР БАЯН ГОВЬ” ХХК, 168,925,023 ТӨГРӨГ**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үйлдвэржилтийн бүсийг тогтоож түүнд үйл ажиллагаа явуулах үйлдвэрийн төлөвлөлтийг гаргасан байдаг. Тус бүсэд барилгын чиглэлийн 7, хөнгөн үйлдвэрийн 8, хүнсний үйлдвэрийн 9, малын гаралтай түүхий эд боловсруулах болон бусад чиглэлийн 30 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулах боломжтойгоор төлөвлөсөн байна. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа хийх тухайн бүсийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, тус бүсийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбох, хангах, аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, төвлөрөн байрлах боломж, бодлогын судалгаа хийх бөгөөд төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:
    - 35 кВ-ын ЦДАШ шинээр татах-(1км)
    - Дэд станц шинээр байгуулах
    - 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж барих, ДЗ станцад 1 гаргалгаа гаргах
    - Үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах
    - Аймгийн хэмжээний үйлдвэрийн нөөц, кластер, бодлогын судалгаа

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Нутгийн үйлдвэрлэгч” төслийг 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь гүйцэтгэгч “Гранд лайн прожект” ХХК, “Хуяг эрчим” ХХК, “Радикс” ХХК, “Ихэр баян говь” ХХК-уудтай санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийг эхлүүлэв.
- 2022 оны жилийн эцэст төслийн нийт гүйцэтгэл 80% -д хүрэв.

## ҮР ДҮН:

- Өмнөговь аймгийн үйлдвэрлэлийн салбар цогц байдлаар хөгжих боломжтой бичиг баримттай болсон.
- Үйлдвэрлэлийн бүс найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан.
- Орон нутгийн иргэдэд тогтвортой, байнгын ажлын байр бий болох суурь тавигдсан.

“Ихэр баян говь” ХХК 2022 оны 12 дугаар сарын 22-нд Даланзадгад сумын үйлдвэрлэлийн бүсэд 35 КВ-ын 1 км цахилгаан дамжуулах шугамыг барьж улсын комисс хүлээлгэн өгсөн.





“Хуяг эрчим” ХХК 2022 оны 12 дугаар 12-нд Даланзадгад сумын үйлдвэрлэлийн бүсэд 35/10 кВ-ын 1*2500 кВА чадалтай дэд станц, 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж барьж улсын комисст хүлээлгэн өгсөн.







## 8. “ЭКО ЖОРЛОН” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА** |
| БАТЛАГДСАН ТӨСӨВ: | **599,994,300 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хог хаягдлын тухай хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх
- “Алсын хараа-2050”, Монгол улсын засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр, Өмнөговь аймгийн хөгжлийн бодлоготой уялдан хэрэгжүүлэх.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Уламжлалт нүхэн жорлонг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй эко жорлонгоор сольж, хөрс, гүний усны бохирдлыг бууруулах, иргэдийн жорлондоо хандах хандлагыг өөрчилж, улмаар нүхэн жорлонгүй анхны аймаг болоход дэмжлэг болох.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Эко жорлон төслийг 599,994,300 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Эко жорлон” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зохион байгуулна.

- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөл 2021 онд "Эко жорлон" төслийн санхүүжилтийг баталсан. Үүний дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ уг төслийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зарласан боловч сонирхсон этгээд тендерт орж ирээгүй. Мөн цар тахлын үеийн хил гаалийн дэглэм, инфляцаас шалтгаалан бараа материалын үнэ нэмэгдсэн учир төслөөр хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагатай болсон.

## ҮР ДҮН:

- Даланзадгад, Цогт-Овоо, Хүрмэн, Номгон сумын айл өрх болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны гаднах нийтийн бие засах байгууламжийг шинэчилж 80ш, аялал жуулчлалын гол бүс нутагт 35 ш эко жорлон байгуулж, 1,000 ба түүнээс дээш насанд хүрэгсэд болон хүүхдүүд төслийн үр шимийг хүртэнэ.

# САНХҮҮЖИЛТИЙН КВОТ

## САНХҮҮЖИЛТИЙН КВОТ, ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон уул уурхайгүй сумдад (хамтад нь "Зорилтот сумд" гэх) квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн иргэд, зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.

Тухайн жилд Түншлэгч болон уул уурхайгүй сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- Ханбогд сум 70,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Манлай, Баян-овоо, Даланзадгад сумд 50,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Уул уурхайгүй сумд тус бүр 30,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот

| № | Зорилтот сумын нэр | 2022 онд нийт хуваарилах боломжит санхүүжилт | 2022 оны гүйцэтгэл | Үлдэгдэл санхүүжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Ханбогд сум | 217,060,191 | - | 217,060,191 |
| 2 | Манлай | 146,220,040 | 138,445,300 | 7,774,740 |
| 3 | Баян-Овоо | 163,101,225 | 162,551,700 | 549,525 |
| 4 | Даланзадгад | 175,497,230 | 159,689,000 | 15,808,230 |
| 5 | Баяндалай | 122,646,081 | 111,885,500 | 10,760,581 |
| 6 | Сэврэй | 88,930,800 | 86,969,000 | 1,961,800 |
| 7 | Булган | 91,981,415 | 91,700,000 | 281,415 |
| 8 | Номгон | 90,616,400 | 79,892,136 | 10,724,264 |
| 9 | Цогт-Овоо | 88,020,600 | 86,125,000 | 1,895,600 |
| 10 | Мандал-Овоо | 111,647,720 | 87,500,000 | 24,147,720 |
| 11 | Хүрмэн | 177,151,301 | 156,618,500 | 20,532,801 |
| 12 | Цогтцэций | 87,507,300 | - | 87,507,300 |

# 2022 ОНД МАНЛАЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. "УЛАМЖЛАЛТ СЭРГЭЭН ЗАСАХ КАБИНЕТ" ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"**
ГҮЙЦЭТГЭГЧ: **Г.ШИНЭБАЯР**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **20,000,000 төгрөг**




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай суманд амьдарч байгаа эмнэлгийн хяналтад байдаг өвчтөнүүдийн мэдээллийг Манлай сумын Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэлээс авч ангилж үзвэл:

| Өвчтөний төрөл | Он | | |
|---|---|---|---|
| | 2019 | 2020 | 2021 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 112 | 113 | 116 |
| Тархинд цус харвалтаар хяналтад байдаг өвчтөн | 13 | 11 | 12 |
| Артерийн даралт ихсэх өвчнөөр | 515 | 518 | 920 |
| Осол гэмтэл | 42 | 39 | 62 |
| Нурууны мэдрэлийн эмгэгтэй | 45 | 83 | 62 |

Дээрх хүснэгтээс харахад жил ирэх тусам өвчлөлийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна. Тиймээс сумын хүн эмнэлэгт уламжлалтын эмчилгээ хийх тоног төхөөрөмжүүд зайлшгүй шаардлагатай байна.

- Уламжлалт эмчилгээ хийх кабинеттай болсноор 7 хоногийн ажлын 5 хоногт 5 удаа сумын эрүүл мэндийн төвд хянагдаж буй болон үйлчлүүлж буй иргэд тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд хөтөлбөрийн дагуу эмчилгээ, үйлчилгээ үзүүлж эмчилгээний явц, үр дүн, барих гам зэрэг зөвлөмж сургалтыг үе шаттай зохион байгуулж, гам бариагүйгээс үүсэж болох хүндрэлээс сэргийлэх зөвлөгөө мэдээллийг цахим мэдээлэл хаягаар дамжуулан тогтмол зохион байгуулахад дэмжлэг болох юм. 2022 онд уламжлалт эмчилгээ болон сэргээн засах кабинетаар давхардсан тоогоор 283 хүн үйлчлүүлсэн.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын эрүүл мэндийн төвд уламжлалт, сэргээн засах эмчилгээний кабинеттай болох, цаашлаад тасагтай болсноор ажил хөдөлмөрийн хүнд нөхцөл болон өвчин эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалттай болох эрсдэлтэй хүмүүсийн бие сэтгэц, нийгмийн харилцаанд дасан зохицох хэрэгцээт мэдлэг чадварыг бий болгож амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгэм эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр ард иргэдийн амьдралын чанар дээшилж, хөдөлмөрийн чадвар алдалтын тоо болон хувь тогтвортой буурахад төслийн зорилго оршино.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын эрүүл мэндийн төвд уламжлалт сэргээн засах кабинет байгуулж, хүзүү нурууны татлагын ор, хэт улаан туяаны шарлагын аппарат суурилуулж бумба, төөнүүр, зүү зэрэг шаардлагатай хэрэгслүүдийг нийлүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ард иргэдийн хөдөлгөөний хомсдол, бэртэл, гэмтэл, өвчин эмгэг, ажлын байрны нөхцөл байдал, онцлогоос үүсэн бий болох өвчнөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх эмчилгээг хийх таатай орчин бүрдсэн.
- Эмчийн зөвлөсний дагуу эмчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчдэд сувилгаа хийхэд хэрэгцээтэй тоног төхөөрөмжтэй болсноор эмчилгээний үр дүн, өгөөж нэмэгдэнэ.



## Сэтгэгдэл Манлай сумын ЭМТ-ийн эмч Г.Шинэбаяр:



*“Уламжлалт,сэргээн засах кабинет тохижуулах” төсөл хэрэгжиж олон нийтийн эрүүл мэндэд хэрэгцээтэй тоног төхөөрөмжөөр хангагдаж тусламж үйлчилгээ үзүүлэх болсондоо баяртай байна. Төсөл дэмжиж санхүүжилт олгосон Говийн Оюу ХДС-даа талархъя. Та бүхэндээ баярлалаа.*

## Сэтгэгдэл Далай багийн малчин Адъяа овогтой Отгонбаяр:



*Манай сумын хүн амын дунд даралт ихсэлт, жин цохих, хүзүү толгой хөших, нурууны суулт зэрэг өвчлөл их байдаг. Эдгээр өвчний эсрэг тэмцэх тоног төхөөрөмжтэй болсонд маш их баяртай байна. Энэхүү төслийг хэрэгжүүлсэн эмчдээ баярлалаа. Энэ ажлыг нь дэмжиж санхүүжилт олгосон Говийн Оюу хөгжлийг дэмжих санд талархал илэрхийлье.*

## 2. “ОЙН ЗУРВАСЫН УСАЛГАА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **Д.УУГАНБАЯР**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **16,000,000 төгрөг**






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын зүүн хойд талд шинээр ойн зурвас байгуулсан. Тухайн ойн зурвас нь услалтын системд холбогдоогүй тул нөөцийн сав автомашинаар ус зөөж усалдаг. Зөөврийн усаар услахад тээвэр шатахууны зардлаас эхлээд урсгал зардал өндөр гарч байна. Иймд шинээр байгуулсан ойн зурвасыг усалгааны нэгдсэн системд холбох шаардлага үүсэж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Шинээр байгуулагдсан ойн төглийг услалтын нэгдсэн системд холбож сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх усалгааны зардлыг бууруулна.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын зүүн хойд талын модны талбай руу 400м урт усалгааны системийг суурилуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын төвийн тодорхой хувийг ойжуулж ногоон байгууламж байгуулснаар зуны улиралд сумын нутаг дэвсгэрт орон хур тунадасны хэмжээ нэмэгдэх, цаашлаад сумын өнгө үзэмжид сайнаар нөлөөлж чийглэг уур амьсгал бий болоход дэмжлэг үзүүлнэ.
- Мөн хөрсний чийгийг хадгалснаар хөрсний элэгдлийг бууруулж, элсний нүүдлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

# 3. “СТАНДАРТАД НИЙЦСЭН ТОХИЛОГ АЖЛЫН БАЙР” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **М.МӨНХЖАРГАЛ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **20,000,000 төгрөг** |




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн үйлчилгээнд чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилго зорилтыг улс, аймгийн хэмжээнд дэвшүүлж байгаа өнөөгийн нөхцөлд бид төрийн үйлчилгээндээ энэхүү стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийлгэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Мөн тохилог ажлын байрыг бий болгох шаардлага байна.
- Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээг авна
- Энэхүү төсөл хэрэгжсэнээр төрийн үйлчилгээнд олон улсын стандарт нэвтэрч, ажлын уялдаа холбоо, мэдээллийн чанар, хүртээмж нэмэгдэж, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэдийн сэтгэл ханамж дээшлэх боломж бүрдэнэ.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Олон улсын стандартыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж, мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийлгэж, орон нутгийн ард иргэдэд

төрийн үйлчилгээг түргэх шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээлэх боломж, үйлчилгээний тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн сэтгэл ханамжийг тасралтгүй нэмэгдүүлнэ.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын ЗДТГ-т ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх иргэдэд хүргэх цэгийг байгуулсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хэрэглэгчийн сэтгэл ханамж тасралтгүй өсөн нэмэгдэнэ.
- Мэдээллийн ил тод байдал хангагдана.
- Төрийн албан хаагчдын харилцаа хандлага, ажлын уялдаа холбоо сайжирна.
- Иргэд төрийн үйлчилгээг тав тухтай орчин нөхцөлөөс авах боломж бүрдэнэ.
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
- Тохилог тав тухай ажлын байр бий болно.

## 4. “ЭКО ХОГИЙН САВ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **М.ЦЭРЭНСОДНОМ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **7,000,000 төгрөг** |







### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн үед дэлхий нийтийн өмнө тулгамдаад байгаа томоохон асуудлуудын нэг бол хог хаягдал юм. Ялангуяа хуванцар хог хаягдал урт хугацаанд байгальд оршин байдаг, бүрэн задарч дуустлаа олон арван жил хүрээлэн буй орчныг бохирдуулан, хорт бодис ялгаруулсаар байх юм. Манлай сумын төвийн хэмжээнд хаягдаж буй хог хаягдлын багагүй хэсэг нь ус, ундааны хуванцар сав байдаг. Сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын төлөвлөгөө, байгаль орчны газартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2-р зорилт арга хэмжээ-Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах зорилтын 2.6 дахь заалтад тусгасны дагуу сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд хуванцар сав ангилах хогийн хаягдлын сав байршуулах юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Хуванцар сав ангилан ялгаж сумын төвийн эко орчныг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, хуванцар савыг борлуулж, дахин боловсруулах цехэд нийлүүлнэ.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын төвд хуванцар цуглуулах хогийн савыг Наадмын талбай, Дэмүүлийн хөшөөний урд талын тоглоомын талбай, том машины талбай, соёлын төвийн гадна талбайд байрлуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын хүн ихтэй газруудад хуванцар сав тусгайлан цуглуулах хогийн сав байршуулснаар ус, ундааны хуванцар савыг бусад ахуйн хог хаягдлаас ангилан ялгах, улмаар дахин боловсруулах цехэд өгснөөр сумын төвийн хог хаягдал багасаж, иргэд хэрэглэхгүй хуванцар саваа зориулалтын ангилан ялгах хогийн саванд хийж хэвшинэ.

# 5. “УНДНЫ УСНЫ ШҮҮЛТҮҮР” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **П.БАТБАЯР**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **10,000,000 төгрөг**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ус нь газрын гадаргын хөрс шороо, хад чулууны завсраар урсах явцад металлын давсыг уусгаснаар хатуулагтай ус болдог. Усанд уусдаг давс нь гэр ахуйн хэрэгсэл болон усны хоолой дотор хананд хуралдан өнгөр болж тогтдог. Манлай сумын Орос ангийн худгийн ус нь цахилгаан дамжуулах чанар (EC) болон натрийн (NA+) ионы агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж байгаа хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад 200мг/л гэсэн шаардлагыг хангахгүй байна. Натри нь усны үндсэн катионуудын нэг бөгөөд хүний мэдрэлийн үйл ажиллагаа, булчингийн ба зүрх судасны тогтолцоо болон эсийн дотор ба гаднах орчны осмос даралт, усны хүчиллэг, шүлтлэг орчныг тогтмол байлгахад зохих ёсоор нөлөөлж байдаг. Ус буцалгагч, ус халаагчаас эхлээд гэр ахуйн хэрэгслүүдэд өнгөр тогтсоноор ашиглалтын хугацаа багасаж, үйл ажиллагаа нь доголдоно. Мөн хүний цусны ийлдэсний (Na+) натрийн хэмжээ ихсэх үед ам цангах, тэнцвэр алдагдах, цочимтгой болох, ухаан санаа самуурах зэрэг илрэлүүд тохиолддог. Цаашид натрийн агуулга ихтэй усыг унд ахуйд хэрэглэхэд тохиромжгүй юм. Иймд шүүлтүүр бүхий ус цэвэршүүлэн эрдэс бууруулах төхөөрөмжийг ундны усны эх үүсвэрт суурилуулсан усыг цэвэршүүлэн зөөлрүүлж ашиглах шаардлагатай байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сум орон нутгийн ард иргэдийн хүрээлэн буй орчин ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлыг хангасан цэвэршүүлсэн устай болох нь энэ төслийн гол зорилго болно.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын төвийн иргэд ихээр үйлчлүүлдэг худагт ус цэвэршүүлэн зөөллөх шүүлтүүр байршуулсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын иргэдийн өдөрт хэрэглэх усны хэрэглээ цэвэршүүлсэн усаар хангагдана.
- Хүнсэндээ шүүсэн ус хэрэглэснээр эрдэс, давсны илүүдлээс сэргийлнэ.

## Сэтгэгдэл Манлай сумын иргэн Б.Эрдэнэбаяр:



*Манайх энэ худгийг энд баригдсанаас хойш ундны усаа авч хэрэглэж ирсэн. Хужир давс ихтэй ус уудаг байлаа. Харин энэ төхөөрөмжийг энэ худагт байршуулснаас хойш ундны усны давс хужир нь мэдэгдэм багасаж хоол унд ахуй хэрэглээндээ хэрэглэхэд хамаагүй дээр болсон. Сумын бүх худаг ийм төхөөрөмжтэй болчихвол сумын ард иргэдийн эрүүл мэндэд ч сайнаар нөлөөлнө гэж бодож байна.*

## 6. “ДОТУУР БАЙР – ТАВ ТУХТАЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **Х.СОДБАЯР**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **23,228,000 төгрөг**






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын дотуур байр нь 1977 онд ашиглалтад орж, түүнээс хойш одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. 2007 онд дотуур байранд дотоод тохижилтын ажил хийснээс хойш нэмэлт тохижилт хийгдээгүй тул өрөө тасгуудын тохижилт шаардлага хангахгүй байгаагаас гадна хүүхдийн хэрэглэдэг эд хогшил, тоног төхөөрөмжүүд нь олон жил ашигласны улмаас элэгдэж муудан ашиглах боломжгүй болсон тул нэн тэргүүнд солих шаардлагатай байгаа юм.
- Дотуур байранд амьдрах хүсэлтэй хүүхдүүд олон байдаг боловч дотуур байрны тохижилт муу, одоогийн байгаа хэрэглэл материал тоног төхөөрөмж нь хүрэлцэхгүй, мөн одоо ашиглагдаж байгаа хэрэгсэл нь чанарын шаардлага хангахгүй байгаагаас шалтгаалан хөдөөгийн айлын хүүхдүүд дотуур байранд бүрэн хамрагдаж чадахгүй, хүүхдүүдийн эцэг эхийн аль нэг нь сумын төвд гэр барин хүүхдээ харж суух, нөгөө нь хөдөө малаа маллаж байна. Хэрэв энэ асуудлыг шийдвэл дотуур байранд амьдрах хүүхдийн тоо нэмэгдэж, илүү олон хүүхэд хамрагдах боломжтой гэж үзэж байна. Дотуур байрыг бүрэн тохижуулах, хүүхэд бүр ая тухтай амьдрах нөхцөл бололцоог ханган ажиллахыг мэргэжлийн хяналтын шалгалтаар удаа дараа шаардаж сануулсан. Гэвч асуудлыг шийдэх санхүүжилт байхгүй гэсээр олон жил болж байгаа юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Дотуур байрны тохижилтыг сайжруулж, хүүхэд бүр тав тухтай өөрийн гэртээ байгаа мэт орчныг бүрдүүлэх.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын ЕБС-ийн дотуур байранд ширээ сандлын ком, ханын босоо толь, буйдан, хувцасны өлгүүр, номын тавиур, оюун ухааны тоглоом зэрэг хэрэгслийг нийлүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Дотуур байрны хүүхдийн амьдрах амрах тав тухтай эрүүл орчин бүрдэнэ.
- Багш ажлын байрандаа хөгжих, ажиллах таатай орчин бүрдэнэ
- Хүүхдүүд чөлөөт цагаараа зурагт үзэх, цаг үеийн мэдээ мэдээллийг цаг тухайд нь авч байх боломжтой болно.

# 7. “ХУЖИР ШҮҮ ТАРИХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **Б.ЖААЛХҮҮ**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **12,217,300 төгрөг**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын Жаргалант баг нь 189 малчин өрхтэй. 58.0 мянган толгой малтай, сумын баруун урд хэсэгт оршдог баг юм. Говийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг уг баг нь Шанхайн хэцийн зүүн үзүүр хэсэгт байршилтай бөгөөд говьд ургадаг багалуур, бударгана, хужир шүү ургадаггүй нутаг юм. Тухайн газарт мал аж ахуйн эрхлэн 27 өрх амьдардаг бөгөөд эдгээр өрхийн 15,470 толгой мал нутаглаж байна. Малын говьсоо гаргах ургамал, хужир шүү дутмагаас малын тарга тэвээрэгт муугаар нөлөөлөх, хөрш зэргэлдээ сумаас өндөр өртөг зардалтайгаар хужир шүү тээвэрлэн авч ирэн малдаа өгдөг ч малчдын хувьд санхүүгийн хүндрэлээс шалтгаалан тэдийлэн тогтмол авч чаддаггүй байна. Дээрх хүндрэлээс гарах гол арга нь лаг шавартай “Гүнзгийн тойром”-ыг ашиглан хужир ургуулах бөгөөд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хужир шүү тарьж ургуулсан туршлагыг Манлай суманд хэрэгжүүлэх юм.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Жаргалант багийн нутаг “Гүнзгийн тойром”-д хужир шүү тарих ажлыг зохион байгуулах,
- Тойрмыг хашаажуулан, ургуулж буй хужрыг байнгын усалгаатай байлгах,
- Хужир ургуулж, тухайн бүс нутгийн малчдын хэрэгцээг бүрэн хангах зорилготой.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Гүнзгийн тойромд байх хуучин худгийг сэргээн, шаварлаг газрыг хашаажуулан хужир тариалсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хужир тариалснаар 27 малчин өрхийн 15,470 толгой малыг хангана.
- Малын тарга тэвээрэг нэмэгдэнэ.



## Сэтгэгдэл Манлай сумын иргэн Б.Жаалхүү:



*Хужир шүү тариалах төсөл хэрэгжүүлэгч Б.Жаалхүү миний бие энэхүү төслөөр нутгийнхаа ард иргэдийг хамгийн хэрэгцээтэй хужир шүүтэй болгосондоо маш их баяртай байна. Намартаа тариалсан хужир шүүгээ хавраас хурааж малчдад тараана. Төсөл дэмжиж санхүүжилт олгосон Говийн оюу хөгжлийг дэмжих сандаа гүнээ талархъя, та бүхэндээ маш их баярлалаа.*

## Сэтгэгдэл Жаргалант багийн малчин Батхүү овогтой Баттөр:



*Манай багийн оршин буй газар хужрын дутагдал асар их байдаг. Говь гэж байдаггүй асар их холоос хужир шүү татдаг байсан бол одоо маш их зардал хэмнэж, гаднаа шахуу ойролцоо хужиртай болж бага зардлаар малаа хужирлуулах болсондоо маш таатай байна. Энэ ажлыг хэрэгжүүлж ажилсан буянтан нутгийн Жаалхүү танд баярлалаа. Энэ ажлыг нь дэмжиж санхүүжилт олгосон Говийн оюу хөгжлийг дэмжих санд баярлалаа.*

# 8. "НОГООН ТӨГӨЛ" ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"**
ГҮЙЦЭТГЭГЧ: **Н.ДЭЛГЭРБАТ**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **20,000,000 төгрөг**




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сумын төвийн ашиглагдаагүй талбайг ашиглан ногоон төгөл байгуулснаар хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрийг хадгалж, хүн ард эрүүл амьдрах таатай орчныг бүрдүүлэхийн хамт байгалийн болзошгүй үер усны болон ган зудын аюулыг бууруулахад онцгой ач холбогдолтой.
- Таримал ойн хөрсний өнгөн хэсэгт бүрэлдэх хөвхөн давхраа нь усыг шингээж хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалж гол горхины усыг жигд тогтмол тэжээж үерийн аюулыг багасгана.
- Ногоон төгөлтэй болох нь олон талын ашиг тусгай экологийн тэнцвэрт байдлыг хангахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг учир түүнийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, арчлан хамгаалах хэрэгтэй.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Манлай сумын 1 га газарт сумын ногоон төгөл байгуулагдсанаар орчны агаарын бохирдолтыг бууруулах, тоосжилтыг багасгах, чийгшил нэмэгдүүлэх, агаарыг цэвэршүүлэх, дуу чимээг багасгах зэрэг байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангахад хувь нэмэр оруулна.
- Ногоон төглийн ажилд орон нутгийн иргэдийг татан оролцуулж ажлын байр бий болгоно. Мөн сумын аж ахуй нэгж албан байгууллагууд айл өрхүүдийг хямд үнэтэй модны тарьц суулгацаар хանган мод тарих арга барилд сурган экологийн боловсрол эзэмшүүлнэ.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай суманд мод тарьсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- 350-400ш мод суулгаж, арчилж тордож ургуулснаар элсний нүүдэл болон цөлжилтийг багасгахад хувь нэмэр оруулна.
- Тоос шороогүй хоггүй орчин бүрэлдэнэ.

# 9. “ЦАГ УУРЫН ӨРТӨӨНИЙ АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **А.ОДОНТУЯА**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **6,000,000 төгрөг**






## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын цаг уурын өртөө нь 1962 онд байгуулагдсан. Өртөөний эрхлэгч, 4 ээлжийн техникч, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хоногийн 24 цагийн турш тасралтгүй ажиллаж, Манлай сумын цаг агаарын орчны мэдээг /агаарын хэм, даралт, салхины хурд, үүлний үзэгдэх орчин г.м/ Өмнөговь аймгийн Цаг уур орчны шинжилгээний төвд 3 цаг тутам дамжуулдаг. Цаг агаарын орчны мэдээнээс гадна хөдөө аж ахуйн ургамал, бэлчээрийн даацын мэдээг 3-10 сарын хооронд мөн дамжуулдаг. Цаг уурын өртөө нь Манлай сумын төв цэгт оршин байдаг байгууллага боловч одоог хүртэл цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбоогүй, гадаа модон жорлон ашиглаж, хэрэглээний усаа зөөврийн усаар хангаж байгаа сумын цорын ганц албан байгууллага юм. Тиймээс цаг уурын өртөөг цэвэр, бохирын шугамд холбож, ажиллах таатай орчин бүрдүүлэх шаардлага тулгараад байна. Боловсон хэрэглээтэй газарт боловсон харилцаа үүснэ.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Албан байгууллагын ажилчдын тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, мөн сумын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлөх модон жорлонгийн тоог цөөлөх, орчны хөрс бохирдуулахгүй байхад оршино.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын цаг уурын өртөөний ариун цэврийн өрөөг тохижуулж, цэвэр бохирын шугамд холбосон.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Байгууллагын 5 ажилтны ажлын орчин сайжирснаар малчид, иргэдэд мэдээ мэдээллээ хүргэхэд амар болно.

## Сэтгэгдэл Манлай сумын цаг уур өртөөний дарга А.Одонтуяа:




*“Цаг уурын ариун цэврийн өрөөний дотор тохижилтын” төсөл хэрэгжүүлж ажилчдын эрүүл ахуйн хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангагдаж, ажил үйлчилгээ явуулах таатай орчин бүрдсэнд баяртай байна.*

***Манлай сумын Цаг уурын өртөөний техникч: С.Түвшин-Алдар:***

*Манай сумын төрийн албаны байгууллагуудын дунд цэвэр бохирын төвлөрсөн шугамд холбогдоогүй ганц байгууллага үлдээд байсан нь ийнхүү холбогдсонд маш их баяртай байна. Энэхүү төслийг хэрэгжүүлсэн Өртөөний даргадаа болон энэ ажлыг нь дэмжиж санхүүжилт олгосон Говийн Оюу хөгжлийг дэмжих санд талархал илэрхийлье.*

# 2022 ОНД БАЯН-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “АЯЛГУУ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ШАНХ ЧАНДМАНЬ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **10,200,000 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн 20 жил Баян-Овоо сумын соёлын төв мэргэжлийн хөгжмийн багшгүй байсан, хөгжим, хөгжмийн зэмсгийн хангалт бага байсан учир хөгжмийн боловсрол олгох сургалт, дугуйлан хичээллээгүй, мэргэжлийн хөгжмийн багштай болсон ч хөгжмийн сургалтууд зохион байгуулахад хөгжим, хөгжмийн зэмсэг дутагдалтай байгаа учраас эхний ээлжид нэн шаардлагатай хөгжмийн зэмсгийг худалдан авах хэрэгцээ шаардлагатай болсон.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Соёлын төвийн хөгжим, хөгжмийн зэмсгийн хангалтыг нэмэгдүүлэх, хүүхэд багачууд, залуучууд, иргэдэд хөгжмийн боловсрол олгох, дээшлүүлэх, үндэсний урлаг, өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын соёлын төвд их хуур, бөмбөр, лимбэ хөгжим тус бүр 1 ширхэг, морин хуур 12 ширхгийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Соёлын төвийн хөгжмийн зэмсгийн хүртээмж нэмэгдсэн.
- Сурагчид, залуучууд, иргэдэд хөгжмийн дугуйлан хичээллэх боломжтой болсон.
- Үндэсний урлагийг хөгжүүлж, сурталчлан хөгжмийн боловсрол эзэмших хүүхэд, насанд хүрэгчдийн тоо нэмэгдэнэ.
- Төрөл бүрийн хөгжмийн сургалтууд хичээллэнэ.
- Сурагчид, насанд хүрэгчид улс, аймаг, бүсийн тэмцээнд оролцох боломжтой болно.
- Үндэснийх хөгжим, урлаг, өв соёлыг сурталчилж, түгээн дэлгэрүүлнэ.



## 2. “ӨРХ БҮР ҮЙЛДВЭРЛЭГЧ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **“ИХ ГУРВАН СИ” ХХК**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **90,000,000 төгрөг**




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд өрхийн хэрэгцээнд хүнсний нарийн ногоо тарих иргэдийн тоо өсөх хандлагатай байна. Гэвч хүлэмжийн үнэ ханш өссөн, зах зээлийн хямралтай энэ үед тариалан эрхлэх хүсэлтэй өрх бүр хүлэмж худалдан авч тариалалт хийхэд хүндрэлтэй байна. Баян-Овоо сумын 2020-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, Өсөлтийг өрх бүрд хөтөлбөрт тусгагдсаны дагуу хөтөлбөрийн хүрээнд газар тариалан эрхлэгчдийг дэмжих, өрхийн тариалалтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Иргэдийн газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хүрээнд сумын 20 өрхийг хүлэмжээр хангах бөгөөд хүлэмжийн үнийг 100% хөнгөлөх юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цаашлаад иргэдийн өрхийн орлого нэмэгдэх, иргэдийн талбай өөрсдийн гараар хүнсний ногоогоо тариалж сурах, тариалан эрхлэгч сум болох зорилготой. Газар тариалан эрхлэгч иргэдэд хөнгөлөлттэй хүлэмж олгосноор сумын хэрэгцээнд өрхийн тариалан эрхлэгч иргэд хамгийн багадаа 12 га-аар өсөх, цаашлаад нийтээрээ хүнсний ногоогоо нутгийн хөрсөндөө өрхийн үйлдвэрлэгч тарьдаг газар тариалан эрхлэгч сум болно.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 10м х 6м хэмжээтэй 20 ширхэг нийлэг материалтай зуны хүлэмж нийлүүлж, сумын иргэдэд олгоно.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

Төслийг хэрэгжүүлснээр дараах ач холбогдол, үр өгөөжтэй.

- Газар тариалан эрхлэгч 20 өрхөд бодит дэмжлэг болно.
- Орон нутгийн тариалан эрхлэгч нэмэгдэнэ.
- Шинээр 12 газарт тариалалт хийгдэнэ.
- Өрхийн орлого нэмэгдэнэ.

## Сэтгэгдэл Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Б.Амарзаяа:



*Сүүлийн жилүүдэд манай суманд хүлэмжээр ногоо тариалах хүсэлтэй иргэд олон болсон. Энэ нь иргэд өрхийн хэрэгцээндээ ногоогоо тариалан идэх цаашлаад өрхийн орлоготоо нэмэр болох сайн талтай байгаа. Манай сумын хувьд 2018 онд "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-гийн санхүүжилтээр "Хөрс эрдэнэ" хөтөлбөр хэрэгжүүлэн газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдээ дэмжиж байна. Энэ жил "Өрх бүр үйлдвэрлэгч" хөтөлбөрийн хүрээнд 6*10метр хэмжээтэй 20 ширхэг хүлэмж нийлүүлэгдсэн. Үүнд тус хөтөлбөрийн хариуцан ажиллаж байгаа миний хувьд, цаашлаад газар тариалан эрхлэх хүсэлтэй байгаа иргэдэд маш том дэмжлэг болж байгаад талархаж байна. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.*

## 3. “ИРЭЭДҮЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ИНЖЕНЕРҮҮД” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Б.БАТЗАЯА** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **19,939,200 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын ЕБС-ийг төгссөн сурагчдаас математик, физикийн хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн сурагчдын үнэлгээг сүүлийн гурван жилээр судалж үзэхэд нийт 10 сурагч, үүнээс математик-9, физик-1 сурагч өгсөн судалгаа байна. Эдгээр сурагчдаас элсэлтийн ерөнхий шалгалтад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах босго хангасан сурагч гараагүй байна. Иймд эдгээр сурагчид ямар нэгэн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж чадаагүй байна. Үүнээс үзэхэд математик, физикийн хичээлийн стандартыг сайжруулах, туршилтад суурилсан байгалийн ухааны хичээлийг чанартай зохион байгуулах шаардлага үүсэж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Туршилтад суурилсан байгалийн ухааны хичээлүүдийг чанартай зохион байгуулах, чанарын шаардлага хангасан хичээлийн хэрэглэгдэхүүнтэй сургалтыг зохион байгуулж ирээдүйн инженерүүдийг бэлтгэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн физик, математикийн кабинетад хичээлд хэрэглэгдэх хичээлийн хэрэглэл 220, ном сурах бичиг 44, техник хэрэгсэл, хичээлийн хэрэглэл зэрэг 266 ширхэг бараа нийлүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Математик, физикийн хичээлүүдийн хэрэглэгдэхүүнээр хангагдсан.
- Тоолох, ангилах, тооцоолох, бүртгэх, зохион бүтээх, зурах, эрэл хайгуул хийх, бүтээлчээр сэтгэх, загварчлах, зохиомжлох, математик сэтгэлгээг хөгжүүлэх гоо зүйн хүмүүжил олгох, шинжлэх ухааны суурь олголтыг эзэмшүүлэх, ойлголттой болно.
- Сурагчдын шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлж, сурагчдыг хөгжүүлнэ.
- Сэтгэн бодох, техник, бүтээлч сэтгэлгээг дээшлүүлснээр тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах боломж нээгдэнэ.
- Байгалийн ухааны хичээлүүд туршилтад суурилан явагдана.



## Сэтгэгдэл

**Баян-Овоо сумын Б.Доржийн нэрэмжит 9-н жилийн сургуулийн Математикийн багш Г.Мөнгөн-Эрдэнэ:**



*Математик физикийн кабинет тохижуулах төслийг санхүүжүүлэн дэмжсэн "Говийн оюу" хөгжлийг дэмжих сангийн хамт олонд бяцхан шавь нарт минь оюуны хөрөнгө оруулалт хийж өгсөнд маш их баярлаж талархаж байна. Нийт 19.9 сая төгрөгийн санхүүжилтээр математик, физикийн хичээлийн хэрэглэгдэхүүн, ном гарын авлага зэрэг нийт 150 хэрэгслээр хангаж, хүүхэд багачуудын ирээдүйд маш үр өгөөжтэй оюуны хөрөнгө оруулалт болсон. Та бүхэндээ ажлын өндөр амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг хүсье.*

# 2022 ОНД ДАЛАНЗАДГАД СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ОЮУ ШҮД” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧИД:

1. **“БҮТЭНЖАРГАЛ” ХХК**
2. **“ЖАРГАЛЫН ЭХ БУЛАГ” ХХК**
3. **“МАНАЛ ГОВЬ” ХХК**
4. **“ХАТАНЗАЯАТ ГОВЬ” ХХК**
5. **“ХЭРМИЙН ЦАХИУР” ХХК**

5 БАГЦ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ НИЙТ ДҮН: **99,759,000 төгрөг**




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 онд Даланзадгад сумын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн 72.2% нь шүдний өвчтэй, 11.4% нь шүдний зуулт, шүдний эгнээ тэгш бус, шүд орсгой зэрэг гажигтай байсан. 2022 оны мэргэжлийн байгууллагын үзлэг, оношилгоогоор Даланзадгад сумын 10 цэцэрлэгт хүмүүжиж буй 2 хүүхэд тутмын 1 нь амны хөндийн ямар нэг өвчлөл, асуудалтай байгаа нь амны хөндийн эрүүл мэндэд анхаарал хандуулах шаардлагатайг илэрхийлж байгаа бөгөөд иргэдийн дунд амны

хөндийн эрүүл ахуйн мэдлэг хангалтгүй, шүдээ зөв арчлах дадал хэвшил бүрэн төлөвшөөгүй байна гэсэн дүгнэлт гарсан.

- 2022 онд 2 үе шаттай “Сүүн шүд” оношилгоо, эмчилгээг Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж 10 цэцэрлэгийн 2308 хүүхдээс 78.2% буюу 1804 хүүхдийг хамруулахад 92% нь амны хөндийн өвчлөлтэй гарсан тул “Сүүн шүд” аяны 2-р шат болох эмчилгээний ажлыг хийж хэрэгжүүлсэн.
- Энэ аяны үр дүн, мөн эцэг эх, асран хамгаалагчид, багш нарын хүсэлтийн дагуу бага насны хүүхдүүдийн шүдийг эмчлэх хэрэгцээ шаардлагатай байгаа.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй шүдний эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллаж Даланзадгад сумын 2-5 дугаар ангийн хүүхдүүдийн шүдийг эмчлэх, амны хөндийн эрүүл мэндийн зөвлөгөө, сургалт явуулах.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй 5 шүдний эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай хамтран ажиллаж Даланзадгад сумын 1, 2, 3, 4, 5-р сургуулийн шүд авах заалттай 1317 хүүхдийн шүдийг эцэг эхийн зөвшөөрөлтэй авах, 1057 хүүхдийн шүдийг ломбодож эмчлэх ажил хийсэн. Эмчилгээ хийлгэсэн бага насны хүүхдүүдэд шүдээ хэрхэн зөв угаах, мөн амны хөндийн ариун цэврийг хэрхэн сайн хангах тухай зөвлөгөө мэдээлэл өгч сургалт хийсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Даланзадгад сумын 2-5-р ангийн 2374 хүүхэд шүдээ эмчлүүлж эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлсэн
- Хүүхдүүд амны хөндийн ариун цэвэр, шүдний арчилгааны тухай мэдлэг мэдээлэлтэй болсон
- Шүдээ эмчлүүлсэн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ шүдэнд илүү анхаарал хандуулдаг болж шүдний эмчилгээнд эерэг хандлага харуулж сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн.

## Сэтгэгдэл **Даланзадгад сумын 4-р сургуулийн 2а ангийн сурагч Ц.Хатанбуурал:**



*Найзууд аа, шүд эрүүл бол бие эрүүл. Шүдээ сайн угаацгаая.*

## 2. "ТУХТАЙ ДОТУУР БАЙР" ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **"ЭХЭН СУХАЙТ" ХХК** |
| ГЭРЭЭНИЙ ДҮН: | **20,000,000 төгрөг** |






### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн дотуур байр нь 1971 онд ашиглалтад орсон. Жил бүр 90-110 хүүхэд хүлээн авч 12-р ангийн 30-47 сурагчийг төгсгөдөг. Сургуулийн дотуур байранд тавилга, эд хогшил шинээр худалдан авах санхүүгийн эх үүсвэр бага байдаг бөгөөд одоогийн байдлаар хуучирч эвдрэл элэгдэл их гарсан байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн дотуур байранд байрладаг хүүхдүүдийн эрүүл аюулгүй, тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, тохижилт хийх.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 25 тасагт тус бүрд 90 см өргөн, 2 метр урттай 1 модон хувцасны шүүгээ нийлүүлж байрлуулах ажил хийнэ.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Даланзадгад сумын 1-р сургуулийн дотуур байранд байрлах 120 хүүхдийн ая тухтай сурч амьдрах орчин нөхцөл бүрдэнэ

- Дотуур байрны тохижилт хийснээр тус дотуур байранд байрлах хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамж нэмэгдэнэ
- Дотуур байрны багш, ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирна.

## Сэтгэгдэл Сурагч: Ширнэн

*Өмнөговь аймгийн улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн 12б ангийн сурагч Ширнэн би сургуулийнхаа дотуур байранд долоон жил амьдарч байна. Энэ хугацаанд төмөр локертой байдаг байсан. Төмөр локер нь хувцас багтаах багтаамж муугаас гадна заримдаа хаалга нь салж унах, гар зүсэж гэмтээх нь их байдаг байсан. Харин одоо шинэчилж тавьсан модон хувцасны шүүгээ маань бат бөх, багтаамж ихтэй, эдэлгээ сайтай санагдаж байна.*

## Сэтгэгдэл Сурагч: М.Анхзаяа

*Мэндбаатарын Анхзаяа би 1-р сургуулийн 12г ангид суралцдаг. Би 9 дүгээр ангиа төгсөөд энэ байранд амьдарч эхэлсэн бөгөөд одоо 3 дахь жилдээ амьдарч байна. Бидэнд өмнө нь байсан төмөр шүүгээ хаалга нь сайн хаагдахгүй, хувцас багтахгүй гэх мэт асуудлууд үүсдэг байсан. Харин энэ модон шүүгээ зай томтой байгаа учраас илүү тохилог орчин бүрдүүлж өгч байна. Амьдрах орчин илүү тохилог болгож өгсөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн ах эгч нартаа баярлалаа.*



# 3. "26-Р ЦЭЦЭРЛЭГ ДЭВСГЭРЖҮҮЛЭЛТ" ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **"ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН"**
ГҮЙЦЭТГЭГЧ: **"СЭРҮҮН ЦАЦАТ" ХХК**
ГЭРЭЭНИЙ ДҮН: **19,980,000 төгрөг**




## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 26-р цэцэрлэг нь 2016 онд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр баригдсан. Тус цэцэрлэг нь Даланзадгад сумын 2 багт харьяалагдах Хан-Уул, Баруун сайхан, Гурван сайхан хороолол, Зуслан, Төгөл Б гэсэн гудамжинд байрлах 314 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгодог. 26-р цэцэрлэгийн одоо байгаа дэвсгэр шаардлага хангахгүйгээс шалтгаалан хүүхдүүдийг доороос нь хайрч жиндүүлэх, тоосонцор их үүсэж байгаагаас цэцэрлэгийн дэвсгэрийг шинэчлэх шаардлагатай болсон.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн хүүхдүүдийг эрүүл аюулгүй орчин нөхцөлд сурч боловсрох боломж бүрдүүлэх, цэцэрлэгийн анги танхимыг зөөлөн дэвсгэрээр дэвсгэрлэсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн анги танхим нийт 720м2 талбайг зөөлөн дэвсгэрээр дэвсгэрлэх ажил хийгдэж хүлээлгэн өгсөн.

**ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн нийт 34 ажилчин, албан хаагч 314 хүүхдийн сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх таатай орчин нөхцөл бүрдсэн
- Тус цэцэрлэгт хамрагддаг 314 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамж нэмэгдсэн
- Цаашид цэвэр, тохилог орчин үйл ажиллагаа явуулах боломжтой болсон.

## Сэтгэгдэл **Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн Эрхлэгч Г.Мөнхтуул**



*Манай цэцэрлэг нь Даланзадгад сумын Баруун сайхан 1-р баг, Хан уулын 2-р багийн нийт 324 хүүхдийг хүлээн авч үйл ажиллагаа явуулж байна. 200 хүүхдийн хүчин чадалтай. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгө оруулалтаар манай цэцэрлэгийн 8-н бүлгийн унтлагын өрөөг чанар стандартын дагуу, өнгө үзэмж сайтай дэвсгэр нийлүүлж өглөө. 2016 оноос хойш дэвсгэрийн шинэчлэл огт хийгдээгүй, бетон шал дээр нимгэн дрож дэвссэний улмаас ангид тоосонцор үүсэж хүүхдийн эрүүл аюулгүй таатай орчин нөхцөл бүрдэхгүй, хүүхдүүд даарч хөрсний улмаас өвчлөл ханиад, томуу салахгүй хүндрэлтэй асуудлууд их гарч байсан. Ингээд хүүхдийн төлөө гэсэн сайхан хөрөнгө оруулалт хийж өгсөн Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хамт олон, Сумын засаг дарга, Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын хамт олон, гүйцэтгэгч "Сэрүүн цацат" ХХК-ий хамт олонд бяцхан хүүхэд багачууд, эцэг эх, хамт олныхоо өмнөөс баярласан талархсанаа илэрхийлж та бүгдийн ажилд гялалзсан сайхан амжилтыг хүсье.*

# 4. “GOBI-22” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **“САКУНДАЛА” ХХК**
ГЭРЭЭНИЙ ДҮН: **19,950,000 төгрөг**




## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Элсний волейболын спорт нь олимпын спортын төрөлд ордог ч манай улсад тэмцээн зохион байгуулдаггүйгээс шалтгаалан элсний волейбол тоглодог хүмүүс цөөхөн, бараг тоглодоггүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Олон улсад далай, эрэгтэй ойр хот суурингуудад “Beach party” буюу эргийн шоу их зохион байгуулагддагтай холбоотойгоор элсний спорт их хөгжиж аялал зугаалга, үзвэр үйлчилгээ олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг хамгийн том салбар болтлоо хөгжсөн.
- Өмнөговь аймгийн хувьд бусад аймгуудыг бодвол байгаль цаг уурын онцлог шинж чанарт тулгуурлан элсний спорт, волейболыг хөгжүүлэхэд тохиромжтой тул Даланзадгад сумын бренд спорт байдлаар хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Ингэснээр гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх, хүүхдүүдийг элсний волейболоор хичээллүүлж бие бялдрын хувьд өв тэгш хөгжүүлэх үр дүн гарна.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Элсний волейболыг Даланзадгад суманд хөгжүүлэх, хүүхэд залуусын чөлөөт цагаа үр бүтээлтэй, зөв боловсон өнгөрөөх газрын тоог нэмэгдүүлэх, олон улсын жишигт хүрэх волейболын талбайг байгуулах.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Элсний волейболын талбай бий болгоход шаардлагатай волейболын тор, талбайн шон, тоглоомын бөмбөг, талбайн зориулалтын шигшсэн сайр, нарийн элс, талбайн элс, шүүгчийн өндөрлөг нийлүүлнэ. Захиалагч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажил гүйцэтгэх гэрээ байгуулан санхүүжилтийн гуравласан гэрээ байгуулаад байна.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Монгол улсын волейболын спортын мастер Т.Доржнамжаа, Волейболын спортын 1-р зэрэгтэй тамирчин Т.Пүрэвдорж нар шинэ залуу тамирчин бэлтгэнэ.
- Элсний волейбол Даланзадгад суманд хөгжиж мэргэжлийн тамирчин бэлтгэгдэж гарах үндэс суурь бий болно.

# 2022 ОНД БАЯНДАЛАЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ЧӨЛӨӨТ БӨХИЙН ДЭВЖЭЭ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Д.ХҮРЭЛБААТАР** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **15,000,000 төгрөг** |






### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Бөхийн спорт нь хүч, оюун ухаан бяраараа тодорхой дүрэм, журмын дагуу эсрэг талаа унагаадаг хоёр хүний хооронд өрсөлддөг тэмцээн юм. Хүүхдийг бага балчир наснаас нь бөхийн ямар ч төрлөөр хичээллүүлэх нь тухайн спортдоо амжилт гаргах үндэс суурь нь тавигддаг ч сургалтын стандартад нийцсэн орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зориулалтын талбай, хувцас хэрэглэлээр хангах нь орхигдуулах боломжгүй хэрэгцээ, шаардлага юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай  сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон иргэдэд чөлөөт бөх болон бөхийн бусад төрлөөр хичээллэхэд нь зориулж стандартад нийцсэн орчин бүрдүүлэх.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын Ерөнхий боловсролын сургуульд Чөлөөт бөхийн дэвжээ нийлүүлж захиалагчид хүлээлгэн өгсөн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сургууль чөлөөт бөхийн стандартад нийцсэн дэвжээтэй болно.
- Улс, бүс, аймгийн хэмжээний тэмцээн зохион байгуулах боломжтой болно.
- Дасгалжуулагч багш илүү хөгжих боломж бүрдэнэ.





## Сэтгэгдэл

**Баяндалай сумын ЕБС-ийн Биеийн тамирын багш А.Батжаргал:**



*2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 72 ширхэг матрас, 12:12 харьцаатай дэвжээг хүлээн авсан. Дэвжээ ирснээр бөхийн секц дугуйлан явуулахад илүү хялбар болж улмаар секцэд хамрагдах хүүхдийн тоо ихсэж эмэгтэй хүүхдүүд секцэд хамрагдах болсон нь талархууштай байгаа. Бэртэл гэмтэл гарах нь эрс багасаж миний хувьд болон сурагчдын хувьд дэвжээтэй болсонд их ач холбогдол өгч сайхан байгаа. Хуучин 2 хивсэн дэвжээн дээр хүүхдүүдтэйгээ бэлтгэл сургуулилт хийдэг байсан бол одоо стандарт хангасан дэвжээн дээр бэлтгэл хийж байна. Дэвжээн дээр бэлтгэл хийснээр хүүхдүүд сандрахгүй, мэдрэмжтэй, ур чадвартай болж байна.*

## 2. “МУЗЕЙН ҮЗМЭР ДЭГЛЭХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Б.МӨНХ-УНДРАМ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **25,000,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2020 онд Баяндалай суманд 280 хүний суудалтай соёлын төвийн барилга шинээр ашиглалтад орсон бөгөөд тус онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжсэн “Соёлын төвийн дотор тохижилт” төслийн хүрээнд шинэ барилгын гадна дотор хаягжилт, дотор тохижилтыг хийж шаардлагатай тавилга, хэрэгслээр бүрэн хангасан. Уг соёлын төвд орон нутаг судлах музейн зориулалттай танхимтай боловч музейн стандарт шаардлагад нийцсэн үзмэрийн хорго байхгүй, танхимын дотоод засал, тохижилт дутмаг байсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай сумын иргэд, гадаад дотоодын жуулчдад сумын түүх соёлтой танилцах боломжийг бүрдүүлж, музейн үйл ажиллагааг өргөжүүлэхэд нь дэмжлэг болох.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Баяндалай сумын соёлын төвийн барилгад байрладаг орон нутаг судлах музейн зориулалттай 9м*9м танхимыг дараах 6 сэдвээр тохижуулсан. Үүнд:

1. Манай эриний өмнөх /Юрийн галав, чулуун зэвсэг/ үе
2. Говь Түшээ гүний хошууны үеийн Баяндалай сум
3. Сум үүсгэн байгуулагдсан түүх
4. Угсаатан зүйн хэсэг
5. Байгалийн хэсэг
6. Сумын албан байгууллагуудын танилцуулга.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сум орон нутгийн түүх, соёлын өвийг олон нийтэд сурталчлах таатай нөхцөл бүрдэнэ
- Гадаад дотоодын жуулчид, орон нутгийн 2100 хүн үр шимийг нь хүртэнэ.

## Сэтгэгдэл Баяндалай сумын Соёлын төвийн дарга С.Өнөрбаяр:



*Сумын орон нутаг судлах музей нь соёлын төвдөө байрладаг бөгөөд манай музей 53 ширхэг үзмэртэй. Мөн манай соёлын төвийн барилга 2020 онд ашиглалтад орсон учир музейн танхимаа тохижуулж амжаагүй байсан. Бидэнд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр Булган, Баян-Овоо сумдын орон нутаг судлах музейг тохижуулсан Мөнх-Ундрамын хийсэн ажил таалагдсан учир энэ хүнтэй хамтран энэ төслийг хэрэгжүүллээ. 2023 онд манай сумын үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой тохионо. Энэхүү 100 жилийн ойн өмнө орон нутаг судлах музейгээ сайхан тохижуулж авсандаа баяртай байна. Ашиглагч байгууллагын зүгээс төслийн гүйцэтгэлд сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлье.*

## 3. “МЯНГАН ТӨГӨЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **А.МӨНХТӨР**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **20,000,000 төгрөг**




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сум нь албан ёсны бүртгэлтэй 2100 хүн амтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон 3 багтай сум бөгөөд сүүлийн жилүүдэд сумын нийт нутгаар хур бороо бага орж ган зудын давтамж ойр ойрхон тохиож байна. Тус сумын Баян багийн 6 малчин өрх бэлчээрийнхээ дунд байрлалтай хуучин гүний худгийг түшиглэн малын тэжээлийн ургамал, хүнсний ногоо, мод тариалахаар санал нэгдэж төслийг санаачилсан бөгөөд тэдэнд эдийн засгийн дэмжлэг шаардлагатай болсон.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг хөнгөвчлөх, амьжиргааг нь дээшлүүлэхэд дэмжлэг болох.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын Баян багийн нутаг дахь гүний худгийг түшиглэн одоо мод тарьж эхлүүлсэн 100м*100м буюу 1 га талбайг хашиж усалгааны систем, нөөцийн сав, гүний худгаас ус соруулах мотпомп байрлуулна.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Баян багийн 6 өрхөд малын тэжээлийн ургамал, хүнсний ногоогоо өөрсдөө тарьж ургуулахад нь дэмжлэг болно.
- Цөлжилттэй тэмцэх эерэг нөлөө үзүүлнэ.
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг хөнгөвчлөх, амьжиргааг нь дээшлүүлэхэд дэмжлэг болно.
- 2023 онд үргэлжлэн хэрэгжинэ.

## 4. “ӨВЛИЙГ ӨНӨТЭЙ ДАВЪЯ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧ: **“ГУРВАН МӨНХ” ОНӨААТҮГ**
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **16,000,000 төгрөг**




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сумын төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн ШГ маркын 2 ширхэг тогоог 2018 онд ашиглалтад оруулсан. Гэвч говийн усны давсжилт болон нүүрсний чанарын илчлэг ихтэйн улмаас 2 тогоо эдэлгээний хугацаанаасаа өмнө цоорч галлагааны улирлын ид ачааллын үед шатаагүй нүүрс үнс баригч уруу унах, тогооноос ус алдах зэргээр өдөр бүр гагнуурын ажил хийгддэг байсан. Үүнээс шалтгаалан дулаан хангамжийн байгууллагын машинист, механик, гагнуурчин зэрэг ажилтнууд байнгын хүнд нөхцөлд ажиллаж сумын дулааны систем хөлдөх гацах эрсдэл өндөртэй байсан. Мөн “Гурван мөнх” ОНӨААТҮГ нь сумын дулаан хангамжаас гадна хог хаягдал, цэвэр, бохир усны үйлчилгээнүүдийг хариуцдаг бөгөөд энэ бүх ажилд шаардлагатай багаж хэрэгслийн дутагдал ихтэй байдаг.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай сумын аж ахуй, айл өрхийг дулааны найдвартай эх үүсвэрээр хангахад дэмжлэг болох.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын төвий төвлөрсөн дулаанаар хангадаг "Гурван мөнх" ОНӨААТҮГ-ын ШГ маркын 1,4МВТ хүчин чадалтай нэг галлагааны зууханд засвар шинэтгэл хийж шаардлагатай багаж хэрэгсэл худалдаж авсан.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэд, аж ахуй нэгж байгууллага тав тухтай орчинд амьдарч, ажиллах нөхцөл бүрдсэн.
- Осол аваарын эрсдэлийн хүчин зүйлийг бууруулсан.
- Байгууллагын ажилтнуудад ажиллах таатай орчин бүрдсэн.

## Сэтгэгдэл **Баяндалай сумын Гурван-Мөнх ОНӨААТҮГазрын механик А.Цогтсайхан:**



*"Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн хүрээнд нэг зуухны засварын ажил хийж байгууллагад чухал хэрэгцээтэй багаж хэрэгслийг худалдан авсан. "Өвлийг өнөтэй давъя" төсөл хэрэгжсэнээр бидний ажлын бүтээмж, найдвартай ажиллагаа сайжирч илүү үр бүтээлтэй ажиллаж байна.*

## 5. “СУМЫН ТӨВИЙН КАМЕРЖУУЛАЛТ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Д.МӨНХБАТ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **19,985,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сум нь Өмнөговь аймгийн баруун талын Ноён, Сэврэй, Гурвантэс сумд орох орон нутгийн төв засмал замын дагуу байршилтайгаас шалтгаалан орон нутгийн иргэд, уул уурхайн ажилчид, гадаад дотоодын аялагч гэх мэт зорчин өнгөрөх, буудаллах хүн амын хөдөлгөөн ихтэй сум юм. Үүнтэй уялдан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хүрээнд төслийг санаачилсан.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сумын төвийн замын хөдөлгөөний зөрчил, танхай, хулгай гэх мэт гэмт хэргээс үүдэлтэй зөрчил, осол, гэмтлээс урьдчилан сэргийлж, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын Цагдаагийн хэсэгт 6 ширхэг хяналтын камер, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлж, нийлүүлсэн барааг цагдаагийн хэсэг тодорхойлсон цэгүүдэд суурилуулж захиалагчид хүлээлгэн өгсөн.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сумын төвд гарч болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан гэмт хэргүүдийг илрүүлэхэд дэмжлэг болно.
- Иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаална.
- Төслийн үр шимийг Баяндалай сумын 691 өрхийн 2094 иргэн шууд хүртэнэ.

## Сэтгэгдэл Баяндалай сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Эрдэнэбат:



*Манай Баяндалай сумын төвд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-аас санхүүжүүлсэн сумын төвийг камержуулах ажлын хүрээнд цагдаагийн хэсэг дээр 6 ширхэг камер, хянах дэлгэц байршуулснаар бидний гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд маш их тус дэм болохоос гадна Баяндалай сумын төвд байгаа олон нийтийн газрууд болон иргэдийн өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, сумын төвөөр дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хянах боломжтой болсон зэрэг ард иргэдийн амар тайван амьдрах таатай орчин бий болсон. Хөтөлбөр хэрэгжсэнд сэтгэгдэл маш өндөр байна.*

# 6. “ХОС ХАЯГТАЙ БАЯНДАЛАЙ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **ИРГЭН С.ТӨГӨЛДӨРЖАВХЛАН** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **9,900,000 төгрөг** |




## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сум нь 1923 онд байгуулагдсан. Сүүлийн жилүүдэд тус сумын төвд цөөнгүй барилга байгууламжууд шинээр баригдаж байгаа бөгөөд сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байшин нь нэгдсэн зохион байгуулалттай хаягжилт байхгүйгээс эмнэлгийн болон галын аюулгүй байдлын түргэн тусламжийн дуудлага цаг хугацаандаа очиж тусламж үзүүлэх, бусад ажлын зохион байгуулалт хийх, гадны хүмүүс зорьсон газраа хаягаар эрж олох, гэмт хэргийн зөрчлийн мэдээлэл хүргэх, мэдээллийн мөрөөр ажиллах, эрэл хайгуул хийх гэх мэт маш олон үйл ажиллагаанд хүндрэл чирэгдэл гардаг. Иймд сумын төвийн нэгдсэн хаягжилтыг стандартын дагуу хийж эмх цэгц, зохион байгуулалтад оруулах шаардлага тулгарсан.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Баяндалай сумын төвийн нэгдсэн хаягжилтыг Монгол улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартын шаардлагад нийцүүлэн хийх.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын төвийн 200 өрхийн хашааны хаягийг кирилл болон монгол хос бичигтэйгээр хийж суурилуулна.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Сумын төвийн бүх айл өрх жигд хаягтай болж сумын өнгө үзэмж сайжирна.
- Кирилл болон монгол хос бичигтэй хаягжилт нь иргэдэд үндэсний бичиг үсгээ уншиж таних, хэрэглэх, өвлөн хадгалах гэх мэт олон эерэг үзүүлэлт гарна.

# 2022 ОНД МАНДАЛ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ГАМШИГ, ДАЙЧИЛГААНЫ БЭЛЭН БАЙДАЛ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ЭРХЭТ РАЙ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **37,600,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сумын ЗДТГ нь орон нутгийнхаа иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд юуны өмнө аливаа гамшиг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд өндөржүүлсэн болон онц байдал зарлахад бэлтгэгдсэн байх шаардлагатай байдаг.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Ард иргэдийг гамшиг, ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хохирол багатай даван туулах, гамшгийн болон цэрэг дайчилгааны бэлэн байдлыг хангахад дэмжлэг болгох зорилготой.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын ЗДТГ-т 263 ширхэг гамшиг, ослын үед шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас, хэрэгсэл нийлүүлсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болно.
- Гамшиг, ослын үед иргэдэд зар мэдээ түгээх, авах арга хэмжээний чиглэлийг шуурхай түгээж аюул ослыг хохирол багатай даван дуулахад дэмжлэг болно.
- Гамшиг, ослын үед голомтод ажиллах ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлнэ.

## Сэтгэгдэл Сумын ЗДТГ-н Нийгмийн бодлогын мэргэжилтэн Б.Нарантуяа:



*Энэхүү төсөл хэрэгжсэнээр аливаа гамшиг, эрсдэл, дайчилгаа зарлагдсан үед төрийн албан хаагчид бидний яаралтай холбоо харилцаа тогтоох, зарлан мэдээлэл хүргэх, суурин болон нүүдлийн хяналтын пост ажиллуулах нөхцөл бүрдэж, хувь хүний аранз, хувцас, анхны тусламжийн бэлэн байдал хангагдаж байгаад маш их баяртай байна. Орон нутгийнхаа ард иргэдийн амар тайван аюулгүй байдлыг хангаж, аливаа эрсдлийг бага хохиролтой даван туулах нь бидний зорилго байдаг. Орон нутгийн үйл ажиллагааг үргэлж дэмжиж байдаг "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-н хамт олондоо баярлалаа. Ажлын амжилт хүсье. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хянах боломжтой болсон бөгөөд ард иргэдийн амар тайван амьдрах таатай орчин бий болоход дэмжлэг болох үр дүнтэй хөтөлбөр хэрэгжсэнд сэтгэгдэл маш өндөр байна.*

## 2. “ЭКО СУМ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ИХ ГОВИЙН СҮЛД ЭРДЭНЭ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **45,500,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь сум орон нутгийнхаа иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчинд учруулж буй хог хаягдлын хор уршгийг багасгах, төв суурины өнгө үзэмжийг сайжруулах зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ хог хаягдлын шаардлагатай менежментийг сонгож хэрэгжүүлэх нь чухал юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Иргэдийн хог хаягдлын талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг хогийн саваар хангах.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын ЗДТГ-т сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд ширхэг 3 тасалгаатай гурван ширхэг ангилан ялгах хогийн сав байрлуулж, айл өрхүүдэд 250 ширхэг хогийн сав тараасан ба сумын ЗДТГ-т хоёрдогч түүхий эд преслэхэд шаардлагатай зарим хэрэгсэл нийлүүлсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болно.
- Иргэдийн хог хаягдлын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж хогоо ангилан ялгаж хаяхад суралцана.
- Ангилсан дахивруудыг үйлдвэрүүдэд нийлүүлснээр булшлагдах хог хаягдлын хэмжээг бууруулан байгаль орчинд зерэг нөлөө үзүүлнэ.
- Иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ дээшилнэ.
- Иргэд тав тухтай орчин нөхцөлд санал бодлоо илэрхийлэх, уулзалт ярилцлага хийх боломж бүрдсэн.
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

## Сэтгэгдэл "Өлзийт Хонгор хайрхан" ХХК-н захирал Г.Цэцгээ:



*Энэ төсөл хэрэгжсэнээр нийтийн эзэмшлийн талбай, байгууллагууд, дэлгүүрүүдийн гадна орчинд хог ангилан ялгаж хийх хогийн савтай болсноор хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлыг эмх цэгцтэй байлгахад маш их ач холбогдолтой ажил болсон. Мөн айл өрхүүдэд хогийн сав олгосноор айлууд хогоо ангилан ялгаж хийх боломж бүрдэж байна. Хогоо ангилан ялгаж сурах нь хогийг баялаг болгох эх үүсвэр юм шүү дээ. Байгаль орчноо хамтран хамгаалцгаая. Олон нийтэд үр ашгаа өгсөн олон сайхан төслийг дэмжиж санхүүжүүлдэг "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-н хамт олонд нутгийнхаа иргэдийн өмнөөс талархал илэрхийлж ажлын амжилт хүсье. Баярлалаа*

# 2022 ОНД СЭВРЭЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ЗӨВ БҮХЭН ЗӨВХӨН МАНАЙ ГЭР БҮЛЭЭС” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“АГЬТ ГОВЬ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **3,400,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монгол улсад явагдсан нийгмийн шилжилтийн үе болон дэлхийн дахины даярчлал, соёлын глобалчлал нь монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт ихээхэн өөрчлөлтийг авчирч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь гэр бүлийн тогтвортой бус байдал нэмэгдсэн, эцэг, эхчүүдийн үүрэг, хариуцлагын ойлголт муудсан , том хүн, хүүхэд ялгаагүй гэр бүлийн гишүүдтэйгээ харилцах, халамжлах хандлага суларсан зэрэг олон сөрөг талаар илэрч байна. Иймд сум орон нутгийн зүгээс иргэд, хүүхэд, залуучууддаа гэр бүлийг хэвийн харилцаатай тогтвортой авч явахад зайлшгүй шаардлагатай боловсролыг олгохын зэрэгцээ тэдний амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон өөрөөр хэлбэл хэрэгцээнд нь тулгуурласан гэр бүлийн боловсролыг олгох шаардлагатай байна.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Иргэдэд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж гэр бүлийн боловсролыг нь дээшлүүлэх, улмаар амьдралын чанарт нь эерэг нөлөө үзүүлэх.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын иргэдэд гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр 30 хоногийн хугацаатай сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлүүдийн гишүүдийг чадавхжуулах
- Хүүхэд, залуус, насанд хүрэгчид, өрхийн гишүүдийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлж тэдний амьдралын чанарыг сайжруулах
- Гэр бүлийн бат бөх, тогтвортой харилцааг бий болгоход дэмжлэг болох
- Залуучуудын амьдрах ухааныг хөгжүүлэх, нийгэмд хүлээх эрх үүрэг, хариуцлага оролцоог нэмэгдүүлэн, мэдлэг боловсролтой, зөв хандлагатай, зөв сэтгэлгээтэй иргэдийг төлөвшүүлэхэд дэмжлэг болно.

## Сэтгэгдэл **Сургуулийн нийгмийн ажилтан Б.Булганаа:**



*Сэврэй суманд зохион байгуулагдсан "Хүүхдийн төлөө үүрэг хүлээгчдийг чадавхжуулах сургалт"- д хамрагдсанаар маш их мэдээлэл олж авлаа. Энэ сургалтад сумын удирдлагууд, байгууллагын дарга нар, хамтарсан баг, хүүхдийн төлөө зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, байгууллагуудын эцэг эхийн зөвлөлүүдийн гишүүдийг хамруулснаар тухайн албан тушаалтан аль зөвлөлд ямар үүрэг гүйцэтгэж оролцох талаар мэдэж авлаа. Сүүлийн жилүүдэд уул уурхайтай холбоотой хөдөлгөөнт хүн ам нэмэгдсэн, мөн хараа хяналтгүй хүүхдийн тоо нэмэгдэж хүүхэдтэй холбоотой хэрэг зөрчил Өмнөговь аймгийн хэмжээнд их гарах болсон энэ талын тоон мэдээг сонсоод сэтгэл эмзэглэж суулаа. Хүүхдийн төлөө үүрэг хүлээгчдийн үүргийг хууль, дүрэм, журмын заалтуудаар нэг бүрчлэн гаргаж, танилцуулж байгаа нь маш үр дүнтэй байлаа.*

## 2. “ЛЕД ДЭЛГЭЦ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“МАНДАЛА ПРО АУДИО” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **79,233,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сум нь 600 гаруй өрх, 2030 иргэнтэй. 2022 онд Сэврэй сумын соёлын төвд төр, хувийн хэвшлийн хурал зөвлөгөөн, урлаг, соёлын тоглолт, уралдаан, тэмцээн зэрэг 83 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнээс харахад тус соёлын төв нь иргэд, үйлчлүүлэгчдэдээ зориулж арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг арвин туршлагатай харагдаж байна. Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулах бүрд хулдаасан баннер хэвлүүлдэг бөгөөд суманд энэ чиглэлийн хэвлэлийн газаргүй тул аймгийн төв цаашлаад Улаанбаатарт хэвлүүлэх ч шаардлага тулгардаг байна. Энэ нь эдийн засаг, цаг хугацааны хувьд хүндрэл учруулдгаас гадна урлагийн тоглолт, зарим арга хэмжээний үеэр дүрс, фон солих асуудлуудыг шийдэж чаддаггүй.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сумын хэмжээнд зохион байгуулдаг арга хэмжээнүүдийг дуу, дүрсний технологийн дэвшлийг ашиглан чанар, хүртээмжтэй зохион байгуулахад дэмжлэг болох.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын Соёлын төвд 5м*6м харьцаатай 30м2 сүүлийн үеийн P5 бүрэн өнгөт дэлгэц нийлүүлж, суурилуулсан.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Ёслол, хүндэтгэл, сургалт мэдээллийн бүхий л арга хэмжээг проектор дэлгэц хэрэглэхгүй явуулах боломж бүрдсэн
- Дуу дүрсний өндөр түвшинд соёлын үйлчилгээг явуулах боломжтой болсон.
- Байгууллагын өнгө үзэмж үйлчилгээ сайжирсан.
- Урлагийн тоглолтын чанар үйлчлүүлэгчдэд хүрэх хүртээмж сайжирна
- Иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ
- Хулдаасан хэвлэл хийлгэх нэг удаагийн зардлууд хэмнэнэ.

## Сэтгэгдэл Сэврэй сумын Соёлын төвийн дарга А.Тэрбиш:



*"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгө оруулалтаар соёлын төвдөө LED дэлгэцтэй болсондоо баяртай байна. Одоо соёлын төвдөө соёл, урлагийн болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад хүндрэлгүй болж байна. Бид өмнө нь арга хэмжээ зохион байгуулах бүрт хулдаасан хэвлэл хэвлүүлдэг байсан. Одоо энэ зардал хэмнэгдэхээс гадна арга хэмжээний үеэр хүссэн дүрс, бичлэгээ явуулах бүрэн боломжтой болсон зэрэг олон давуу талууд бий болсон.*

# 2022 ОНД БУЛГАН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **БУЛГАН СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧИД:

1. **Л.МЯДАГМАА**
2. **Г.ТҮВШИНЖАРГАЛ**
3. **Г.ЧУЛУУНЦЭЦЭГ**

3 БАГЦ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ НИЙТ ДҮН: **45,000,000 төгрөг**






### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган сумын иргэдэд зориулсан баяр ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тусгай байгууламжгүйгээс болж гэр бүл болох гэсэн залуу хосууд гэрлэлтийн ёслолын үйл ажиллагааг сумаасаа хол зохион байгуулах, сум орон нутагт уламжлалт баяр ёслол тэмдэглэх, шагнал гардуулах болон бусад хүндэтгэлийн үйл ажиллагааг зохистой байдлаар зохион байгуулж чадахгүй байгаа.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сум орон нутагт зохион байгуулах боломжтой баяр ёслолын болон хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах тусгай байгууламж, бүрэн тохижуулсан гэртэй болох.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

8 ханатай гэр нийлүүлж дотор нь тохижуулах сандал, ширээг бүрэн сийлбэрлүүлж байршуулсан. Дараах гэр, сандал ширээг нийлүүлсэн.

- Цуулбар уньтай, бургасан 8 ханатай, 2 давхар бүрээстэй, 4 ширхэг тооны араамтай, давхар хаалгатай гэр

- Бүрэн сийлбэрлүүлсэн 1.7 м урттай модон ширээ-4 ширхэг
- Бүрэн сийлбэрлүүлсэн түшлэгтэй том модон сандал-4 ширхэг
- Бүрэн сийлбэрлүүлсэн жижиг сандал-12 ширхэг

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булган сумын иргэд, аж ахуй нэгж байгууллагууд шаардлагатай үед ашиглаж болох ёслол хүндэтгэлийн өргөөтэй болсон
- Булган суманд гэрлэлтээ батлуулах, гэрлэлтийн ёслолын үйл ажиллагаа явуулах тохь тухтай өргөөтэй болж сумын залуу хосууд орон нутагтаа гэрлэх боломж бүрдсэн.

## Сэтгэгдэл 4-р багийн иргэн З.Баяржаргал:



*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” -ийн санхүүжилтээр Булган суманд ‘’Ёслол хүндэтгэлийн өргөө”төсөл амжилттай хэрэгжсэн. Энэхүү өргөө нь 8 ханатай гэр бөгөөд гадна талдаа өв уламжлал бүхий улаан халзан бүрээстэй. Гэрийн унь, хаалга, багана, ширээ, сандал бүгд иж бүрэн сийлбэртэй. 8 ханатай гэр учраас суманд ирсэн гадна дотны зочдыг хүлээн авах, нийтийн баяр ёслол тэмдэглэх, гэр бүл болох-хуримын ёслолыг хийх зэргээр ашиглах боломжтой юм. Бид цаашдаа энэхүү өргөөг түүхэн өв соёлыг харуулсан гэрлэх ёслолын өргөө болгохоор зорьж байна. Энэхүү өргөөндөө Булган сум байгуулагдсаны түүхт 70 жилийн ой, Монгол Улсын начин Бэгзийн Мижидсүрэнгийн начин цолонд хүндэтгэл үзүүлэх наадам, Монгол улсын харцага Ишийн Ламаажав агсны хүрэл хөшөөний нээлтэд зориулсан наадамд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдийг хүлээн авсан билээ.*

## 2. “ТҮҮХЭЭ МӨНХӨЛЬЕ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ: **БУЛГАН СУМЫН ЗДТГ**
САНХҮҮЖҮҮЛЭГЧ: **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**
ГҮЙЦЭТГЭГЧИД:

1. **Г.МЯДАГМАА**
2. **“УДАМ СОЁЛ” ХХК**

2 БАГЦ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ НИЙТ ДҮН: **30,000,000 төгрөг**




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Булган сумын 70 жилийн ойн баяр болж байгаатай уялдуулан сумын иргэд, айлчин гийчдэд танилцуулах боломжтой Булган сум үүсэн цагаас өнөөг хүртэлх бүх үеийн түүхийг бүрэн багтаасан ном товхимолтой болох хэрэгцээ шаардлага үүссэн билээ.
- Булган сумаас төрөн гарсан Хөнгөн атлетикийн нэрт тамирчин Ц.Бадамцэрэн, Номч мэргэн гавж Д.Жамбалдорж, Эм баригч, оточ бариач, домч Ж.Жанцан, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Б.Лувсан, Монгол улсын спортын мастер С.Сэнгэдорж гэх мэт үе үеийн баатрууд, ахмадууд, тамирчид гэх мэт алдар цуутай хүмүүсийг мөнхлөн алдаршуулах, сум орон нутгийн түүх соёлыг түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ танин мэдүүлэх хэрэгцээ байсныг ажил хэрэг болгох шаардлага үүссэн.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын уугуул, суугуул иргэдэд сумын түүх соёлыг сурталчлан танин мэдүүлэх, сумын бүх айл өрхүүдэд сумын түүхийн тухай ном хэвлүүлэн тараах, үе үеийн ахмадууд, хөдөлмөрийн алдартан гавьяатнууд, тамирчид, сэхээтнүүдийг алдаршуулах зорилготой.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Булган сумыг үүсгэн байгуулснаас хойш өнөөг хүртэлх түүхийг судалж сумынхаа хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм хүмүүсийн намтар, түүхийг нэгтгэн эмхэтгэж номын эх бэлтгэснээр А5 хэмжээтэй, 505 хуудастай 500 ширхэг ном хэвлүүлэн Булган сумын айл өрх, албан байгууллагуудад тараах ажил хийсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булган сумын иргэд сумын үүсэл хөгжлийн түүх болоод сумаасаа төрөн гарсан, мөн сумынхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүсийн тухай мэдээллийг баттай эх сурвалжаас авах боломжтой болсон
- Булган сумыг зорин ирэх зочид гийчдэд танилцуулга хийх, түүх соёлоо танин мэдүүлэхэд дөхөм болсон
- Булган сум үүсгэн байгуулагдсанаас хойших түүхийг багтаасан 500 ширхэг ном тарааж түүх соёл түгээн дэлгэрүүлэх ажилд үнэтэй хувь нэмэр оруулсан.

## Сэтгэгдэл **4-р багийн иргэн Б.Дамдинсүрэн:**



*Өмнөговь аймгийн Булган сум анх 1952 онд байгуулагдаж 2022 онд түүхт 70-н жилийнхээ ойг 07 дугаар сарын 24-26 өдрүүдэд тэмдэглэн өнгөрлүүллээ. Бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олондоо баярлалаа. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдэн хэвлэгдсэн 505 хуудастай 500 ширхэг номыг Булган сумаар овоглодог уугуул суугуул иргэддээ өргөн барилаа.*

# 3. “ӨРХИЙН ЭМИЙН САН” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **БУЛГАН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ТООРОЙН ГОВЬ” ХХК** |
| ГЭРЭЭНИЙ ДҮН: | **12,700,000 төгрөг** |




## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган суманд 360 малчин өрхийн 1051 иргэн сумын төвөөс алслагдсан газар амьдарч байна. Сүүлийн жилүүдэд COVID-19 цар тахал гарсан, мөн хур бороо муутайгаас шалтгаалан отор нүүдэл их хийж байгаа учраас яаралтай үед хэрэглэх эм, анхны тусламжийн хэрэгслийн хангамж гэрт байхгүй байх үе их байна. Тиймээс яаралтай тусламж авахад цаг алдах, гарын доор эмчийн жоргүйгээр олгох эм бэлдмэлээр шийдэх боломжтой асуудлуудыг шийдвэрлэж чадахгүйгээс эрүүл мэнд дордох асуудал их үүсэж байна.

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын малчин өрх бүрийг эмийн санжуулах, малчин иргэдийг эрүүл мэндийн болон эмийн анхан шатны тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай авдаг болгох.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 360 малчин өрхөд ариутгасан наалт, халууны шил, тамедины уусмал, шарх цэвэрлэх хөвөн, өвчин намдаах эм гэх мэт эмчийн жоргүйгээр авч болох эм бэлдмэл, анхны тусламжийн өрхийн эмийн сан өгсөн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Малчин өрхийн иргэд цаг алдалгүй эмийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг гэртээ авах боломжтой болно
- Эмнэлэг явах, эрүүл мэндийн үйлчилгээ авахаар дуудлага өгч цаг алдалгүй эрүүл мэндийн анхны тусламж малчин өрхүүд авдаг болно
- Малчин өрхийн иргэд эм бэлдмэл, анхны тусламжийн мэдлэг, мэдээлэлтэй болно

## Сэтгэгдэл 4-р багийн иргэн Д.Энхмөнх:



*Манай гэр бүл нь мал маллан амьдардаг ба одоо цаг үеийн байдлаас хамаарч отор нүүдэл хийж Дундговь Аймгийн Гурвансайхан сумын чулуутын өвөлжөө гэх газар оторлож байгаа билээ. Энэ үед Сум орон нутгийн удирдлагын санаачилснаар Говийн оюу төслийн хүрээнд малчин өрхөд эмийн анхан шатны багц тарааж иргэдэд дэм болж байгаа нь талархууштай ажил болсон. Иргэдээ дэмжин зөв ажил санаачилсан удирдлагууд болон Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хамт олонд баярласан талархсанаа илэрхийлье.*

# 2022 ОНД ЦОГТ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “ХҮНСНИЙ НОГООНЫ ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Б.ХҮҮХЭНДҮҮ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **11,945,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Одоогийн байдлаар Цогт-Овоо сумын хэмжээнд 50 өрх хүлэмжийн аж ахуй эрхэлж, 6 өрх төмс хүнсний ногоо тариалж байна. Цаашид Цогт-Овоо сумын иргэдийн хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг дэмжихийн тулд суманд байгаа 2.6 га талбай бүхий хүнсний ногооны тариалангийн талбайд ус хадгалах, нөөцлөх сав, мал, амьтнаас хамгаалах хашаа татах гэх мэт зохих бараа материал татах, тохижуулах шаардлагатай байгаа. Ингэж тохижуулснаар сумын иргэд сумандаа эрүүл, генийн өөрчлөлтгүй хүнсний ногоо тарьж ургуулах хүнсэндээ хэрэглэх, цаашлаад бусад аймаг, сумдын хүнсний ногооны хэрэгцээг хангах гэх мэт боломжууд нэмэгдэх юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Цогт-Овоо сумын нийт хүн амын дөчөөс доошгүй хувийг төмс, хүнсний ногоогоор хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг дэмжсэнээр өрхийн орлого нэмэгдүүлэх.

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүнсний ногооны тариалангийн талбайд шаардлагатай хүлэмжийн гялгар уут, хүлэмжийн нар бууруулагч, хавчаар, шаланк, нийлэг хальс түгжигч, даруулга уяа, хүлэмжийн гялгар нөхөгч скоч, гүний худгийн насос, цахилгааны утас, усалгааны хоолой гэх мэт хэрэгцээтэй бараа материал нийлүүлж талбайн гадна талаар 820 м урттай, 1 метрийн гүнтэй шуудуу татсан.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Хүнсний ногооны тариалангийн талбайн тог цахилгаан, тоног төхөөрөмжийн ажиллагаа сайжирсан
- Тариалалтын гарц нэмэгдэж ногоочдын орлого нэмэгдэх боломжтой болсон
- Хашаа, хамгаалалттай болгосноор мал амьтны хөлөөс тарьсан хүнсний ногоогоо илүү хамгаалдаг болсон

## Сэтгэгдэл Цогт-Овоо сумын иргэн М.Бүрэнбаяр:



*Цогт-Овоо сумын 10 хүлэмжид тариалан эрхлэгчдийг дэмжиж "Хүнсний ногооны тариалангийн талбайн тохижилт" төсөл хэрэгжсэн нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, ард иргэдийн чанартай хүнсний ногоогоор хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн, стандартад нийцсэн материаллаг баазыг бий болгож чадсан сайн төсөл болсон гэж үзэж байна. Нутгийн иргэдэд эрүүл хүнсээр хангагдах нөхцөлийг сайжруулж өгсөн Говийн оюу хөгжлийн дэмжих сангийн хамт олондоо маш их баярлалаа. Та бүхний цаашдын ажил хөдөлмөрт улам их амжилт хүсье.*

## 2. “УХААЛАГ ШИЙДЭЛ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ХӨЧҮҮН НОМТ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: | **69,800,000 төгрөг** |




### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогт-Овоо сумын соёлын төв 1962 онд байгуулагдсан бөгөөд суманд зохион байгуулагдаж байгаа соёл урлагийн бүхий л үйл ажиллагааг тус соёлын төвд зохион байгуулж сумын иргэд болон айлчлан ирсэн зочид төлөөлөгчдийг хүлээн авах, соён гэгээрүүлэх ажлыг хийж байна.
- Соёлын төвд одоо байгаа тоног төхөөрөмжөөр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад хүндрэл их үүсэж байна. Тиймээс одоо хэрэгтэй байгаа тайзны дэлгэц, бусад дагалдах тоног төхөөрөмжүүдийг нийлүүлснээр соёлын төвийн үйл ажиллагаагаа иргэдэд илүү хүрэх юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Цогт-Овоо сумын соёлын төвд зохион байгуулж байгаа үйл ажиллагааг олон нийтэд хүргэх чанартай тоног төхөөрөмж хэрэгсэл нийлүүлэх.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хөтөлбөрийн хүрээнд 24 м2 дотор дэлгэц дагалдах хэрэгслийн хамт, тэжээлийн блок, цахилгааны утас, дэлгэц тогтоох төмөр хийцэл, программ, Nova удирдлага нийлүүлэх ажил хийсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Соёлын төвөөр үйлчлүүлж буй хүмүүсийн сэтгэл ханамж дээшилсэн
- Соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан
- Жилд дунджаар үйлчлүүлдэг 5000 гаруй хүнд соёл урлагийн үйл ажиллагааг чанартай хүргэх боломж бүрдсэн

## Сэтгэгдэл Б.Цэрэнтунгалаг:



*Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Соёлын төвд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Ухаалаг шийдэл" төслийн хүрээнд 24 квадрат метр LED Дэлгэцийг, тоглуулагч дагалдах хэрэгслийн хамт хүлээн аваад байна. Орчин цагт урлагийн тайз засалд хэмнэлт болж, бид бүхний захиалсан үзүүлэлтийн дагуу "Ухаалаг шийдэл" дэлгэц шийдэгдсэнд баяртай байна.*

*Нэг арга хэмжээ зохион байгуулахдаа тайз дээр дэвсгэр болгон 4*6 м2 хулдаас хэвлүүлж байршуулахад 550.000 -650.000 төгрөг зарцуулдаг бөгөөд жилд хамгийн багадаа 5 тоглолт 12 үйл ажиллагаа зохион байгуулагдахад 10,000,000 төгрөгийн зардал гардаг. Энэ их зардлыг хэмнэх боломжтой болсон. Мөн тайзны өнгө үзэмж гэрэлтүүлэг сайжирсан гээд давуу талууд их боллоо. Ийм сайхан орчин нөхцөлийг бүрдүүлж, бидний ажлыг дэмжиж санхүүгийн дэмжлэг олгосон "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан"-ийн нийт ажилтан албан хаагчид, Цогт-Овоо сумын ЗДТГ-ын хамт олондоо баярласан талархсанаа илэрхийлж байна.*

# 2022 ОНД НОМГОН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “НОМГОН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ АВТОМАШИНААР ХАНГАХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **НОМГОН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Б.ДАЛАЙХҮҮ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **23,400,000 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сумын эрүүл мэндийн төв нь  сумын нийт хүн амд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэж ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.
- Эрүүл мэндийн төв нь мал аж ахуйн 5 баг, хилийн цэргийн 3 суман, сумын төвийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Сум нь нийт 2544 хүн амтай, үүнээс 0-16 насны хүүхэд 670, ахмад настан 305, хөдөлмөрийн насны 1519 иргэн болон сумангийн цэргүүд байна. Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын санхүүждэг болсонтой холбоотойгоор гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ зэргийг иргэдэд үзүүлж эхэлсэн ба эдгээр үйлчилгээг үзүүлэхэд ээлжийн ажилтан сувилагч нарт бага оврын үйлчилгээний автомашин шаардлагатай байна.

- Мөн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийг хамруулж эмчлэн эрүүлжүүлэх тусламж үйлчилгээ үзүүлэхэд эмч мэргэжилтнүүд иргэдэд хүрч үйлчлэхэд эрүүл мэндийн төвийн гэр автомашин хүрэлцээ дутмаг, шаардлага хангахгүй байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Эрүүл мэндийн төвийг бага оврын суудлын автомашинаар хангаснаар гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтын түвшин нэмэгдэж, үйлчилгээний хүртээмж сайжирна.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Номгон сумын ЭМТ-д Тоёота пробокс маркийн автомашин нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хүнд хэвтрийн өвчтөнийг гэрээр асарч сувилах, гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, нярайн эргэлт үзлэг, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтын түвшин нэмэгдэх, дуудлага хооронд иргэдийг удаан хүлээлгэх байдал багасаж товлосон цагтаа хүлээгдэлгүй тусламж үйлчилгээнд хамрагдах боломжтой болно. Элэг бүтэн Монгол, Элэг бүтэн Өмнөговь, сүрьеэгүй Монгол зэрэг хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн сайжирч, сумын төвийн дуудлагын хүлээлт багасаж шинжилгээнд хамрагдаж байгаа иргэд түргэн шуурхай хамрагдаж, дараагийн шатлалын тусламж үйлчилгээг цаг алдалгүй авч иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.

## Сэтгэгдэл **Номгон сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Х.Мядагмаа:**



*Номгон сумын эрүүл мэндийн төвд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн Toyata probox маркийн 6460ӨМЭ улсын дугаартай автомашин нь эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлж байгаа түргэн тусламжийн дуудлага, гэрийн эргэлт, нярай хүүхдийн эргэлт, өдрийн эмчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, жирэмсэн эхчүүд, нярай хүүхдийг хамруулахад чухал ач холбогдолтой байна.*

*Эрүүл мэндийн төвийн дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхэд автомашин нь бүрэн тохирч шаардлага хангаж байгаа бөгөөд эрүүл мэндийн төвийн хамт олон, иргэд олон нийт сэтгэл түйлын өндөр байгаа үхний цаашдын ажил хөдөлмөрт улам их амжилт хүсье.*

## Сэтгэгдэл Номгон сумын оршин суугч Ж.Мааваг:



*Гэр хорооллын айл өрхийн гэрийн дуудлага болон эмчилгээ хийх, эм тариа хийх зэрэг сандарсан үед түргэн шуурхай үйлчлэхэд чухал хэрэгтэй унаатай болсонд талархалтай байна.*

## Сэтгэгдэл Номгон сумын оршин суугч Ш.Нарантуяа:



*Эрүүл мэндийн төв нь өмнө нь сумын төв дээрээ унаа байхгүй гэрээр асаргаа сувилгаа, эмчилгээ хийлгэхэд хүндрэлтэй байдаг байсан одоо бол сайхан машинтай болсон эрүүл мэндийн үйлчилгээний чанар сайжирсан.*

## Сэтгэгдэл Номгон сумын оршин суугч Б.Бат-Эрдэнэ:



*Эрүүл мэндийн төв нь суудлын автомашинтай болсноор гэр хорооллын өндөр настнуудад асаргаа сувилгаа хийх, нярай хүүхэдтэй айл өрхөө гэрээр очиж эрүүл мэндийн үзлэг заавар зөвлөмж өгөх зэрэг үйлчилгээ үзүүлж байгаа талархалтай байна. Баярлалаа*

## 2. “ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АГААРЫН ДЭД СТАНЦ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **НОМГОН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **“ГОВЬ БАЯН ЭНЕРГИ” ХХК** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **41,787,136 төгрөг** |




### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сумын төвөөс баруун хойш 1.2 км зайд тус бүр 5 га 2 хэсэг талбайд ногоон зурвас байгуулахаар мод тарьсан. Уг модны талбайг услах цахилгаан худаг гаргасан боловч сумын төвөөс зайтай учир цахилгааны шугам байхгүй, худаг ажиллуулах боломжгүй учир зөөврийн усаар ногоон зурвасын модыг усалж байна. Тиймээс модны талбайг цахилгаанаар хангах цахилгаан дамжуулах агаарын шугам тавих хэрэгцээ шаардлага үүсээд байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Модны талбайг цахилгаанаар хангах цахилгааны шугам татна.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Даланзадгад-Номгон чиглэлийн төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас мод тарьсан талбай хүртэл 50 метр урт 15кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж 50кВа чадалтай агаарын дэд станц байгуулсан. Уг дэд станцаас мод тарьсан хоёр талбай руу 128м, 25м урт 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг тус тус татаж худгийн моторыг холбосон.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хэрэглэгчийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах нөхцөл бүрдсэн.
- Модны талбай дахь цахилгаан худгийг ашиглах дэд бүтэцтэй болсон
- Талбайд тарьсан модын найдвартай услах, цаашид мод нэмж тарих боломжтой болсон.

# 3. “ХАЙРХАН ХОРООЛЛЫН ГЭРЭЛТҮҮЛГЭЭР ХАНГАХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **НОМГОН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Б.ЭРДЭНЭБАЯР** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **14,705,000 төгрөг** |




## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сум нь хүн ам олонтой, сумынхаа төвд 230 орчин өрхтэй, түүний 80 орчим өрх нь Хайрхан хороололд амьдардаг болно. Гэрийн тэжээвэр муур, нохой олонтой хороолол бөгөөд орой үдэш айл өрхүүд нохойгоо сул байлгадгаас болж иргэдийн амар амгалан байдал алдагдах, хичээл сургуулиа тарсан хүүхдүүд, иргэд нохойнд туулгах, уруулах зэрэг эрсдэл их байдаг учраас гарч болох эрсдэлээс сэргийлэх үүднээс гэрэлтүүлэг байрлуулах шаардлага бий болоод байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын төвийн гэр хороолол гэрэлтүүлэг муу тул айл хоорондын гудамж талбайг гэрэлтүүлж, иргэдийн аюулгүй байдлыг хангаж, жишиг хорооллыг бий болгох.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Номгон сумын хайрхан хороололд нарны энергиэр цэнэглэгддэг 20 ширхэг гэрэл байрлуулсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Гэр хорооллын айлуудын 2 өрхийн дунд нэг гэрэл байрлуулж, гудамж талбайг нарны энергиэр гэрэлтүүлэх, тохижилт үйлчилгээг хийнэ. Байр хорооллын тохижилтыг сайжруулж, өнгө үзэмжийг нэмэгдүүлнэ.

## Сэтгэгдэл **Хайрхан хорооллын 2-2 тоотод оршин суугч Ц.Мөнхцэцэг:**



*Гэрэл тавьсан гоё гэрэлтэй байна. Гудам гэрэлтэй сайхан байна. Гэрэл тавьсан хүнд баярлалаа.*

## Сэтгэгдэл **Хайрхан хорооллын 3-9 тоотод оршин суугч Б.Нямцэрэн:**



*Гудамж гэрэлтүүлэгтэй болсноор өглөө оройдоо гэрэлтэй сэтгэлд нийцсэн маш тааламжтай байгаа. Та бүхэнд баярлалаа.*

## Сэтгэгдэл **Хайрхан хорооллын 5-4 тоотод оршин суугч Ж.Түмэнбаяр:**



*Манай гудамжинд гэрэлтүүлэг тавьсан явдалд талархалтай байна. Шөнө орой үдэш хүүхэд хөгшид гарч орох бие засахад амар гэрэлтэй сайхан байдагт баяртай байна. Цаашид хашаа болгонд ийм гэрэлтэй болбол илүү ашигтай юм байна.*

# 2022 ОНД ХҮРМЭН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

## 1. “МОДНЫ ТАЛБАЙН ХАШАА БАРИХ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ХҮРМЭН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Т.БАЯРЦЭЦЭГ** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **10,000,000 төгрөг** |






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Суманд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлын сурталчлан түгээж, бүх нийтийн үйлс болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хөрсний гэмтэл, цөлжилт түргэсэж байгаа энэ үед цөлжилтийг бууруулах хамгийн чухал арга нь мод тарих, тарьсан модыг хашаажуулан хамгаалах юм. Ойн зурвасын тусламжтай хөрсийг нягтаршуулах, хөрсний элэгдлийг багасгах зэргээр цөлийг тэлэхээс сэргийлж суурин газрын болон ногоон байгууламжийг бие даасан салбар болгон хөгжүүлэхийг чиглэл болгож байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн дагуу "Тэрбум мод" тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хөгжил цэцэглэлтийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, говь нутгийн цөлжилтийг бууруулахад хувь нэмэр оруулан мод тарих үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор ойжуулах талбайг хашаажуулна.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Шинээр ойн зурвас байгуулах, талбайн хамгаалалтын хашаа барих ажлыг гүйцэтгэж нийт 3 га газрыг хашаажуулсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Талбай хаших нь зулзаган моддыг мал, амьтны үйлчлэлээр үүсэх аливаа гэмтлээс хамгаалж өгнө.
- Талбайг хашиж хамгаалах нь удаан хугацаанд үйлчлэх хамгаалалтын арга хэрэгсэл бөгөөд байгалийн нөхөн сэргээлтэд богино хугацаанд сайн үр нөлөөтэй ба модны зурвас дахь өвс ногоо зэрэг дагалдах ургамал сайн хөгждөг зэрэг давуу талтай
- Цөлжилтийн эсрэг экологийн тэнцвэрт байдлыг хадгална.
- Байгууллага аж ахуй нэгж, иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Сумын ногоон байгууламж нэмэгдэн орон нутгийн өнгө үзэмж сайжирна.

## 2. “СОЁЛЫН ТӨВИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ХҮРМЭН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Ө.ХАНДСҮРЭН** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **94,099,900 төгрөг** |






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Хүрмэн сум нь 1700 гаруй хүн амтай. Үүнээс сумын төвд 500 орчим хүн оршин суудаг. 2008 онд шинэ соёлын төвийн байр ашиглалтад орсон бөгөөд сум орон нутгийн ард иргэдэд урлаг соёл, спортын үйл ажиллагааг хүргэж байна. Өнөөгийн байдлаар урлаг соёл, спортын олон төрөлт үйл ажиллагааг тогтмол явуулдаг боловч, урлагийн ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулахад сүүлийн үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж дутмаг, техник хэрэгсэл хүчин чадал муутай байдаг нь урлаг соёлын үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэлтэй байдаг. 2023 онд Хүрмэн сум байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан техник, тоног төхөөрөмж, тохижилтын ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сум орон нутгийн ард иргэдэд урлагийн олон төрөлт үйл ажиллагааг тогтмол, чанартай зохион байгуулах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүрмэн сумын соёлын төвд гэрэлтүүлэг, өсгөгч, дууны процессор, утасгүй микрофон, хөшиг, явуулын тайз, ширээ, сандал, компьютер, зургийн хэрэгсэл, үзмэрийн шилэн хорго зэрэг 17 нэр төрлийн 60 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Урлагийн томоохон арга хэмжээ зохион байгуулах, үйлчлүүлэгчийн ая тух, үзмэрийн аюулгүй хадгалалт хамгаалалтын боломж бололцоо нөөц бүрдэж, сум орон нутгийн иргэдийн идэвх оролцоо сайжирч үйл ажиллагаа явуулахад чанарын өндөр түвшинд зохион байгуулагдана.

- Урлаг уран сайхны арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах
- Урлаг соёлын явуулын үйлчилгээг сүүлийн үеийн тайз, гэрэлтүүлэг, техник, тоног төхөөрөмжөөр ард иргэдэд үйлчлэх
- Хүчин чадал сайтай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах
- Үйлчлүүлэгчийн ая тухтай нөхцөл бүрдүүлэх.




## Сэтгэгдэл Соёлын төвийн Эрхлэгч Д.Мөнхзул:



*Говийн оюу хөгжлийн сантай манай байгууллага 2 дахь удаагаа хамтран ажиллаж байна. Энэ удаад манай байгууллага 94,099,900 төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл дэмжигдэж орон нутаг судлах танхим, номын сан, хөгжим техник хэрэгсэл нийлүүлэгдэж байгаа бүхий л зүйлд сэтгэл хангалуун сайхан байна. Ирэх 2023 онд сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой болно. Энэхүү ажил маань ойг угтсан их ажлын нэгээхэн том хөрөнгө оруулалт болсон. Төслийг санхүүжүүлэгч "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олонд байгууллагынхаа ажилчдын өмнөөс баярлаж талархаж байгаагаа илэрхийлж байна.*

## Сэтгэгдэл Соёлын төвийн хөгжмийн багш А.Баяр-Эрдэнэ:



*"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн санхүүжилтээр манай байгууллагад нийлүүлэгдсэн хөгжим техник хэрэгсэл надад маш таалагдаж байгаа ажиллах эрч хүч, урамтай сайхан байна. Ийм сайхан хүчирхэг техник хэрэгсэл дээр ажиллах мөрөөдөл минь өнөөдөр биелж байгаа явдал төслийг санхүүжүүлэгч "Говийн оюу хөгжлийг дэмжих сан", байгууллагын удирдлага, дэмжиж ажилласан сумын ажлын хэсэг гээд бүхий л байгууллага, хүмүүстээ баярлаж талархаж байгаагаа энэ дашрамд илэрхийлж байна.*

## Сэтгэгдэл Соёлын төвийн номын санч Б.Цэвэлмаа:



*Номын сангийн стандартад нийцсэн сандал ширээ нийлүүлэгдэж ард иргэд, бяцхан уншигч хүүхэд багачуудын ая тухайтай орчин бүрдүүлэн ажиллаж байгаа билээ. Орчин үеийн үзүүлэлт сайтай компьютер тоног төхөөрөмжтэй болсон явдал нь миний хувьд цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрд хурдан шуурхай уншигч ард иргэдэд хүргэх, мэдээллээр хангах боломж бүрдэж байна. Ингээд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн хамт олонд хамт олныхоо өмнөөс ажлын өндөр амжилт хүсэж шинэ оны мэнд хүргэе.*

## Сэтгэгдэл Ард иргэдийн төлөөлөл Н.Галтаа:



*Сумын нүүр царай болж ажилладаг Соёл урлагийн байгууллага маань ийм сайхан тоног төхөөрөмжтэй болсон явдал иргэд бидэнд үнэхээр сайхан байна. Манай сумын соёл урлагийн байгууллагын хөгжим техникийн хувьд их л хуучирсан үйл ажиллагаа явуулахад маш хэцүү байдаг байлаа. Өнөөдөр сумын төв шинэ жилийн тоглолт болж үнэхээр эрч хүчтэй цоглог золбоолог маш гоё тоглолт боллоо. Хөгжим техник хэрэгслийн дуугаралт, тайз чимэглэл гэрэл гэрэлтүүлэг гээд үнэхээр гоё байна. Соёлын төвийнхөө хамт олонд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.*

## 3. “ХАМГААЛАГДСАН ХҮҮХЭД ХӨГЖДӨГ” ТӨСӨЛ

| | |
|---|---|
| ЗАХИАЛАГЧ: | **ХҮРМЭН СУМЫН ЗДТГ** |
| САНХҮҮЖҮҮЛЭГЧ: | **“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”** |
| ГҮЙЦЭТГЭГЧ: | **Т.ЦЭЦЭГДАРИНАА** |
| ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: | **22,563,600 төгрөг** |






### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:



- Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх зорилгоор суурь боловсрол эзэмшүүлэх үйлчилгээг 137 хүүхдэд хүргэж байна.
- Анхлан суралцагсдын эцэг эхийн 64% нь хүүхдийнхээ сургуулийн орчинд дасах, сурах, хөгжих, бусадтай харилцаж байгааг харах хүсэлтэй байх, үе тэнгийн дээрэлхэл, гадуурхал сургуулийн орчинд 74% нь үйлдэгддэг гэсэн дүгнэлт нь сургуулийн орчныг аюулгүй байдлыг хангах, сурах, хөгжих таатай орчин бүрдүүлэхэд хяналтын камер шаардлагатайг илэрхийлж байна.
